МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗАР







# МОНГОЛЫН ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2002-2003





УЛААНБААТАР ХОТ
2004 ОН

Үндэсний Статистикийн Газар

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага

# МОНГОЛЫН ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

## 2002-2003

Улаанбаатар хот 2004 он

Санал хүсэлт байвал доорхи хаягаар холбоо барина уу.
Энэхүү тайлан нь англи хэл дээр хэвлэгдсэн болно.

***Хаяг:***
Засгийн Газрын III байр
Сүхбаатар дүүрэг
Бага тойруу 44
Улаанбаатар, Монгол Улс
И-мэйл: nso@magicnet.com
Вэб хуудас: http://www.nso.com
Факс: 976-11-324518
Утас: 976-11-326414

# АГУУЛГА


**ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ** v
**ӨМНӨХ ҮГ** ix
**ТАЛАРХАЛ** x
**Товчилсон үгийн жагсаалт** xi
**Монгол Улсын газрын зураг, бүс нутгаар** xii
**Бүлэг 1. ЕРӨНХИЙ ТОЙМ** 1

**Бүлэг 2. УДИРТГАЛ** 13
2.1 Танилцуулга 14
2.2 Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөр 16
2.3 Судалгааны зорилт 17
2.4 Тайлангийн агуулга, бүтэц 19

**Бүлэг 3. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ, ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ** 21
3.1 Удиртгал 22
3.2 Судалгааны хамрах хүрээ 22
3.3 Тооцооны үе шат 23
3.3.1 Түүврийн жин 23
3.3.2 Өрхийн тоо мэдээллийг ашиглан тооцоо хийх 24
3.3.3 Вариаци болон стандарт алдааны тооцоо 25
3.4 Судалгааны бэлтгэл үе шат 26
3.4.1 Асуулга 27
3.4.2 Ахлагч, тоологч нарын сургалт 27
3.4.3 Тоо мэдээ цуглуулах, хяналт тавих 27
3.4.4 Сурталчилгааны арга хэмжээ 27
3.4.5 Мэдээлэл боловсруулалт 28
3.5 Түүврийн жин, стандарт алдаа 28
3.6 Ойлголт, тодорхойлолт 29

**Бүлэг 4. ӨРХИЙН ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД** 33
4.1 Удиртгал 34
4.2 Хүн ам зүйн үзүүлэлтүүд 34
4.2.1 Хүн амын байршил 34
4.2.2 Хүн амын нас, хүйсийн бүтэц 36
4.3 Өрхийн бүтэц 37
4.3.1 Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх 38
4.4 Боловсролын түвшин, сургуульд хамрагдалт 39
4.4.1 Боловсролын түвшин 39
4.4.2 Сургуульд хамрагдалт 39
4.4.3 Бичиг үсгийн мэдлэг 41

**Бүлэг 5. ХҮҮХДИЙН ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД** 43
5.1 Удиртгал 44
5.2 5-17 насны хүүхдүүдийн тоо 44
5.3 5-17 насны хүүхдүүдийн боловсролын түвшин 45
5.4 5-17 насны хүүхдийн сургуульд хамрагдалт, эдийн засгийн идэвхи 47
5.5 Өрхөөс гадуур амьдарч буй хүүхдүүд 54
5.6 Сургуульд суралцаагүй шалтгаан 54

**Бүлэг 6. АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР** 59
6.1 Удиртгал 60
6.2 Хүүхдийн эдийн засгийн идэвхийн байдал 60
6.3 Ажил эрхэлж буй хүүхдүүдийн тоо, тухайн үеийн идэвхээр 61

6.4 Ажил эрхэлж буй хүүхдүүдийн боловсролын түвшин 69
6.5 Сургууль, боловсролоос гадуурх үйл ажиллагаанд зарцуулсан цаг 72
6.6 Нэмэгдэл ажил хайсан хүүхдүүд 74
6.7 Хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа 75
6.7.1 Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар 76
6.7.2 Ажил эрхэлж буй хүүхдүүдийн ажил эрхлэлтийн байдал 85
6.7.3 Ажил эрхэлж буй хүүхдүүд, ажил мэргэжлийн ангиллаар 85
6.7.4 Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдүүдийн сарын орлого 86
6.8 Эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд 86

**Бүлэг 7. ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨР, ТҮҮНИЙГ ЭРХЛЭХ БОЛСОН ШАЛТГААН 93**

7.1 Удиртгал 94
7.2 Хүүхдийн хөдөлмөрийн тооцоо 94
7.3 Өрхөөс гадуур эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгаан 97
7.3.1 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгаан 97
7.3.2 Эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгаан 98
7.4 Өрхөөс гадуур ажил хийж эхэлсэн нас 106
7.5 Хүүхдийн ажлын байр 109
7.5.1 Ажлын байрны байршил 109
7.5.2 Ажлын байран дээрх хяналт, удирдлага 110
7.5.3 Ажлын байрны нөхцлийн талаарх үнэлгээ 110
7.5.4 Ажлын байран дээрх дарамт 110
7.5.5 Ажлын байран дээрх хөдөлмөр хамгааллын багаж, хэрэгслүүд 110
7.5.6 Шөнө оройн цагаар ажилласан хугацаа 110
7.5.7 Ажлаасаа болж өвдөж, гэмтсэн байдал 117
7.6 Ажил эрхэлж буй хүүхдүүдийн талаарх нэмэлт үзүүлэлтүүд 117
7.6.1 Орлогын зарцуулалт 117
7.6.2 Хүүхэд ажиллахаа боливол өөрт нь болон өрхөд нь үзүүлэх нөлөө 117
7.6.3 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлснээс болж өвдөж, гэмтсэн хүүхдүүд 117
7.7 Чөлөөт цаг 118

**Бүлэг 8. ХҮҮХДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ, УЛИРАЛ БОЛОН БҮС НУТГААР 125**

8.1 Удиртгал 126
8.2 Хүүхдийн ажил эрхлэлт, бүс нутгаар 126
8.2.1 Хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин, бүс нутгаар 126
8.2.2 Ажил эрхэлж буй хүүхдүүдийн тоо, бүс нутгаар 128
8.3 Хүүхдийн ажил эрхлэлт, улирлаар 130
8.4 Ажил эрхэлж буй хүүхдүүд, хот, хөдөөгөөр 131
8.4.1 Хот, хөдөөд ажил эрхэлж буй хүүхдүүд, улирлаар 131
8.4.2 Хот, хөдөөд ажил эрхэлж буй хүүхдүүд, бүс нутгаар 132

**Бүлэг 9. ДҮГНЭЛТ 137**

9.1 Нэгдсэн дүгнэлт 138
9.2 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд 138
9.3 Хүүхдийн эдийн засгийн бус үйл ажиллагаа 139
9.4 Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, бүс нутгаар 139
9.5 Дүгнэлт, бодлогын зөвлөмж 141
9.5.1 2002-2003 оны МХХС-ны дүн 141
9.5.2 2002-2003 оны МХХС-ны сул тал 141
9.5.3 Хүүхдийн хөдөлмөрийг устгахад чиглэсэн бодлогын зөвлөмж 141

**Хавсралт 1. Асуулгын хуудас 145**
**Хавсралт 2. Судалгаанд оролцогчдын нэрс 159**

# ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ


| | | |
|---|---|---|
| Хүснэгт 3.1 | Бүс нутагт ногдох түүврийн хэмжээ | 23 |
| Хүснэгт 3.2 | Судалгаанд хамрагдсан тооллогын нэгж болон өрх, бүсээр | 23 |
| Хүснэгт 3.3 | МХХС-ны зарим үзүүлэлтүүдийн стандарт алдааны тооцоо | 28 |
| Хүснэгт 4.1 | Өрх, хүн амын тоо, байршил, бүсээр | 35 |
| Хүснэгт 4.2 | 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур байгаа гишүүдтэй өрхийн тоо, хот, хөдөө, бүсээр | 35 |
| Хүснэгт 4.3 | Өрх, хүн амын тоо, хот, хөдөө, бүсээр | 36 |
| Хүснэгт 4.4 | Хүн амын нас, хүйсийн бүтэц, хүйсийн харьцаа | 37 |
| Хүснэгт 4.5 | Өрхийн дунд эзлэх хувь, ам бүлийн тоо, хот, хөдөө, бүсээр | 37 |
| Хүснэгт 4.6 | Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь, ам бүлийн тоогоор | 38 |
| Хүснэгт 4.7 | Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн бүтэц, ам бүлийн тоогоор | 38 |
| Хүснэгт 4.8 | 15, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хүйс, байршил, дунд эзлэх хувиар | 39 |
| Хүснэгт 4.9 | 7-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин, хот, хөдөө, хүйсээр | 40 |
| Хүснэгт 4.10 | Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин, хот, хөдөө, бүсээр | 41 |
| Хүснэгт 4.11 | Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин, насны бүлэг, хот, хөдөөгөөр | 41 |
| Хүснэгт 5.1 | 5-17 настай хүүхдийн тоо, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр | 44 |
| Хүснэгт 5.1а | 5-17 насны хүүхдүүдийн, нас, хүйсийн бүтэц, хот, хөдөөгөөр | 44 |
| Хүснэгт 5.1б | 5-17 насны хүүхдүүд, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, дунд эзлэх хувиар | 45 |
| Хүснэгт 5.2 | Судалгаагаар тооцсон хүүхдийн тоо болон 2003 оны хүн амын тоотой харьцуулсан нь, насны бүлгээр | 45 |
| Хүснэгт 5.3 | 5-17 насны хүүхдийн тоо, боловсролын түвшин, насны бүлэг, хүйсээр | 46 |
| Хүснэгт 5.3а | 5-17 насны хүүхдийн эзлэх хувь боловсролын түвшин, насны бүлэг, хүйсээр | 46 |
| Хүснэгт 5.3б | 5-17 насны хүүхдийн эзлэх хувь, боловсролын түвшин, насны бүлэг, хүйсээр | 47 |
| Хүснэгт 5.4 | Сүүлийн 7 хоногт сургуульд сурсан, эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр | 49 |
| Хүснэгт 5.4а | Сүүлийн 7 хоногт сургуульд суралцсан, ажил эрхэлсэн, гэрийн ажилд оролцсон 5-17 насны хүүхдүүд, насны бүлэг, хүйсээр | 50 |
| Хүснэгт 5.4б | Сүүлийн 7 хоногт сургуульд суралцсан, ажил эрхэлсэн, гэрийн ажилд оролцсон 5-17 насны хүүхдүүд, насны бүлэг, хүйсээр, хувиар | 51 |
| Хүснэгт 5.5 | Сүүлийн 7 хоногт сургуульд суралцсан, ажил эрхэлсэн, гэрийн ажилд оролцсон 5-17 насны хүүхдийн тоо, өрхийн ам бүлийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр | 52 |
| Хүснэгт 5.5а | Сүүлийн 7 хоногт сургуульд суралцсан, ажил эрхэлсэн, гэрийн ажилд оролцсон 5-17 насны хүүхэд, өрхийн ам бүлийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр (эзлэх хувь) | 53 |
| Хүснэгт 5.6 | 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч буй 5-17 насны хүүхдийн тоо | 54 |
| Хүснэгт 5.6а | 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч буй 5-17 насны хүүхдийн дунд эзлэх хувь, идэвхиэр | 54 |
| Хүснэгт 5.7 | 5-17 насны сургууль, курст хамрагдаагүй хүүхдийн тоо, шалтгаан, насны бүлэг, хүйсээр | 56 |
| Хүснэгт 5.7а | Сургууль, курст хамрагдаагүй 5-17 насны хүүхдийн дунд эзлэх хувь, шалтгаан, насны бүлэг, хүйсээр | 57 |
| Хүснэгт 5.7б | Сургууль, курст хамрагдаагүй 5-17 насны хүүхдийн дунд эзлэх хувь, шалтгаан, насны бүлэг, хүйсээр | 58 |
| Хүснэгт 6.1 | 5-17 насны хүүхдийн сүүлийн 7 хоногийн буюу тухайн үеийн эдийн | |

| | | |
|---|---|---|
| | засгийн идэвхийн байдал, хүйсээр | 61 |
| Хүснэгт 6.2 | Ажил эрхэлж буй хүүхдийн тоо, эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр | 62 |
| Хүснэгт 6.3 | Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, долоо хоногт ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйсээр | 64 |
| Хүснэгт 6.3а | Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, долоо хоногт ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цагаар, хүйсээр | 65 |
| Хүснэгт 6.3б | Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн 5–17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр | 66 |
| Хүснэгт 6.3в | Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн 5–17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, хувиар | 66 |
| Хүснэгт 6.4 | Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүүхэд, насны бүлэг, хот, хөдөө, долоо хоногт ажилласан дундаж цаг, хүйсээр | 67 |
| Хүснэгт 6.4а | Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүүхэд, насны бүлэг, хот, хөдөө, долоо хоногт ажилласан дундаж цаг, хүйсээр, хувиар | 67 |
| Хүснэгт 6.5 | 5-17 насны хүүхдүүдийн үндсэн ажлаараа ажилласан хугацаа, насны бүлэг, хүйсээр | 68 |
| Хүснэгт 6.5а | 5-17 насны хүүхдүүдийн үндсэн ажлаараа ажилласан хугацаа, насны бүлэг, хүйсээр | 69 |
| Хүснэгт 6.6 | Ажил эрхэлсэн болон зөвхөн сургуульд сурч буй хүүхдийн тоо, өрхийн сарын орлого, насны бүлгээр (хувиар) | 70 |
| Хүснэгт 6.7 | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн тоо, боловсролын түвшин, насны бүлэг, хүйсээр | 71 |
| Хүснэгт 6.7а | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, боловсролын түвшин, насны бүлэг, хүйсээр (дүнд эзлэх хувиар) | 72 |
| Хүснэгт 6.8 | Хүүхдүүдийн гэрийн ажил хийхэд долоо хоногт зарцуулсан цаг, насны бүлэг, хүйсээр | 73 |
| Хүснэгт 6.9 | Хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд зарцуулсан цаг, насны бүлэг, хүйсээр | 74 |
| Хүснэгт 6.10 | Сүүлийн 7 хоногт нэмэгдэл ажил хийхэд бэлэн байсан хүүхдүүд, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр | 75 |
| Хүснэгт 6 11 | Сүүлийн 7 хоногт нэмэгдэл ажил хайсан хүүхдүүдийн тоо, ажил хайсан хугацаагаар | 75 |
| Хүснэгт 6.12 | Тухайн үед эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, насны бүлэг, хүйсээр | 77 |
| Хүснэгт 6.13 | Байнгын үед эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, насны бүлэг, хүйсээр | 78 |
| Хүснэгт 6.14 | Тухайн үед эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр | 79 |
| Хүснэгт 6.14а | Тухайн үед эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр (хувиар) | 80 |
| Хүснэгт 6.15 | Байнгын эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр | 81 |
| Хүснэгт 6.15а | Байнгын эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр (хувиар) | 82 |
| Хүснэгт 6.16 | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, ажил мэргэжлийн үндсэн ангилал болон насны бүлэг, хүйсээр | 83 |
| Хүснэгт 6.17 | Байнгын идэвхитэй хүүхэд, ажил мэргэжлийн үндсэн ангилал, насны бүлэг, хүйсээр | 84 |
| Хүснэгт 6.18 | Тухайн үед цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдүүдийн сарын орлого | 86 |

| | | |
|---|---|---|
| Хүснэгт 6.19 | Гэрийн (эдийн засгийн бус үйл ажиллагаа) ажил хийхэд оролцсон хүүхдүүд, хийсэн ажлын төрөл, насны бүлэг, хүйсээр | 88 |
| Хүснэгт 6.20 | Гэрийн (эдийн засгийн бус үйл ажиллагаа) ажил хийхэд оролцсон хүүхдийн тоо, хийсэн ажлын төрөл, насны бүлэг, хүйсээр | 89 |
| Хүснэгт 6.21 | Гэрийн ажил хийсэн болон ус авсан, түлээ түлш бэлтгэсэн хүүхдүүдийн тоо, насны бүлэг, хүйс, 7 хоногт зарцуулсан цагаар | 90 |
| Хүснэгт 7.1 | Эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цагт үндэслэн тооцсон хүүхдийн хөдөлмөр, насны бүлэг, хүйсээр | 95 |
| Хүснэгт 7.2 | Түлш, түлээ бэлтгэх, ус авахад зарцуулсан цагт үндэслэн тооцсон хүүхдийн хөдөлмөр, насны бүлэг, хүйсээр | 96 |
| Хүснэгт 7.3 | Өрхөөс гадуур ажил хийж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгаан, насны бүлэг, хүйсээр | 100 |
| Хүснэгт 7.3а | Өрхөөс гадуур ажил хийж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгааны бүтэц, насны бүлэг, хүйсээр (хувиар) | 101 |
| Хүснэгт 7.3б | Өрхөөс гадуур ажил хийж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгаан, насны бүлэг, хүйсээр (хувиар) | 102 |
| Хүснэгт 7.4 | Хүүхдүүдийн эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгаан, насны бүлэг, хүйсээр | 103 |
| Хүснэгт 7.4а | Хүүхдүүдийн эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгааны бүтэц, насны бүлэг, хүйсээр (эзлэх хувь) | 104 |
| Хүснэгт 7.4б | Хүүхдүүдийн эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгааны бүтэц, насны бүлэг, хүйсээр (хувиар) | 105 |
| Хүснэгт 7.5 | Өрхөөс гадуур ажил хийж байгаа хүүхдүүд ажил хийж эхэлсэн насны бүлэг, хүйсээр | 106 |
| Хүснэгт 7.5а | Өрхөөс гадуур ажил хийж байгаа хүүхдүүд ажиллаж эхэлсэн насны бүлэг, хүйсээр (дунд эзлэх хувь) | 107 |
| Хүснэгт 7.5б | Өрхөөс гадуур ажил хийж байгаа хүүхдүүд ажиллаж эхэлсэн насны бүлэг, хүйсээр (дунд эзлэх хувь) | 107 |
| Хүснэгт 7.6 | Хүүхэд гэрийн ажилд тусалж эхэлсэн нас, хүйсээр | 108 |
| Хүснэгт 7.7 | Хүүхдийн (1) ажлын байр, (2) ажлын байран дээрх удирдлага, хяналт, (3) ажлын байрны нөхцлийн талаарх үнэлгээ, насны бүлэг, хүйсээр | 111 |
| Хүснэгт 7.7а | Хүүхдийн (1) ажлын байр, (2) ажлын байран дээрх удирдлага, хяналт, (3) ажлын байрны нөхцлийн талаарх үнэлгээ, насны бүлэг, хүйсээр (хувь) | 112 |
| Хүснэгт 7.8. | Хүүхдийн (1) ажлын байран дээрх дарамт, (2) хөдөлмөр хамгааллын багаж, хэрэгслийн хэрэглээ, (3) шөнө, оройн цагаар ажилласан хугацаа, давтамж, (4) ажлаас болж өвдөж, гэмтсэн байдал, насны бүлэг, хүйсээр | 113 |
| Хүснэгт 7.8а | Хүүхдийн (1) ажлын байран дээрх дарамт, (2) хөдөлмөр хамгааллын багаж, хэрэгслийн хэрэглээ, (3) шөнө, оройн цагаар ажилласан хугацаа, давтамж, (4) ажлаас болж өвдөж, гэмтсэн байдал, насны бүлэг, хүйсээр (хувь) | 114 |
| Хүснэгт 7.9 | Хүүхдийн (1) эмчилгээний зардлыг гаргасан хүн, (2) орлогын зарцуулалт, (3) ажил хийхгүй бол өөрт нь болон өрхөд нь үзүүлэх нөлөө, насны бүлэг, хүйсээр | 115 |
| Хүснэгт 7.9а | Хүүхдийн (1) эмчилгээний зардлыг гаргасан хүн, (2) орлогын зарцуулалт, (3) ажил хийхгүй бол өөрт нь болон өрхөд нь үзүүлэх нөлөө, насны бүлэг, хүйсээр (эзлэх хувиар) | 116 |
| Хүснэгт 7.10 | Хүүхэд ажлаас болж (1) өвдөж, гэмтсэн, (2) хамгийн сүүлд авсан гэмтэл, өвчлөлийн зэрэглэл, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар | 118 |
| Хүснэгт 7.10а | Хүүхэд ажлаас болж (1) өвдөж, гэмтсэн, (2) хамгийн сүүлд авсан гэмтэл, өвчлөлийн зэрэглэл, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар (эзлэх хувиар) | 118 |
| Хүснэгт 7.11 | Хүүхэд өдөрт чөлөөт цагт зарцуулж буй дундаж цаг, хүйс, насны бүлгээр | 120 |
| Хүснэгт 7.11а | Хүүхэд өдөрт чөлөөт цагт зарцуулж буй дундаж цаг, хүйс, | |

| | | |
|---|---|---|
| | насны бүлгээр (эзлэх хувь) | 121 |
| Хүснэгт 7.12 | Суралцаж буй, ажиллаж буй хүүхдүүдийн, өдөрт чөлөөт цагт зарцуулах дундаж цаг, насны бүлэг, хүйсээр | 122 |
| Хүснэгт 7.12а | Суралцаж буй, ажиллаж буй хүүхдүүд, өдөрт чөлөөт цагт зарцуулах цаг, насны бүлэг, хүйсээр (хувиар) | 122 |
| Хүснэгт 8.1 | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, бүс нутаг, насны бүлэг, хүйсээр | 127 |
| Хүснэгт 8.2 | 5-17 насны нийт хүүхдэд ажил эрхэлж буй хүүхдийн эзлэх хувь, бүс нутгаар | 128 |
| Хүснэгт 8.3 | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн бүс нутгууд дахь байршил, насны бүлэг, хүйсээр (хувиар) | 129 |
| Хүснэгт 8.3а | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн бүс нутгууд дахь байршил, насны бүлэг, хүйсээр (хувиар) | 129 |
| Хүснэгт 8.4 | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, насны бүлэг, хүйс, улирлаар | 130 |
| Хүснэгт 8.4а. | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, насны бүлэг, хүйс, улирлаар (хувиар) | 130 |
| Хүснэгт 8.5 | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, хот, хөдөө, улирал, хүйсээр | 132 |
| Хүснэгт 8.6 | Тухайн үед ажил эрхэлсэн хот, хөдөөгийн хүүхдүүдийн эзлэх хувь, бүс нутаг, хүйсээр | 133 |
| Хүснэгт 8.6а | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдүүдийн дунд эзлэх хувь, бүс нутаг, хот, хөдөө, хүйсээр | 134 |
| Хүснэгт 8.6б | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн дунд эзлэх хувь, бүс нутаг, хот, хөдөө, хүйсээр | 134 |
| Хүснэгт 9.1 | Нийт хүүхдийн тоо болон эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийн тухайн үеийн ажил эрхлэлтийн байдал, хот, хөдөөгөөр | 136 |
| Хүснэгт 9.2 | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн тоо, ажил эрхлэлтийн байдал, долоо хоногт ажилласан дундаж цагаар | 137 |
| Хүснэгт 9.3 | Өрхөөс гадуур ажил эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгаанаар | 138 |
| Хүснэгт 9.4 | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил эрхлэлтийн байдлаар | 138 |
| Хүснэгт 9.5 | Хүүхдийн тоо, ажил мэргэжлийн үндсэн ангиллаар | 138 |
| Хүснэгт 9.6 | Сүүлийн 7 хоногт гэрийн ажил (эдийн засгийн бус үйл ажиллагаа) хийхэд оролцсон хүүхдүүд, хийсэн ажлын төрлөөр | 140 |
| Хүснэгт 9.7 | Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, бүс нутгаар | 141 |

Зураг 1. 5-17 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдаагүй шалтгааны бүтэц, хувиар................55
Зураг 2. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр...........62
Зураг 3. Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хувиар......76
Зураг 4. Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, ажил мэргэжлийн ангиллаар, хувиар..............................85
Зураг 5. Өрхөөс гадуур ажил хийж байгаа хүүхдүүдийн ажил эрхлэх болсон шалтгааны бүтэц, хувиар.......... 98
Зураг 6. Өрхөөс гадуур ажил хийж байгаа хүүхдүүдийн ажлын байрны байршлын бүтэц, хувиар..........109
Зураг 7. Ажил эрхэлж буй хүүхдийн тоо, хүйс, бүс нутгаар..........128
Зураг 8. Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, хүйс, улирлаар..........131

# ӨМНӨХ ҮГ

Зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилтийн явцад нийгмийн сөрөг үзэгдлүүд олонтоо гарч ирсэний нэг нь хүүхдийн хөдөлмөрийн асуудал билээ. Монгол Улс 1990 онд НҮБ-аас гаргасан Хүүхдийн Эрхийн Конвенц, 2000 онд ОУХБ-аас батлагдсан Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182 дугаар Конвенц, 2002 онд Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай 138 дугаар Конвенцэд тус тус нэгдэн орсон орны хувьд хүүхдийн хөдөлмөрийг бүрэн устгах, хүүхдийг хүнд, хортой нөхцлийн ажил, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтэнд татан оруулахыг таслан зогсооход чиглэсэн үндэсний бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд онцгой анхаарал хандуулах болсон. Үүнтэй холбогдон хүүхдийн хөдөлмөрийн цар хүрээ, тархалт, төлөв байдлын талаарх үнэн зөв, бодит тоо мэдээллийн эрэлт хэрэгцээ байнга нэмэгдэж байгаа билээ. Эл байдлыг харгалзан Монгол Улсын Засгийн Газар болон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ) харилцан зөвшилцсөний дагуу Монгол Улсад Хүүхдийн хөдөлмөрийн үндэсний хэмжээний судалгааг явуулахад санхүү, техникийн туслалцаа үзүүлэх гэрээг 2002 оны 9 дүгээр сард байгуулсан билээ. Энэ цаг хугацаа нь Монгол Улсын Үндэсний статистикийн газарт, Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны санхүүжилттэйгээр хэрэгжүүлэх “Нийгмийн статистикийг боловсронгуй болгох” төслийн хүрээнд Ажиллах хүчний түүвэр судалгаа (АХС)-г үндэсний хэмжээнд явуулах ажлыг эхлэх үе шаттай давхардаж байсан тул Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа (ХХС)-г уг судалгааны хавсарга хэсэг болгон явуулах нь мэдээлэл цуглуулах өртөг зардлыг хэмнэх төдийгүй цаашид уг судалгааг бие даан явуулах боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой гэж үзэж холбогдох байгууллагууд харилцан тохирсон болно. Иймхүү уг судалгааг 2002 оны 10 дугаар сард эхэлж нэг жилийн туршид явуулав.

Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа (МХХС) нь Монгол Улсын хувьд хүн амын ажил эрхлэлт, нэн ялангуяа хүүхдийн хөдөлмөрийн талаар Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйг ашиглан хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар Монгол Улсын хэмжээнд анх удаа өргөн хэмжээний мэдээлэл цуглуулж, хүүхдийн эдийн засгийн идэвхи, хүүхдийн ажил, хөдөлмөрийн цар хүрээ, төлөв байдлын талаархи мэдээллийн санг бүрдүүлж байгаагаараа ихээхэн ач холбогдолтой юм.

Энэ нь хөдөлмөр эрхлэх эрсдэлтэй болон хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг бодитойгоор тодорхойлон улмаар ажил эрхэлж буй хүүхдүүдийг хамгаалах хууль эрх зүйн хүрээг боловсронгуй болгох, хүүхдийн хөдөлмөрийг бүрэн устгах, хүүхдийг хүнд, хортой нөхцлийн ажил, тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэлтэнд татан оруулах явдлыг хязгаарлах, таслан зогсооход чиглэсэн үндэсний хэмжээний бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд үнэ цэнэтэй тулгуур мэдээлэл болно гэж үзэж байна.

Зах зээлийн шилжилтийн үед тус оронд хүүхдийн хөдөлмөр, хүүхдийг гадуурхах, ашиглах зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд гарч ирж буй өнөө үед хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн холбогдолтой мэдээллийн тогтолцоо, арга зүйг улам боловсронгуй болгох, хүүхдийг хөдөлмөр эрхлэхэд түлхэж буй нөхцөл байдлыг устгах, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг таслан зогсооход чиглэсэн бодлогын чанартай зарим санал, дүгнэлтийг судалгааны үр дүнгээр дэвшүүлсэн нь бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, хэрэгжүүлэгчдэд ач холбогдлоо өгнө гэдэгт найдаж байна.

**П.БЯМБАЦЭРЭН**
**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗРЫН ДАРГА**

# ТАЛАРХАЛ

Монгол Улсын хэмжээнд анх удаа “Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа”-г Ажиллах хүчний судалгаа(АХС)-тай хамтруулан улирлаар явуулсан нь хөдөлмөрийн зах зээл дэх улирлын хэлбэлзлийг тусгасан хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн үндэсний хэмжээний суурь судалгаа болсон билээ. Судалгаагаар хүүхдийн хөдөлмөрийг устгах бодлого, үйл ажиллагаанд ашиглах зорилгоор хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг тодорхойлох, эрхэлж буй ажил, хөдөлмөрийн нөхцөл, хүүхдэд үзүүлж буй үр дагавар зэргийг тооцох замаар хүүхдийн хөдөлмөрийн талаар дүн шинжилгээ хийхэд шаардлагатай дэлгэрэнгүй тоо мэдээллийг цуглуулах зорилго тавьсан юм. Судалгааны эцсийн зорилт нь хүүхдийн хөдөлмөрийн талаарх тоо мэдээллийн санг бий болгох, хүүхдийн хөдөлмөрийг устгах бодлого, арга хэмжээг боловсруулахад ашиглах зорилгоор ОУХБ-ын аргачлалын дагуу хүүхдийн хөдөлмөрийн талаар тоо мэдээ цуглуулах үндэсний чадавхийг нэмэгдүүлэх, Монгол Улсын Хүүхдийн хөдөлмөрийн талаарх тоо мэдээг Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-ын хүүхдийн хөдөлмөрийн мэдээллийн санд нэгтгэн оруулж, ингэснээрээ хүүхдийн хөдөлмөрийн чиг хандлагын талаар бүс нутгийн болон дэлхийн түвшинд боловсруулан гаргадаг тайланд Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн холбогдолтой мэдээллийг тусгадаг болоход оршино.

Хүүхдийн хөдөлмөрийн хавсарга судалгааг манай оронд анх удаа Олон улсын аргачлалаар үндэсний хэмжээнд явуулахад санхүү, техникийн туслалцаа үзүүлсэн ОУХБ-ын Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр (ХХУОУХ) болон санхүүжүүлэгч орон болох Норвегийн Засгийн Газарт талархаж байгаагаа илэрхийлэхийн ялдамд судалгааны аргачлал боловсруулах, судалгааны тоо мэдээнд дүн шинжилгээ хийх, тайлан бичих ажилд мэргэжлийн өндөр түвшний зөвлөгөө өгч ажилласан ОУХБ/ХХУОУХ-ийн Олон улсын зөвлөх Бижой Раучадхури, төслийн ажлыг хэрэгжүүлэх үйл явцыг зохицуулж байсан ОУХБ/ХХУОУХ-ийн үндэсний хөтөлбөрийн зохицуулагч Н.Монголмаа нарт чин сэтгэлийн гүн талархал илэрхийлж байна.

Мөн энэхүү судалгааг гардан зохион байгуулж явуулах ачааны хүндийг үүрч санаачлагатай ажилласан ҮСГ-ын “Ажиллах хүчний судалгаа”-ны ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Б.Даваахүү (ХАНСГ-ын ахлах мэргэжилтэн), ажлын хэсгийн гишүүд З.Нансалмаа, Н.Должинсүрэн, Ц.Гарьд, Д.Насандэлгэр, С.Оюун-Эрдэнэ, М.Лувсан нарын хичээл зүтгэл ихээхэн хувь нэмэр оруулсан гэдгийг цохон тэмдэглэж байна. Судалгааны асуулга боловсруулах, тайлан бичих ажилд үнэтэй санал, зөвлөгөө өгч ажилласан судалгааны удирдлагын зөвлөлийн гишүүд, ҮСГ-ын даргын зөвлөлийн гишүүд болон судалгааг орон нутагт зохион байгуулах, мэдээллийг цуглуулах, боловсруулалтанд бэлтгэх ажилд идэвхи зүтгэлтэй оролцож, дэмжлэг үзүүлсэн төв, орон нутгийн статистикийн албадын нийт ажилтнууд, орон нутгийн засаг, захиргааны удирдлага, нийт хүмүүст талархал илэрхийлж сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

**П.БЯМБАЦЭРЭН**
**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ГАЗРЫН ДАРГА**

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| **АЗЦХХШӨ** | Амьсгалын замын цочмог халдварт хам шинжит өвчин |
| **АХБ** | Азийн хөгжлийн банк |
| **АХОТ** | Ажиллах хүчний оролцооны түвшин |
| **АХС** | Ажиллах хүчний судалгаа |
| **АЭТ** | Ажил эрхлэлтийн түвшин |
| **МБНС** | Мэдээлэл боловсруулах нэгдсэн систем |
| **МХХС** | Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа |
| **НҮБ** | Нэгдсэн үндэсний байгууллага |
| **НҮБХС** | Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан |
| **НХХЯ** | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам |
| **ОУХБ** | Олон улсын хөдөлмөрийн байгууллага |
| **СЭЗЯ** | Санхүү эдийн засгийн яам |
| **ТАШН** | Тооллогын анхан шатны нэгж |
| **ТББ** | Төрийн бус байгууллага |
| **ТХШН** | Тооллогын хоёр дахь шатны нэгж |
| **УИХ** | Улсын их хурал |
| **ҮСГ** | Үндэсний статистикийн газар |
| **ҮТС** | Үндэсний тооцооны систем |
| **ХАНСГ** | Хүн ам, нийгмийн статистикийн газар |
| **ХАОСТ** | Хүн ам, орон сууцны тооллого |
| **ХХУОУХ** | Хүүхдийн хөдөлмөрийг устгах олон улсын хөтөлбөр |
| **ХЭГ** | Хөдөлмөр эрхлэлтийн газар |

## Судалгааны хугацаа

| | |
|---|---|
| **Судалгааны 1 дүгээр улирал** | 2002 оны 10, 11, 12 сар |
| **Судалгааны 2 дугаар улирал** | 2003 оны 1, 2, 3 сар |
| **Судалгааны 3 дугаар улирал** | 2003 оны 4, 5, 6 сар |
| **Судалгааны 4 дүгээр улирал** | 2003 оны 7, 8, 9 сар |

## МОНГОЛ УЛСЫН ГАЗРЫН ЗУРАГ, БАЙРШЛААР



Бүлэг 1

# ЕРӨНХИЙ ТОЙМ

Монголын хүүхдийн хөдөлмөрийн судалгаа (МХХС) нь олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан нийтлэг тодорхойлолт, арга зүйг ашиглан хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар өргөн хэмжээний мэдээлэл цуглуулж явуулсан үндэсний хэмжээний томоохон судалгаа юм. Энэхүү түүвэр судалгаанд Монгол Улсын бүх аймаг, Улаанбаатар хотын 5-17 насны хүүхдүүд хамрагдсан.

### 5-17 насны хүүхдийн тоо

Судалгааны тархаалтын тооцоогоор нийт 679049 хүүхэд судалгаанд хамрагдсаны 53.1 хувь нь хот, суурин газарт, 46.9 хувь нь хөдөө орон нутагт амьдарч байна. Насны бүлгээр авч үзвэл 31.2 хувийг 5-9 насны, 43.4 хувийг 10-14 насны, 25.4 хувийг 15-17 насны хүүхдүүд тус тус эзэлж байна. Нийт хүүхдийн 51.2 хувь нь хөвгүүд, 48.8 хувь нь охид байна.

### Хүүхдийн боловсролын түвшин

Судалгааны тархаалтын тооцоогоор 5-17 насны нийт 679049 хүүхэд судалгаанд хамрагдсанаас хүүхдийн эдийн засгийн идэвхийн талаарх асуулганд 2138 хүүхэд хариулаагүй тул хүүхдийн хүн ам зүйн болон эдийн засгийн идэвхийн талаарх үзүүлэлтүүдийг асуулганд хариулсан 676911 хүүхдээр тооцсон болно. Судалгаагаар 5-17 насны нийт хүүхдийн 19.2 хувь нь сургуульд огт суралцаагүй байгаагийн 92.0 хувь нь 5-9 насны хүүхдүүд байгаа нь сургуульд орох насны доод хязгаар 7 нас байгаатай холбон үзэх хэрэгтэй. Сургуульд огт суралцаагүй хүүхдийн дотор 10-17 насны хүүхдүүд 8.0 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Түүнчлэн нийт хүүхдийн дөрөвний нэг (24.2 хувь) нь бага сургууль төгсөөгүй байгаагийн бараг 44.0 хувь нь 10-17 насныхан байна. Хүүхдүүдийн боловсролын түвшинг хүйсээр авч үзэхэд нэг их ялгаа гарахгүй байгаа боловч 10-17 насны хөвгүүдийн 2.9 хувь нь сургуульд суралцаагүй байхад мөн насны охидын зөвхөн 1.5 хувь нь сургуульд суралцаагүй байна. 15-17 насныханд 4-8-р анги болон 9-10-р ангид сурсан охидын эзлэх хувь 51.5 болон 6.7 байхад харин хөвгүүдийнх 48.6 болон 4.5 хувьтай байна. Эндээс дүгнэхэд охидын боловсролын түвшин хөвгүүдийнхээс өндөр байх магадлалтай байна.

### Хүүхдийн сургуульд хамрагдалт, эдийн засгийн идэвхи

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийг сургуульд сурч байгаа болон сургуульд суралцаагүй гэж ангилаад, ангилал бүрийг 1) эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн (гэрийн ажил хийхэд оролцсон хүүхдийг оролцуулаад), 2) зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон (эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн), 3) зөвхөн сургуульд сурсан, 4) юунд ч оролцоогүй буюу эдийн засгийн идэвхигүй, өвчтэй, тахир дутуу хүүхдүүд гэж бүлэглэж хуваасан. Судалгааны дүнгээр 5-17 насны нийт 676911 хүүхдийн 74.6 хувь нь сүүлийн 7 хоногийн байдлаар сургуульд суралцаж байна. Насны бүлгээр нь авч үзэхэд сургуульд сурч байгаа хүүхдүүдийн эзлэх хувь 7-9 насанд 70.6 хувь, 10-14 насанд 93.7 хувь, 15-17 насанд 78.7 хувьтай байна. Нийт хүүхдийн 74.8 хувь нь зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон гэж хариулсан байна. Гэхдээ эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн зарим хүүхэд гэрийн ажил хийсэн байж болох талтай. 10-14 насныхан гэрийн ажилд хамгийн их тусалж байна.

5-17 насны нийт хүүхдийн 10.0 орчим хувь нь эдийн засгийн үйл ажиллагаанд татагдан орсон байна. Энэ тоог хүйсээр задлан харуулбал хөвгүүд 11.6 хувьтай байхад охидууд 7.7 хувь байна. Ерөнхийдөө бүх насны бүлэгт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хөвгүүдийн тоо охидынхоос өндөр байгаа бөгөөд эдийн засгийн идэвхитэй хүүхдийн дийлэнх нь 15-17 насныхан байна. Нийт хүүхдийн 8.2 хувийг эдийн засгийн ямар нэгэн үйл ажиллагаа эрхэлдэггүй, гэрийн ажил хийхэд ч оролцдоггүй зөвхөн л сургуульд суралцдаг хүүхдүүд, харин 7.3 хувийг юунд ч оролцдоггүй буюу сургуульд сурдаггүй мөн эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцдоггүй хүүхдүүд тус тус эзэлж байна. Харин сургуульд хамрагдсан бүх хүүхдийн 11.0 хувь нь зөвхөн сургуульд сурч (эдийн засгийн ямар нэгэн үйл ажиллагаа эрхэлдэггүй, гэрийн ажил хийхэд оролцдоггүй), 4.8 хувь нь сурахын хажуугаар ажил эрхэлж байна. Сургуульд суралцагчдын дийлэнх буюу 84.2 хувь нь гэрийн ажилд тусалж байна. Сургуульд суралцдаггүй хүүхдийн 24.3 хувь нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж (түүнчлэн гэрийн ажилд тусалж байж болно), 47.0 хувь нь зөвхөн гэрийн ажилд тусалж байна. Сургуульд сурахын хажуугаар эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хөвгүүдийн эзлэх хувь 10-14 болон 15-17 насанд тус тус 5.0, 7.2 хувь байхад охидынх 3.6, 5.8 хувьтай байна. Сургуульд суралцдаггүй, эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 10-14 болон 15-17 насны хөвгүүдийн эзлэх хувь 53.8, 63.2 хувь, харин охидынх 33.8, 55.4 хувьтай байна. Өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам гэрийн ажилд туслалцаж буй хүүхдийн тоо багасч буй нь өрхийн насанд хүрсэн бусад гишүүн энэ ажлыг хийж байгаатай холбоотой байж болох юм. Судалгаагаар 5-17 насны бүх хүүхдийн 10.3 хувь буюу 70215 нь 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байна. Хөдөөгийн нийт хүүхдэд өрхөөс гадуур амьдарч буй хүүхдийн эзлэх хувь 20.0 (318299 хүүхдийн 63546) байхад хот, суурин газарт энэ үзүүлэлт нэлээд доогуур буюу 1.8 хувь (360750 хүүхдийн 6669) байгаа нь хөдөө орон нутагт сургууль хүрэлцэхгүй байгаатай холбоотой байж болох юм. Өрхөөс гадуур амьдарч байгаа хөдөөгийн хүүхдүүдийн 95.5 хувь нь, хот, суурин газрын хүүхдүүдийн 84.4 хувь нь суралцах зорилгоор өрхөөс гадуур амьдарч байна. Өрхөөс гадуур амьдарч буй хот, суурин газрын хүүхдийн 10.0 гаруй хувь нь суралцах, эсвэл ажиллах зорилгогүй, улмаар шалтгаан нь тодорхой бус байгаад анхааран гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй. Ялангуяа, энэ үзүүлэлт Улаанбаатар хотод 21.4 хувь (711 хүүхдийн 152) байна. Өрхөөс гадуур амьдарч буй хүүхдүүдийн 2.3 хувь нь ажил хийх гэсэн үндсэн шалтгаантай байна. Ийм хүүхдийн эзлэх хувь хөдөө орон нутагт 2.1 хувь, хот, суурин газарт 4.9 хувь байна.

### Сургуульд суралцаагүй шалтгаан

Судлийн 7 хоногийн байдлаар 5-17 насны нийт хүүхдийн 25.4 хувь буюу 171677 хүүхэд нь сургуульд суралцаагүй байгаагийн дотор 45.9 хувь нь 5-6 насны хүүхдүүд байна. Суралцах сонирхолгүй, өрхийн орлогод нэмэр болох, хичээлийн хэрэгсэл, сургуулийн дүрэмт хувцас зэрэг сургалтын зардлыг төлөх чадваргүй гэх мэт шалтгааны улмаас хүүхдүүд сургуульд хамрагдаагүй байна. Сургуульд хамрагдаагүй шалтгааныг хүйсээр авч үзэхэд онцын ялгаа ажиглагдсангүй. 10-14 нас (20.6 хувь) болон 15-

17 (29.4 хувь) насанд гэрийн ажилд туслах зорилгоор сургуульд хамрагдаагүй гэсэн хариулт зонхилж байгаа нь сонирхол татаж байна. Эдгээр насны бүлэгт өрхийн орлогод нэмэр болох зорилгоор сургуульд сураагүй хүүхдийн эзлэх хувь 8.3, 18.5, өвчтэй, тахир дутуугийн улмаас гэж хариулсан хүүхэд 21.7, 8.6 хувьтай байна.

### Хүүхдийн эдийн засгийн идэвхи

Ажил эрхэлж буй хүүхэд гэдэг нь ажил болон хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг хамруулсан өргөн хүрээний ойлголт юм. Хувиараа хөдөлмөр эрхэлж буй, эсвэл хөлстэй, хөлсгүй, байнгын болон түр зуурын ажил хийж буй, хууль бусаар хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзнэ. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлнэ гэдэг нь ажил эрхлэлтийг тооцох олон улсын жишиг ойлголт юм[1].

5-17 насны хүүхдийн эдийн засгийн идэвхийг тооцохдоо а) ажил эрхэлж буй буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн, б) эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй, в) ажил ч хийдэггүй, сургуульд ч сурдаггүй гэж гурав ангилан, ангиллын түвшин бүрд эдийн засгийн идэвхийн байдлыг маш нарийвчлан давхардуулалгүйгээр гаргасан бөгөөд ингэснээр нэг хүүхэд зөвхөн нэг ангилалд байхаар тооцсон. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн тоог тооцохдоо хоёр нөхцөл байдлыг анхааралдаа авах ёстойг тэмдэглэх нь зүйтэй. Үүнд: а) зөвхөн ажил эрхэлж буй хүүхдүүд, б) суралцахын зэрэгцээ ажил эрхэлж буй хүүхдүүд. Хүүхдүүдийн өөрийн гэртээ хийж буй ойр зуурын (гэрийн) ажлыг эдийн засгийн үйл ажиллагаанд оруулдаггүй тул ДНБ-ийг тооцдог НҮБ-ын 1993 оны ҮТС-ийн үйлдвэрлэлийн хүрээнд хамааруулдаггүй. Тиймээс ажил эрхэлж буй хүүхдүүдэд эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүдийг оруулан тооцоогүй болно. Судалгаагаар хүүхдийн эдийн засгийн идэвхийг тухайн үеийн идэвхи буюу сүүлийн долоо хоногийн, байнгын идэвхи буюу сүүлийн 12 сарын байдлаар тус тус тооцож гаргасан ба энэ тайланд тухайн үеийн идэвхийн аргачлалаар тооцсон дүнг ашиглав[2].

### Ажил эрхэлж буй хүүхдүүдийн тоо, тухайн үеийн идэвхийн байдлаар

Судалгааны дүнг улсын хэмжээнд тархаан тооцоход тухайн үеийн идэвхийн аргачлалаар 5-17 насны 68580 хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон буюу ажил эрхэлсэн байна. Нийт 5-17 насны хүүхдийн 10.1 хувь нь ажил эрхэлсэн бөгөөд эдгээр хүүхдийг насны бүлгээр авч үзэхэд 5-14 насанд 7.2 хувь, харин 15-17 насанд үлэмж өндөр буюу 18.5 хувьтай байна. Энэ нь Монгол Улсын хөдөлмөрийн хуулинд хөдөлмөрийн насны доод хязгаарыг 16 насаар, зарим ажлыг эрхлэх насны доод хязгаарыг 15 насаар тус тус зааглан тогтоосонтой холбоотой юм. Ажил эрхэлж буй хөвгүүдийн тоо охидынхоос өндөр байна. 5-14 насанд ажил хийж буй хөвгүүдийн эзлэх хувь 8.7 хувь, охидынх 5.7 хувь байна. 15-17 насны бүлэгт энэ үзүүлэлт хөвгүүдийн хувьд 22.1 хувь, охидын хувьд 14.9 хувьтай байна. Тухайн үеийн аргачлалаар 68580 хүүхэд ажил эрхэлж

*[1] Эдийн засгийн идэвхитэй хүн амын судалгаа, ажил эрхлэлт, ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлт, ОУХБ, Женев хот, 1990*
*[2] Эдийн засгийн идэвхийн талаарх ойлголт, тодорхойлолт, тайлбарыг Бүлэг 5-д танилцуулав.*

байгаагийн 2851 нь ажлын байртай боловч сүүлийн долоо хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй буюу ажил хийгээгүй хүүхдүүд байна. Эдгээр хүүхдүүд нь амарсан, чөлөө авсан, өвдсөн зэрэг ямар нэг шалтгаанаар эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй буюу ажил хийгээгүй байгаа тул сүүлийн долоо хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийсэн 65729 хүүхдийн талаарх үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй тооцсон. Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн 65729 хүүхдийн 22.3 хувь нь 5-9 насны, 31.1 хувь нь 10-14 насны, 46.6 хувь нь 15-17 насныхан байна. Хүйсээр авч үзэхэд 15-17 насны бүлэгт ажил эрхэлсэн охидын эзлэх хувь /48.2 хувь/ хөвгүүдийнхээс/45.6 хувь/ ялимгүй өндөр байгаа бөгөөд ийм хандлага хувиараа



хөдөлмөр эрхэлж буй болон өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцогчдыг насны бүлгээр тооцоход ажиглагдав.

Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн 65279 хүүхдийн 706 нь цалин хөлстэй ажил, дийлэнх болох 65023 хүүхэд хувиараа хөдөлмөр эрхэлсэн эсвэл өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй ажилласан байна. Нас болон хүйсийн бүтцээр харахад цалин хөлстэй ажил эрхэлсэн хөвгүүдийн тоо /452/ охидынхоос /254/ өндөр байна. Хувиараа хөдөлмөр эрхэлсэн, өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцсон хөвгүүдийн тоо 39955 байхад охидынх ердөө 25068 байна. Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдийн дийлэнх /566/ нь 15-17 насныхан байна. 10-14 насны хөвгүүдийн 140 нь цалин хөлстэй ажил эрхэлсэн бол ийм ажил эрхэлсэн охид зөвхөн 15-17 насныхан байна. Цалин хөлстэй ажил эрхэлсэн 15-17 насны хүүхдүүд дунджаар 50 гаруй цагийг 7 хоногийн ажилдаа зарцуулсан нь ОУХБ-гаас тогтоосон хүүхдийн хөдөлмөр гэсэн ангилалд тооцох цагаас үлэмж дээгүүр байгаа юм[3]. Энэ нь цалин хөлстэй ажил эрхэлж буй насанд хүрэгчдийн долоо хоногт зарцуулж буй цагаас ч өндөр байгаа боловч ийм ажил эрхэлж буй хүүхдийн тоо маш цөөн байгаа тул энэ талаар дүгнэлт хийхдээ болгоомжтой хандах хэрэгтэй. Долоо хоногт хувиараа хөдөлмөр эрхлэх болон өрхийн бизнест цалин хөлсгүй ажил эрхлэхэд хөвгүүд охидыг бодоход илүү олон цагийг зарцуулсан байна. Ажил эрхэлж буй охид, хөвгүүдийн эзлэх хувийг насны бүлгээр харахад ерөнхийдөө ойролцоо байна. Нийт ажил эрхэлж буй хүүхдийн дийлэнх буюу бараг 90.0 хувь нь хөдөө орон нутагт байна /68580 хүүхдийн 61686/. Харин цалин хөлстэй ажил эрхэлж буй хүүхдийн дийлэнх хот, суурин газарт байна. Хот, суурин газарт ажил эрхэлж буй нийт хүүхдийн 8.4 хувийг цалин хөлстэй ажил эрхэлж буй хүүхэд эзэлж байхад энэ үзүүлэлт хөдөөд 0.2 хувьтай байна. Ажил эрхэлж буй нийт хүүхдэд 5-9 насны хүүхдийн эзлэх хувь хөдөө орон нутагт 23.9 хувь байхад

[3] *Бүлэг 3-ын хэсэг 6-д өгсөн тодорхойлолтыг үзнэ үү.*

хотод ердөө 8.1 хувьтай байна.

Хот, суурин газартай харьцуулахад хөдөө орон нутагт бүх насны бүлгийн хүүхдүүд өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцоход илүү их цаг зарцуулжээ. Хот, суурин газарт өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон 5-9 насны хүүхдийн эзлэх хувь (11.1 хувь) хөдөөгийнхөөс (25.6 хувь) доогуур байхад 15-17 насны бүлэгт хот, суурин газарт өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүүхдийн эзлэх хувь (52.3 хувь) хөдөө орон нутгаас (43.9 хувь) өндөр байна. Энэ нь хот, суурин газарт бага сургуульд хамрагдалтын түвшин өндөр болон ажлын орон тоо харьцангуй хүртээмжтэй байдагтай зарим талаар холбоотой байж болох юм. Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүүхдүүдийг хүйсээр нь авч үзэхэд хот, хөдөөд бараг адил ойролцоогоор 60.0 хувь нь хөвгүүд, 40.0 хувь нь охид байна. Зарим хүүхэд харьцангуй бага наснаас эхлэн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон байна. Тухайлбал, 5-9 насны 15320 хүүхдийн бараг гуравны нэг нь /31.2 хувь/ 2-3 жил ажилласан, 15-17 насны хүүхдийн 6.9 хувь нь 10-аас дээш жил ажиллажээ. МХХС-ны сул тал нь судалгаанд хамрагдсан өрхүүдийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг судлаагүй явдал юм. Хүүхдийн хөдөлмөрийг судлахад ядуурлыг авч үзэх нь чухал байдаг. Иймд өрхийн сарын орлогын мэдээнд үндэслэн ажил эрхэлж буй хүүхдүүдийг /ажил эрхлэхийн хажуугаар сурч буй болон сураагүй/ зөвхөн сургуульд сурч буй хүүхдүүдтэй харьцуулах оролдлогыг хийж үзэхэд хүйсийн хувьд онцын ялгаа ажиглагдаагүй боловч тухайн хоёр ангиллын хүүхдүүдийг насны бүлэгт хуваан орлогын түвшингээр тооцоход тодорхой түвшингийн хувьд бага зэргийн зөрүү ажиглагдав. Эндээс харахад орлогын бүлгээр ангилсан хувийн жин ангилал бүрд ойролцоо байгаагаас үзэхэд өрхийн орлого нь хүүхэд нэг бол ажил эрхлэх, эсвэл зөвхөн сургуульд сурахад онцын нөлөөлөх хүчин зүйл болохгүй байна. Сургуульд сурч буй хүүхдүүдийн дийлэнх нь 7-14 насныхан байна. Харин түүнээс дээшхи насанд ийм хүүхдүүдийн тоо буурчээ. Өөрөөр хэлбэл хүүхдүүд бага, дунд ангид сургуульд дагнан суралцаж байгаад ахлах ангид сурахын хажуугаар ажил эрхэлж байж болох юм.

### Ажил эрхэлж буй хүүхдүүдийн боловсролын түвшин

Ажил эрхэлж буй хүүхдүүдийн боловсролын түвшин анхаарал татсан асуудал болж байна. Ажил эрхэлж буй 10-14 насны хүүхдүүдийн 10.5 хувь нь сургуульд огт суралцаагүй байхад, 15-17 насны хүүхдүүдийн 8.8 хувь нь сургуульд огт суралцаагүй, харин 9.2 хувь нь бага боловсрол эзэмшээгүй хүүхдүүд байна. Эндээс харахад ажил эрхэлж буй хүүхдүүдийн боловсролын түвшин үе тэнгийнхнээсээ доогуур байна. Ажил эрхэлж буй 15-17 насны хүүхдүүдийн бараг тэн хагас нь (47.0 хувь) бага ангийн боловсролтой байна. Гэтэл энэ насны хүүхдүүд доод тал нь 4-8-р ангид сурч байх ёстой. Хүйсийн хувьд онцын ялгаа ажиглагдахгүй байгаа бөгөөд харин 15-17 насны ажил эрхэлж буй охидын 5.8 хувь нь, хөвгүүдийн 1.4 хувь нь 9-10-р ангид сурч байгаа аж.

### Сургууль, боловсролоос гадуурх үйл ажиллагаанд зарцуулсан цаг

Бүх хүүхдийн бараг тэн хагас нь (47.1 хувь) гэрийн ажил хийхэд долоо хоногт 10 хүртэлх цагийг, 16.8 хувь нь 25-аас илүү цагийг тус тус

зарцуулсан байна. Энэ үзүүлэлт хүйсээр ялгаатай байгаа бөгөөд гэрийн ажил хийхэд оролцож буй охидын 21.1 хувь, хөвгүүдийн зөвхөн 12.7 хувь нь долоо хоногт 25-аас илүү цагийг зарцуулсан байна. 5-9 насны хүүхдүүд гэрийн ажилд нэлээд тусалж байгаа бөгөөд эдгээр хүүхдийн бараг 70.0 хувь нь долоо хоногт бараг 9 цагийг ийм ажилд зарцуулж байна. Насны бүлэг дээшлэх тусам гэрийн ажилд туслах цаг нь нэмэгдэж байна. Үүнд: 10-14 насны хүүхдүүдийн бараг тэн хагас нь (50.2 хувь ), 15-17 насны хүүхдүүдийн бараг гуравны хоёр (63.7 хувь) нь долоо хоногт 10-41 цагийг гэрийн ажилд туслахад зарцуулж байна. Долоо хоногт 42-оос дээш цагийг гэрийн ажил хийхэд зарцуулсан охидын тоо (16704) хөвгүүдийнхээс (7771) даруй хоёр дахин их байна. Гэрийн хүнд хүчир ажлыг хийхэд оролцож буй хүүхдүүдийн дийлэнх нь 10-17 насныхан байна. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийсэн нийт хүүхдийн 61.9 хувь нь сүүлийн долоо хоногт 10-41 цаг ажилласан байна. Насны бүлэг дээшлэх тусам долоо хоногт ажиллахад зарцуулсан цагийн тоо нэмэгдэж байна. 15-17 насны хөвгүүдийн 41.5 хувь, охидын 26.0 хувь нь долоо хоногт 42-оос дээш цаг ажиллажээ.

### Хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа

МХХС-ны тархаалтын тооцоогоор тухайн үед 68580 хүүхэд ажил эрхэлж байгаагийн дийлэнх хүүхэд нь (91.7 хувь) хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт ажиллаж байна. Нийт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүдийн 1.0 хувь нь боловсруулах аж үйлдвэрт, 0.8 хувь нь уул уурхай, олборлох салбарт, 0.5 хувь нь зочид буудал, зоогийн газарт ажиллаж байна. Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар хүйсийн ялгаа нэг их байхгүй, гагцхүү хөвгүүд уул уурхай, олборлох үйлдвэрийн салбарт охидоос илүү ажиллаж, харин зочид буудал, зоогийн газарт охид илүүтэй ажиллаж байгаа дүн гарч байна. Харин барилгын салбарт ажиллаж байгаа хүүхдүүдийн ихэнх нь хөвгүүд байна. Насны бүлгээр харахад хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй хүүхэд бүх насанд тодорхой хувийг (5-9 насанд 23.8 хувь, 10-14 насанд 30.7 хувь, 15-17 насанд 45.5 хувь) эзэлсэн байхад бусад салбарт ажиллаж буй хүүхдийн тоо 10-17 насанд илүүтэй төвлөрчээ.

### Ажил эрхэлж буй хүүхдүүдийн ажил эрхлэлтийн байдал

Тухайн үед ажил эрхэлсэн дийлэнх хүүхэд (90.0 орчим хувь) өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцогч байж, түүний дараагаар хувиараа хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд (8.2 хувь) орж байна. Гэрээгээр ажил эрхэлж буй хүүхдүүдийн ихэнх нь боловсруулах аж үйлдвэр, уул уурхай, олборлолт болон барилгын салбарт ажиллаж байна. Хүйсийн хувьд онцын ялгаа ажиглагдсангүй.

### Ажил эрхэлж буй хүүхдүүд, ажил мэргэжлийн ангиллаар

Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдүүдийн ихэнх нь (90.8 хувь) нь хөдөө аж ахуйн холбогдолтой ажил хийж байна. Түүний дараагаар үйлчилгээний ажил болон дэлгүүр, зах дээр худалдаа эрхлэгч (4.1 хувь), энгийн ажил (2.7 хувь), үйлдвэр, худалдааны ажил (1.6 хувь) хийж байгаа хүүхдүүд орж байна. Насны бүлгээр авч үзвэл 5-9 насны бараг бүх хүүхэд

(98.3 хувь) хөдөө аж ахуйн холбогдолтой ямар нэгэн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлжээ. Харин бусад төрлийн ажилд ахлах насны хүүхдүүд илүү ажиллаж байна. Байнгын эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийн ажил мэргэжлийн төрөл нь тухайн үеийнхтэй



адилхан байна.

### Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдүүдийн сарын орлого

Судалгааны дүнгээс харахад цалин хөлстэй ажил эрхэлж буй дөрвөн хүүхдийн гурав нь сургуульд сурдаггүй хүүхдүүд байна. Цалин хөлстэй ажил хийж байгаа хүүхдүүдийн 38.4 хувь нь 5000 хүртэлх, 47.8 хувь нь 5001-20000, харин үлдсэн 14.8 хувь нь 20000-аас дээш төгрөгний сарын орлоготой ажиллаж байна. Хүйсийн хувьд онцын ялгаагүй боловч сарын орлого нь өндөр буюу 26000-аас дээш төгрөгийн орлоготой хүүхдүүд нь дандаа хөвгүүд байна. Гэхдээ цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдийн тоо бага, зөвхөн тооцоогоор гарч байгаа гэдгийг энэхүү мэдээллийг ашиглахдаа анхаарах хэрэгтэй.

### Эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд

Ихэнхи хүүхдүүд ямар нэгэн хэмжээгээр гэрийнхээ ажилд тусалж байна. Хүүхэд хэд хэдэн төрлийн гэрийн ажил хийсэн байж болох бөгөөд хамгийн түгээмэл хийж буй эдийн засгийн бус үйл ажиллагаа буюу гэрийн ажлуудыг дурьдвал, хоол цай хийх, аяга таваг угаах, гэр орон цэвэрлэх, ус авах, түлээ түлш бэлтгэх, хувцас угаах, индүүдэх, гэрийнхээ хэрэгцээт зүйлсийг худалдаж авахаар дэлгүүр явах зэрэг ажлууд байна. Хүүхдүүдийн 76.4 хувь нь хоол унд хийх, аяга таваг угаах, 74.1 хувь нь гэр орон цэвэрлэх, 21.1 хувь нь гэр орныхоо хэрэгцээт зүйлсийг худалдан авахаар дэлгүүр хоршоогоор явах ажилд тусалсан байна. Ус авах, түлээ түлш бэлтгэх ажлыг хөвгүүд илүүтэй хийж байгаа нь биеийн хүч шаарддаг, магадгүй хол зам туулахад хүрдэг зэрэгтэй холбоотой байж болох юм. Гэр орныхоо хэрэгцээт зүйлсийг худалдан авах, дэлгүүр явахын хувьд бол охид, хөвгүүдийн аль аль нь оролцож байна. Ус авах, түлээ түлш бэлтгэх ажлыг хийхэд олон хүүхэд оролцсоныг харгалзан тусгайд нь хүснэгт боловсруулан долоо хоногт зарцуулсан цаг, насны бүлэг, хүйсээр тооцсон. НҮБ-ын 1993 онд боловсруулсан ҮТС-ийн хүрээнд дээрх хоёр ажлыг эдийн засгийн үйл ажиллагаанд тооцон, ажил мэргэжлийн олон улсын ангиллын 6210-р бүлэгт (амиа аргацаасан хөдөө аж ахуй, загас ан агнуур эрхлэх) бүртгэдэг. Гэхдээ ус авах, түлээ түлш бэлтгэх ажлыг ҮТС-ийн үйл ажиллагаанд хамруулах асуудлыг тухайн улс орон өөрийн орны нөхцөл байдалд тохируулан харилцан адилгүй шийддэг.

### Хүүхдийн хөдөлмөрийн тооцоо

Хүүхдийн хөдөлмөр нь ажил эрхэлж буй буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд гэсэн ойлголтоос арай бага хүрээг

хамарсан, нарийвчилсан ойлголт юм. ОУХБ-ын 138, 182-р конвенцийн дагуу хүүхдийн хөдөлмөрийг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

5-9 нас = Энэ насны эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй бүх хүүхэд;

Нэмэх нь:

10-14 нас = Энэ насны эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд [хөнгөн ажил эрхэлж буй хүүхэд, тухайлбал өдөрт 2-оос дээш цаг ажиллаж буй бүх хүүхэд]

Нэмэх нь:

15-17 нас = Хортой, хүнд нөхцөлд ажиллаж буй болон тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй бүх хүүхэд [2002-2003 оны МХХС-нд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн талаар судлаагүй. Түүнчлэн ажлын хортой, хүнд нөхцлийг заасан олон улсын жишиг үзүүлэлт байхгүй тул долоо хоногт 43 болон түүнээс дээш цагийг зарцуулж буй ажлыг хортой, хүнд нөхцөлд оруулж тооцсон]

Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийг ажилласан цагаар нь тооцож гаргасан. Эндээс харахад сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 65729 хүүхдийн 38857 (59.1 хувь) нь хөдөлмөр эрхэлж байна гэж гарлаа. Өөрөөр хэлбэл судалгаанд хамрагдсан 5-17 насны нийт хүүхдийн 5.7 хувь нь (679049 хүүхдийн 38857 нь) хөдөлмөр эрхэлж байна гэсэн үг юм. Хөдөлмөр эрхэлж буй нийт 38857 хүүхдийн 25445 (65.5 хувь) нь хөвгүүд, 13411 нь (34.5 хувь) охид байна. 15-17 насны бүлэгт ч хүйсийн ялгаа ажиглагдаж байна. Энэ насны эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн эрэгтэй хүүхдийн 41.5 хувь (18442 эрэгтэй хүүхдийн 7648) нь, охидын 26.0 хувь нь (12217 эмэгтэй хүүхдийн 3182) хөдөлмөр эрхэлж байна.

Гэхдээ МХХС-нд хараа хяналтгүй, тэнүүчлэн амьдарч буй болон нийтийн байранд суугаа хүүхдүүдийг хамруулаагүй тул хүүхдийн хөдөлмөрийн талаарх дээрх тоо мэдээ нь Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийг бүрэн хамраагүй гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Үүнээс гадна өрхийн судалгаа нь голдуу далд хэлбэрээр явагддаг тэвчишгүй хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг хамрах боломжгүй байдаг. Хүнд, хортой нөхцөлд эдийн засгийн үйл ажиллагааны ямар салбар, ямар ажил мэргэжлийг оруулах талаар чиг, заавар байхгүй тул ийм нөхцөл дэх хүүхдийн хөдөлмөрийг тооцсонгүй.

### Өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх буюу ажил хийх болсон шалтгаан

Судалгааны тооцоогоор нийт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийсэн хүүхдүүдийн 20.0 орчим хувь (68580 хүүхдээс 13509) нь өрхөөс гадуур ямар нэгэн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийж байна. Эдгээр хүүхдүүдийн олонхи нь өрхийн орлогод нэмэр болох зорилгоор (13509 хүүхдийн 7452 нь буюу 55.2 хувь) эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байна гэж хариулсан байна. Ийм хариултыг өрхөөс гадуур ажил хийхийн зэрэгцээ сургуульд сурч буй хүүхдүүдийн 61.9 хувь (5952 хүүхдийн 3685 нь), харин сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн 49.8 хувь (7557 хүүхдийн 3767) нь өгчээ. Ажлын дадлага, туршлагатай болох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх болсон гэсэн хариултыг нийт хүүхдүүдийн 22.3 хувь (13509 хүүхдийн 3017 нь), сургуульд сурч буй хүүхдүүдийн 19.0 хувь (5952 хүүхдийн 1128 ) нь, сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн 25.0 хувь

(7557 хүүхдийн 1889) нь тус тус өгсөн. Сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн зарим нь сургуульд сурахад гарах зардлыг олохын тулд ажилласан гэж хариулсан сонирхуушгай дүн гарлаа. Өөрийгөө авч явах, эдийн засгийн хувьд бие даахын тулд зарим хүүхэд ажил эрхэлж байна.

### Өрхөөс гадуур ажил хийж эхэлсэн нас

Тухайн үед өрхөөс гадуур ажил эрхэлж байгаа хүүхдүүдийн нэлээд олон нь бага наснаасаа ажиллаж эхэлжээ. 10 хүрэхгүй настайдаа өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж хариулсан хүүхдүүд 15.0 хувийг (13509 хүүхдийн 2094 нь) эзэлж байна. 10-12 насны бүлэгт[4] хамгийн олон хүүхэд (нийт хүүхдийн 34.5 хувь нь) бага наснаасаа өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож эхэлсэн бөгөөд энэ үзүүлэлт 13-14 болон 15-17 насныханд ч өндөр (25.0 хувьтай) байна. Сургуульд суралцаж буй эсэх, өрхөөс гадуур амьдарч буй эсэхээр нь хүүхдүүдийг тооцоход нас, хүйсээр онцын их ялгаа байхгүй байна.

### Ажлын байрны байршил

Өрхөөс гадуур ажил хийсэн нийт хүүхдийн 40.0 гаруй хувь нь малын бэлчээр, тариалангийн талбайд, 29.1 хувь нь ажил олгогчийн гэрт, 13.7 хувь нь дэлгүүр, зах дээр, 4.2 хувь нь уурхайд ажилладаг гэж хариулжээ. Гудамж, үйлдвэрийн газар, барилга дээр ажилладаг хүүхэд цөөхөн байна. Ажил хийж буй хүүхдүүдийн ажлын байрны байршлын төрөл хүүхдийн 10 наснаас эхлэн олширч, үйлдвэрийн газарт ажиллаж буй хүүхдийн дийлэнх нь 15-17 насныхан байна. Уурхайд ажиллаж буй хөвгүүдийн ихэнх нь 10-14 насныхан байгаа гэсэн дүн гарч байгаад анхаарал хандуулах хэрэгтэй юм.

### Ажлын байран дээрх удирдлага, хяналт, ажлын байрны нөхцөл

Өрхөөс гадуур ажиллаж буй хүүхдүүдийн дөрөвний гурав нь насанд хүрсэн хамаатан садны удирдлага, хяналтын дор ажиллаж байна. Гэхдээ хүүхдүүдийн дунд, түүн дотроо 10-аас дээш насны хүүхдүүдийг оруулаад, нийлээд хувь (12.6 хувь) нь хэний ч хяналт, удирдлаган дор бус харин бие даан ажиллаж байна. Бие даан ажиллаж байгаа хүүхдүүдийн дунд эзлэх энэ хувь насанд хүрсэн. хамаатан садан бус хүний удирдлаган дор ажиллаж буй хүүхдүүдийнхээс 2.9 пунктээр өндөр байгаа нь сонирхол татаж байна. Магадгүй энэ нь 10-аас дээш насны бүлгүүдэд албан бус секторт хувиараа хөдөлмөр эрхлэх хүүхдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байж болох юм. Нийт хүүхдийн 88.3 хувь нь ажлын байрны нөхцөлдөө сэтгэл ханамжтай байна. Харин ажлын байрны нөхцөлд сэтгэл ханамжгүй хүүхдүүд хэт хүйтэн, эсвэл хэт халуунд ажиллахад хүрдэг гэж хариулжээ. Түүнчлэн ажлын байрны тааламжгүй нөхцөлд тоосжилт, чийг, чимээ шуугиан ихтэй, аюултай бодис, материалтай ажилладаг зэрэг хүчин зүйлүүдийг дурьдаж байна. Дийлэнх хүүхэд (99.0 хувь) ажлын байран дээр ямар нэг дарамт байхгүй гэж хариулжээ. Загнуулдаг, хэл амаар доромжлуулдаг, орлогоо дээрэмдүүлдэг, ажил олгогч нь тэдэнтэй хүйтэн хөндий харьцдаг тул дарамттай байдаг гэж зарим хүүхэд хариулсан тохиолдол байна.

[4] *Хамгийн өндөр хувьтай насны бүлэг.*

### Шөнө оройн цагаар ажилласан хугацаа

Хүүхдүүдийн 20.0 орчим хувь нь шөнө оройгоор (өөрөөр хэлбэл оройн цагаар болон шөнө) ажилласан гэж хариулжээ. 10-аас дээш насны хүүхдүүд л шөнө, оройн цагаар ажиллаж, 15-17 насны хүүхдүүдийн дөрөвний нэгээс илүү хувь нь шаардлага гарсан үед шөнө, оройн цагаар ажилладаг гэжээ. Шөнө, оройн цагаар ажилласан давтамж нь сүүлийн 30 хоногт 1-3 удаа гарсан байна. Шөнө, оройгоор үүнээс олон удаа ажилласан хүүхдүүд ч бас байгаа бөгөөд ялангуяа 15-17 насны охид ингэж ажилласан нь нэлээд анхаарал татаж байна.

### Ажлаасаа болж өвдөж, гэмтсэн байдал

Өрхөөс гадуур эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил эрхэлж буй хүүхдүүдийн дийлэнх (98.8 орчим хувь) нь сүүлийн 12 сард хийж буй ажлаасаа болж өвдөж, гэмтээгүй гэж хариулжээ. Гэхдээ хүүхдүүдийн 1.2 хувь нь ажлаасаа болж өвдөж, гэмтсэн бөгөөд ийм хүүхдүүдийн 79.4 хувь нь 10-14 насныхан, түүн дотроо хөвгүүд зонхилж байна. Өвдөж гэмтсэн ихэнх тохиолдолд эмчилгээ хийх шаардлагатай байсан ба эмчилгээний зардлыг эцэг, эх нь голчлон гаргасан байна. Өвдөж, гэмтсэн хүүхдүүдийн ихэнх нь хөдөө аж ахуй, ан агнуур, бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажиллаж байгаа бөгөөд ийм тохиолдлын гуравны нэгд нь эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлага гарсан, мөн гуравны нэгд нь хөдөлмөрийн чадвараа түр алдсан байна. Нийт гэмтэл авсан болон өвдсөн хүүхдүүдийн 26.3 хувь нь хөнгөн хэлбэрийн гэмтэл авчээ.

### Орлогын зарцуулалт

Өрхөөс гадуур ажил эрхэлж буй нийт хүүхдийн тэн хагасаас илүү хувь нь (51.7 хувь) орлогоо бүгдийг нь гэртээ өгдөг байна. Харин 37.2 хувь нь орлогынхоо заримыг нь гэртээ, заримыг нь өөртөө зарцуулдаг бол олсон орлогоо хуримтлуулдаг хүүхэд маш цөөхөн буюу 0.4 хувь, орлогоо өөртөө бүтэн зарцуулдаг хүүхэд 6.4 хувьтай байна. Хэдийгээр хүйсээр онцын их зөрөө байхгүй байгаа боловч олсон орлогоо бүгдийг нь гэртээ өгдөг охидын эзлэх хувь хөвгүүдийнхээс өндөр байна.

### Хүүхэд ажиллахаа боливол өөрт нь болон өрхөд үзүүлэх нөлөө

Өрхөөс гадуур ажил эрхэлж буй нийт хүүхдийн 42.8 хувь нь ажил хийхээ болих нь өөрсдөд нь болон өрхөд нь нөлөө үзүүлэхгүй гэж хариулжээ. Харин муугаар нөлөөлнө гэж хариулсан хүүхдүүдийн дийлэнх нь (тэн хагасаас илүү хувь нь) өрхийн амьжиргааны түвшин доошилно гэж, харин 20 хүүхдийн нэг нь өрх орлогын эх үүсвэргүй болно гэж хариулжээ. Түүнчлэн ажлын дадлага, туршлагагүй болно, өрхийн бизнест муугаар нөлөөлнө гэж цөөн хүүхэд үзжээ.

### Хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин, бүс нутгаар

Баруун бүсийн нутагт хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин хамгийн өндөр буюу 18.6 хувь, түүний дараагаар Хангайн бүсэд 15.3 хувьтай байна. Энэ үзүүлэлт Улаанбаатар хотод хамгийн доогуур буюу 1.0 хувь хүрэхгүй байна. Харин Зүүн болон Төвийн бүсийн нутагт тус бүр 7.2-7.8 хувьтай байна. Насны бүлгээр авч үзвэл бүс нутгууд дахь хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин нийт ажил эрхэлж буй хүүхдүүдийн хандлагыг давтаж байна. Тухайлбал, ажил эрхлэлтийн түвшин насны

бүлэг дээшлэх тусам нэмэгдэж байна. Харин Төв, Баруун бүсэд 10-14 насанд энэ үзүүлэлт буурч гарчээ.

### Хүүхдийн ажил эрхлэлт, улирлаар

Хүүхдийн ажил эрхлэлт улирлаар нэлээд хэлбэлзэж байгаа бөгөөд эхний улиралд хамгийн цөөн хүүхэд, дараачийн улирлуудад аажим аажмаар өсөх хандлагатай байна. Гэхдээ судалгааны улирлын хугацаа цаг тооллын улирлын хугацаатай таарахгүй байгааг анхаарах хэрэгтэй (Хуудас xi, судалгааны хугацааг харна уу). Эхний хоёр улирал (2002 оны 10-12 сар, 2003 оны 1-3 сар) нь ил задгай газар эсвэл гадаа ажиллахад тохиромжгүй хамгийн хүйтэн, хатуу ширүүн уур амьсгалтай улирал байдаг тул хүүхдүүд ажил эрхлэх нь бага байж болох талтай. 4-р улирал буюу 7-9 сард ажил эрхэлж буй хүүхдийн тоо хамгийн их байгаа нь эдийн засгийн ямар нэгэн үйл ажиллагаа эрхлэх хамгийн боломжтой улирал болохоос гадна намар, өвлийн улиралд бэлтгэх олон төрлийн ажил хийгддэгтэй холбоотой байж болох талтай. Эхний улиралд ажил эрхэлж буй хүүхдийн тоо хамгийн бага, харин бусад улирлынхтай харьцуулахад ажил эрхэлж буй 15-17 насны хүүхдүүдийн дунд эзлэх хувь нь хамгийн өндөр буюу 62.3 хувьтай байна. Бусад саруудтай харьцуулахад 4-9-р сарууддад эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдийн тоо, ялангуяа бага насны хүүхдийн тоо нэмэгддэг нь хүүхдүүдийн зуны амралт эхэлсэнтэй холбоотой байж болох юм. 3,4-р улиралд ажил эрхэлж буй бүх насны хүүхдүүдийн насны бүлгийн дунд эзлэх хувь нэлээд жигд, тэнцүү байна.

### Хот, хөдөөд ажил эрхэлж буй хүүхдүүдийн тоо, улирлаар

Нийт ажил эрхэлж буй хүүхдийн бараг 90.0 хувь нь хөдөө орон нутагт ажиллаж байна. Ажил эрхэлж буй хөвгүүдийн 10.9 хувь нь (41874 хүүхдийн 4558), охидын 8.7 хувь (26706 хүүхдийн 2336) нь хот, суурин газрынх байна. Нийт хүүхдүүдийн хувьд 4-р улиралд ажил эрхлэлтийн түвшин хамгийн өндөр байхад харин хот, суурин газрын хувьд болохоор 3-р улиралд хамгийн олон хүүхэд ажил хийсэн харагдаж байна.

Хүйсээр задлан харвал ажил эрхэлж буй эмэгтэй хүүхдийн тоо болон дунд эзлэх хувь дахь хэлбэлзэл ерөнхий чиглэл хандлагатай адил байхад эрэгтэй хүүхдүүдийн хувьд 3-р улиралд хамгийн олон хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцжээ. 4-р улиралд ажил хийсэн хүүхдүүдийн тоо 3-р улирлынхаас өссөн ч гэсэн хотод ажил эрхэлж буй хөвгүүдийн тоо 4-р улиралд 3-р улирлынхаас эрс багасчээ. Хөдөө орон нутагт ажил эрхэлж буй охидын тоо 3, 4-р улирлын хооронд эрс өссөн байна.

Бүлэг 2

# УДИРТГАЛ

## 2.1 Танилцуулга

Монгол Улс нь өмнө талаараа Хятад Улс, хойд талаараа Оросын Холбооны Улстай хил залган нийт 1564.1 мянган хавтгай дөрвөлжин нутаг дэвсгэрийг эзлэн Ази тивийн төв хэсэгт оршдог далайд гарцгүй орон билээ. 2003 оны эцэст суурин хүн ам 2.504[5] мянга байсан бөгөөд нэг хавтгай дөрвөлжин км газарт 1.6 хүн ногдож байгаа тул хүн амын нягтрал хамгийн бага орнуудын тоонд багтдаг. Монгол Улс нь газар зүй болон засаг захиргааны хувьд Улаанбаатар хот (нийслэл хот), 4 бүс нутагт хуваагддаг. Үүнд: төвийн бүсийн аймгуудад Дархан-Уул, Сэлэнгэ, Дундговь, Төв, Өмнөговь, Дорноговь, Говьсүмбэр, зүүн бүсийн аймгуудад Хэнтий, Дорнод, Сүхбаатар, хангайн бүсийн аймгуудад Архангай, Өвөрхангай, Булган, Орхон, Баянхонгор, Хөвсгөл, баруун бүсийн аймгуудад Баян-Өлгий, Увс, Ховд, Говь-Алтай, Завхан аймгууд орж байна.

Өнгөрсөн 10 гаруй жилийн хугацаанд Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих шилжилтийн замыг туулж, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр ихээхэн дэвшилд хүрч, өөрчлөлт хийсэн билээ. Ардчиллыг дээдлэн, өмч эзэмшлийн олон хэлбэр түүн дотроо хувийн өмчлөлийн хэлбэрийг дэмжин, хөгжүүлэх зарчмыг хуульчлан тогтоосон хуулийг батлан мөрдөж, эдүгээ Төв Азид хамгийн нээлттэй эдийн засаг бүхий орнуудын нэг болж байна. Энэ зорилтод хүрэхийн тулд Монгол Улс үнэ, ханшийг чөлөөлөн, хоёр шатлалт банкны тогтолцоог бүрдүүлэн хэвшүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Эдгээр арга хэмжээ нь эдийн засгийн салбарт Засгийн газар, төсвийн оролцоог багасган, харин хувийн хэвшил үүсэн хөгжих үйл явцыг чөлөөтэй, нээлттэй болгон улмаар эдийн засгийн бүтэц шинэчлэн өөрчлөгдөхөд ихээхэн хувь нэмэр оруулсан юм.

Сүүлийн жилүүдэд хандивлагч орон болон байгууллагуудын тусламжтайгаар төсвийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн боловсронгуй болгох, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжин зээл олгох, санхүүгийн бичил тогтолцоог бүрдүүлэх, гадны хөрөнгө оруулалтыг дэмжих зэрэг алхмуудыг хийсний дүнд эдүгээ Монгол Улсын ДНБ-ий 70.0 гаруй хувь нь хувийн хэвшлийн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд ногдож байна. Засгийн Газар нь хууль эрх зүйн уялдаа, тогтвортой байдлыг хангах, газрын шинэтгэл хийх, өмчлөлийн эрхийг баталгаажуулах чиглэлээр хувийн хэвшлийг илүү эрчимтэй дэмжих шаардлагатай байгаа юм.

Дотоодын нийт бүтээгдэхүүний 1996-1999 оны 4 жилийн дундаж өсөлт 3.3 хувь байсан бол 2000-2003 оны 4 жилийн дундаж нь 2.9 хувь байна. Энэ нь 2000-2002 онуудад ган, зудны улмаас мал аж ахуйд учирсан хохирол 11 сая гаруй толгой мал болж, уг салбарт үйлдвэрлэлийн хэмжээ ихээхэн буурсантай холбоотой юм. Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарын 1995 оны зэрэгцүүлэх үнээр үнэлсэн нэмэгдэл өртөг 2002 онд өмнөх оныхоосоо 18.7 тэрбум төгрөгөөр буурч байсан бол 2003 онд 9.1 тэрбум төгрөгийн өсөлттэй, үүний дотор мал аж ахуйн салбарын нэмэгдэл

[5] *2003 оны Монгол Улсын Статистикийн эмхтгэл, УСГ, УБ, 2004.*

өртөг 2002 онд өмнөх оноос 17.6 тэрбум төгрөгөөр буурч байсан бол 2003 онд 3.9 тэрбум төгрөгөөр өссөн нь тус салбарт малын тоо толгой 1.5 саяар өсч, үйлдвэрлэлт хэвийн хэмжээнд явагдаж эхэлж буйг харуулж байна.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт 1996-1999 онуудад уналтанд орсон байсан бол 2000-2003 оны 4 жилийн дундаж өсөлт 5.9 хувь, үүний дотор боловсруулах үйлдвэрийн салбарынх 12.3 хувь болж өсчээ. Энэ нь тус салбарын үйлдвэрлэл сэргэж, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж эхэлж буйг харуулж байна.

2003 онд ДНБ өнгөрсөн оноос 5.6 хувиар өсөхөд барилга, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа, тээвэр, агуулахын аж ахуй, холбоо, бөөний болон жижиглэн худалдаа зэрэг үйлчилгээний салбаруудын бүтээгдэхүүний өсөлт голлон нөлөөлсөн.

Ноолуур, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр болон алт олборлолт хөгжин эрчимжиж, боловсруулах үйлдвэр, уул уурхайн үйлдвэрлэл ойрын ирээдүйд өсөх хандлагатай байна. ДНБ-ий үйлдвэрлэлд хамгийн их хувийг эзлээд байгаа үйлчилгээний салбар ч нийслэл хотод түргэн хурдацтай хөгжиж байгаа ба эрэлт хэрэгцээ нь нэмэгдэж буй тул цаашид улам өргөжих болно.

Эдийн засгийн өсөлт нь амьжиргааны түвшин дээшилж, орлого нэмэгдэх нааштай үр дагаврыг авчирсан ч нэг хүнд ногдох ДНБ 2003 оны байдлаар 450.0 ам доллар байсаар байна. Нэг хүнд ногдох орлогод зарим ахиц гарсан ч эдийн засгийн шилжилтийн үр ашгийг жигд бус хүртэж байгаа нь тэгш бус байдлыг нэмэгдүүлж байна. Эдийн засгийн үйл ажиллагаа уул уурхайн олборлолт, мал аж ахуй төдийгөөр хязгаарлагдаж, эдийн засгийн өсөлт хурдацтай бус явагдаж байгаа нөхцөлд эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлүүдийг өргөжүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн үр ашгийг жигд бус хүртэж байгаагаас улбаалан гарч буй өөр нэг үр дагавар нь хэдийгээр шилжилтийн үйл явц эдийн засгийг хөгжүүлэн эрчимжүүлэхэд нөлөөлж байгаа ч зах зээлийн тодорхой хүчин зүйлүүд өөрөөр хэлбэл хот, хөдөөгийн хүн амын амьжиргааны түвшинд зааг ялгаа гаргахад хүргэсэн.

Монголын хүн амын гуравны нэг нь амьжиргааны доод түвшинд амьдарч байна. Ялангуяа хот, суурин газарт байр орон сууц, хоол хүнсний үнэ өртөг өндөр байгаа нь хотын ядуу бүлгийн хүн амын эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Монгол орны хатуу ширүүн уур амьсгалтай өвлийн улиралд орон гэргүй хүмүүс амь насаа ч алдах магадлал өндөр байна. 1998 оны амьжиргааны доод түвшинд үндэслэн ядуурлын гүнзгийрлийг тооцоход хөдөө орон нутагт ядуу хүн амын эзлэх хувь 32.6 хувь, харин хот, суурин газарт 39.4 хувь байна[6]. Ялангуяа олон ам бүлтэй өрх, өрх толгойлсон эмэгтэйчүүд ядууралд илүүтэй өртөж байна. Эдийн засгийн өсөлт доогуур байгаа мөн ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлт зэрэг нь ядуурлыг үүсгэгч гол хүчин зүйл болж байна.

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын

[6] *Ази, Номхон Далайн Орнуудын Эдийн Засаг, Нийгмийн Судалгаа 2004, НҮБАНДБЭЗНХ (2002, НҮБ, Нью-Йорк), Хүснэгт III.4, хх. 248.*

тооллогоор хот, суурин газрын 10-14 насны хүүхдүүдийн 95.4 хувь нь сургуульд суралцаж байхад хөдөө орон нутагт 78.1 хувь байсан байна. Хэдийгээр Монгол Улс хүн амаа бичиг үсэгтэй болгох талаар ихээхэн амжилт гаргаж, дэлхийд бичиг үсгийн мэдлэгийн түвшингээр хамгийн дээгүүр байранд ордог орнуудын нэг болж чадсан ч сүүлийн жилүүдэд гарсан өөрчлөлтийн явцад ядуу өрхийн хүүхдүүд болон хөдөө орон нутгийн хүүхэд багачууд сургууль завсардах нь нэмэгдэж, энэ нь залуу хүн амын дунд бичиг үсгийн мэдлэгийн түвшинг бууруулах сөрөг үр дагавартай болжээ. Эмэгтэйчүүд их, дээд сургуулиудад суралцагчдын нэлээд хувийг ээлж байгаа сайн талтай боловч хувийн хэвшил болон төр, засгийн удирдах албан тушаалд эмэгтэйчүүдийн эзлэх хувь бага байна.

## 2.2 Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөр

1990-ээд оноос эхэлсэн зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих шилжилтийн явцад нийгмийн сөрөг үзэгдлүүд гарсны нэг нь хүүхдийн хөдөлмөр билээ. Эдийн засгийн болон улс төрийн шинэчлэл нь Монголын хүн амд гэнэтийн бөгөөд хүнд үр дагаврыг авчирлаа. Шилжилтийн өмнөх үед нийгмийн үйлчилгээний харьцангуй сайн хөгжсөн дэд бүтэц үйлчилж, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээнд хүн ам жигд хамрагдаж байсан юм. Ийнхүү хүн амд хүргэх нийгэм болон халамжийн бусад үйлчилгээг төвлөрсөн төлөвлөгөөт хуваарийн дагуу хүргэх зарчмаас хөндийрүүлж, эдгээр үйлчилгээ доройтсон нь өрх айлуудад хүндээр тусч, хүн амын үлэмж хэсгийг эмзэг байдалд оруулан, тэдний ирээдүйд итгэх итгэл, хүсэл эрмэлзлийг бууруулсан. Ядуурал, хөдөө орон нутгаас хот, суурин газрыг чиглэсэн шилжих хөдөлгөөн, ялангуяа хот, суурин газарт ажилгүйдэл, өрх толгойлсон эмэгтэйчүүд нэмэгдэж, албан бус сектор цар хүрээгээ тэлэн өргөжиж байна. ҮСГ-аас явуулсан 1998 оны Хүн амын амьжиргааны түвшний түүвэр судалгаа (АТТС)-гаар хүн амын 35.0 орчим хувь нь амьжиргааны доод түвшингээс доогуур хэрэглээтэй байна гэсэн дүн гарсан.

Ядуурал өргөн хүрээнд тархан, хямд ажиллах хүчийг ажиллуулах сонирхол бий болохын сацуу хүүхдийг ажил хөдөлмөрт сургах уламжлал, заншил зэрэг хүчин зүйлийн улмаас Монгол Улсын зарим хэсэгт хүүхдүүд эдийн засгийн үйл ажиллагаанд татагдан орж байна. Сургуульд суралцах боломж, бололцоо тааруу байгаа нь хүүхдүүдийг орлого олж, амь зуух зорилгоор ажил хайхад түлхэж байна. 8-15 насны хүүхдүүдийн 13.5 хувь нь сургуульд суралцахгүй байгаа гэсэн тоо мэдээ байна.[7]

Монгол Улсад хүүхдийн хөдөлмөр ямар шинж чанартай, хир их цар хүрээтэй байгаа талаар статистикийн тоо мэдээлэл гардаггүй. ҮСГ нь НҮБХС-тай хамтран 2000 онд явуулсан “Хүүхэд Хөгжил” судалгаагаар 5-14 насны хүүхдүүдийн 1.4 хувь нь бусдад хөлслөгдөн ажил хийж байна гэж гарчээ. Мөн Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогоор 15 настай хүүхдүүдийн 17.3 хувь нь ажил эрхэлж байгаагийн дийлэнх нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байгаа гэж гарчээ. Хэдийгээр тодорхой хэдхэн салбарт

[7] *"Монголын хөдөө дэх жендэрийн дүр зураг" номны Хүснэгт 6-17, НҮБЭХС, 2003*

хүүхдийн хөдөлмөрийн талаар богино хугацааны судалгаа хийж үнэлэлт өгсөн ч аргачлал, зорилго нь харилцан адилгүй тул үр дүнг нь хооронд нь харьцуулах эсвэл ерөнхийд нь нэгтгэн тооцох боломжгүй юм. Ийм ч учраас эдгээр болон бусад тоо мэдээг ашиглан хүүхдийн хөдөлмөрийг улсын хэмжээнд тооцон дүгнэхэд бэрхшээлтэй байгаа билээ.

Энэ байдлыг харгалзан үзэж Монгол Улсын Засгийн Газар болон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ) харилцан зөвшилцсөний дагуу Монгол Улсад Хүүхдийн Хөдөлмөрийн Үндэсний Хэмжээний Судалгааг явуулахад санхүү, техникийн туслалцаа үзүүлэх гэрээг 2002 оны 9-р сард байгуулсан. Энэхүү туслалцааг ОУХБ-ын Хүүхдийн Хөдөлмөрийг Устгах Олон Улсын Хөтөлбөр (ХХУОУХ)-ийн бүрдэл хэсэг болох Хүүхдийн хөдөлмөрийн статистикийн мэдээлэл цуглуулах, хянах ажлын хүрээнд үзүүлсэн билээ. Тухайн үед Үндэсний статистикийн газар АХБ-ны санхүүжилттэйгээр хэрэгжүүлж буй "Нийгмийн Статистикийг Боловсронгуй Болгох" төслийн хүрээнд Ажиллах Хүчний Судалгаа (АХС)-г үндэсний хэмжээнд явуулах ажлыг эхэлсэн байсан тул Монголын Хүүхдийн Хөдөлмөрийн Судалгаа (МХХС)-г тус судалгааны хавсарга хэсэг болгон явуулахаар тохирч, АХС-ны асуулга авах өрхийн гишүүдийн насны доод хязгаарыг 5 насаар тогтоосон. МХХС-г АХС-тай хавсран явуулснаар мэдээлэл цуглуулах өртөг зардлыг хэмнэх төдийгүй цаашид судалгааг бие даан явуулах боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой болсон юм.

## 2.3 Судалгааны зорилт

МХХС-гаар 5-17 насны хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагааг өрхөд суурилан судаллаа. Тус судалгааны стратегийн зорилт нь хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагааны талаар тоон мэдээлэл цуглуулж (сургуульд хамрагдалт, эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаан дахь хүүхдийн оролцооны талаарх), тоон болон чанарын үзүүлэлтээс бүрдсэн мэдээллийн санг байгуулахад оршиж байв. Хөдөө орон нутаг, хот, суурин газар болон улсын хэмжээн дэх хүүхдийн хөдөлмөрийн байдалд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх, хүүхдийн хөдөлмөрийн чиг хандлагын талаар мэдээлэл өгөх, үндсэн шалтгаануудыг тодорхойлоход судалгааны дүнг ашиглана.

Судалгааны асуулга (АХС+МХХС) нь үндсэн болон хавсарга хэсгээс бүрдсэн. Судалгааны үндсэн болон хавсарга асуулгын мэдээллийг бөглөхдөө өрхийн 5 ба түүнээс дээш насны бүх гишүүдээс (харин асуултанд хариулах чадваргүй гишүүнийг төлөөлөн хариулж чадах өрхийн насанд хүрсэн гишүүнээс) ярилцлага авч өрхийн бүх гишүүдийн хүн ам зүйн болон эдийн засгийн идэвхийн талаарх мэдээлэл цуглуулсан. Хүүхдийн хөдөлмөрийн хавсарга судалгаагаар хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаан дахь оролцоо, эрхэлж буй ажил, ажлын байрны нөхцөл, хөдөлмөр эрхлэх болсон шалтгааны талаар асуусан. Тодруулбал, МХХС-гаар дараах мэдээллийг цуглуулахыг зорив. Үүнд:

1. Хүүхдийн хөдөлмөрийн төлөв байдал, хамрах хүрээ, хөдөлмөр эрхлэх болсон шалтгааны талаар мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийх, хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн ажлын нөхцөл, хөдөлмөр эрхэлснээр хүүхдийн эрүүл мэнд болон боловсрол, хэвийн өсөлт бойжилтод хэрхэн нөлөөлж буйг тодорхойлохын тулд судалгааны асуулгад зохих нэмэлт асуултуудыг оруулж хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн талаарх мэдээллийг цуглуулсан. Үүнд:
    - Хүн ам зүй, нийгмийн үзүүлэлтүүд: боловсролын түвшин, сургуульд хамрагдалт, эрхэлж буй ажлын төрөл, ур чадварын түвшин, ажилласан цаг, цалин хөлс, орлого, ажлын байрны нөхцөл;
    - Хүүхдүүдийн ажил эрхлэлтийг эдийн засгийн үйл ажиллагааны салбар, аж ахуйн нэгж, байгууллагын төрөл, ажил мэргэжлийн ангиллаар;
    - Хүүхдүүд хаана ажил хөдөлмөр эрхэлж байна, ажил хийх болсон шалтгаан, хэдэн настайгаасаа ажил хийж эхэлсэн, ажил хийсэн хугацаа;
    - Хэний удирдлага, хяналт эсвэл анхаарал дор ажиллаж байна;
    - Сэтгэл санааны дарамтанд ордог эсэх;
    - Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн эрүүл мэнд болон тэдгээрийн аж байдлыг ажлын нөхцөлтэй нь уялдуулан судлах;
    - Хүүхдийн эдийн засгийн үйл ажиллагааг бүс нутаг болон улирлаар гаргах зэрэг болно.

2. Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн талаарх тоон мэдээллийн бааз суурийг бий болгох, бусад судалгаа болон засаг захиргааны мэдээллээр шинэчлэн баяжуулах,

3. Хүүхдийн хөдөлмөрийг устгах бодлого, арга хэмжээг боловсруулахад ашиглах зорилгоор ОУХБ-ын аргачлалын дагуу хүүхдийн хөдөлмөрийн талаар тоо мэдээ цуглуулах ҮСГ-ын чадавхийг нэмэгдүүлэх,

4. Хүүхдийн хөдөлмөрийг устгах бодлого, үйл ажиллагаанд ашиглах зорилгоор хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг тодорхойлох, ажлын байрны нөхцөл, гарч буй үр дагавар зэргийг тооцох замаар хүүхдийн хөдөлмөрийн талаар иж бүрэн шинжилгээ хийх,

5. Статистикийн мэдээлэл, дүн шинжилгээ дүгнэлт бүхий Монгол Улсын Хүүхдийн хөдөлмөрийн үндэсний тайланг боловсруулан, Засгийн газар, Ажил олгогч эздийн холбоод, Үйлдвэрчний эвлэл, төрийн бус байгууллагууд (ТББ), олон нийтэд танилцуулах, түгээх, тэдний ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх,

6. Монгол Улсын хүүхдийн хөдөлмөрийн талаарх тоо мэдээг ОУХБ-ын хүүхдийн хөдөлмөрийн мэдээллийн санд нэгтгэн оруулж, ингэснээр хүүхдийн хөдөлмөрийн чиг хандлагын талаар бүс нутгийн болон

дэлхийн түвшинд боловсруулан гаргадаг тайланд Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн холбогдолтой мэдээллийг тусгадаг болох.

## 2.4 Тайлангийн агуулга, бүтэц

Өрхөд амьдарч буй 5-17 насны хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагааны талаарх иж бүрэн мэдээллийг энэхүү тайланд танилцуулж байна. Хүүхдүүдийг дараах ангиллаар бүлэглэсэн.

- Зөвхөн сургуульд сурч байгаа (өөр ямар нэгэн эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлээгүй);
- Сургуульд сурахын зэрэгцээ эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа;
- Сургуульд сурахын зэрэгцээ эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж байгаа;
- Сургуульд сурахын зэрэгцээ эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагааны аль алиныг нь эрхэлж байгаа;
- Зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа;
- Зөвхөн эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж байгаа;
- Эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагааны аль алиныг нь эрхэлж байгаа;
- Сургуульд суралцдаггүй;
- Сургуульд суралцдаггүйгээс гадна эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагааны аль алиныг нь эрхлээгүй;

**Тайлан нь дараах 9 бүлэгтэй:**

**Бүлэг 1:** Ерөнхий тойм

**Бүлэг 2:** Удиртгал

**Бүлэг 3:** Судалгааны аргачлал, ойлголт, тодорхойлолт

**Бүлэг 4:** Өрхийн хүн ам зүйн үзүүлэлтүүд

**Бүлэг 5:** Хүүхдийн хүн ам зүйн үзүүлэлтүүд

**Бүлэг 6:** Ажил эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр

**Бүлэг 7:** Хүүхдийн хөдөлмөр, түүнийг эрхлэх болсон шалтгаан

**Бүлэг 8:** Хүүхдийн ажил эрхлэлт, улирал болон бүс нутгаар

**Бүлэг 9:** Дүгнэлт

Бүлэг 1-д ерөнхий тойм, Бүлэг 2-т Монгол Улсын хүн ам зүй, эрүүл мэнд, боловсрол, эдийн засгийн талаар танилцуулж, судалгааны үндэслэл зорилт, бүтцийг тодорхойлсон бол Бүлэг 3-т судалгааны аргачлал, түүвэрлэлт, ойлголт, тодорхойлолтыг, Бүлэг 4-т АХС-ны цуглуулсан тоо мэдээнд үндэслэн өрх болон судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн талаарх зарим үндсэн үзүүлэлтийг тооцсон дүнг, Бүлэг 5–д судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн талаарх зарим үр дүнг, Бүлэг 6-д тухайн үеийн эдийн засгийн идэвхи болон байнгын эдийн засгийн идэвхийн аргачлалаар хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн талаар цуглуулсан холбогдох мэдээллийг ажилласан

цаг, ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тооцсон дүнг, Бүлэг 7-д ОУХБ-аас 2002[8] онд гаргасан Хүүхдийн хөдөлмөрийн тооцоонд хэрэглэсэн олон улсын тодорхойлолтын дагуу хүүхдийн хөдөлмөрийг зарим үзүүлэлтээр тооцон гаргаж, хүүхдийг хөдөлмөр эрхлэхэд хүргэж буй шалтгаан, хөдөлмөр эрхэлснээр хүүхдэд учирч буйүр дагаврын талаар мэдээлэл цуглуулж тооцсон дүнг, Бүлэг 8-д хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийг улирал болон бүс нутгаар харуулсан бол Бүлэг 9-д судалгааны дүгнэлт, бодлогын зөвлөмжүүдийг тусгасан болно.

[8] *Хүүхдийн Хөдөлмөрийн Тоо Мэдээ, Дэлхийн Хэмжээнд, ОУХБ/ХХУОУХ-ХХС, Женев хот, 2002 оны 4-р сар.*

Бүлэг 3

# СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ, ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ

### 3.1 Удиртгал

Энэ бүлэгт 2002-2003 оны Монгол Улсын Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа (МХХС)-нд ашигласан аргачлал, ойлголт, тодорхойлолт болон тоо мэдээ цуглуулах, боловсруулах үе шатуудын талаар танилцуулав. Мөн түүнчлэн МХХС-ны хамрах хүрээг дэлгэрэнгүй танилцуулахын зэрэгцээ түүврийн дизайн, тооцоог хийх, судалгааны асуулга боловсруулах, ахлагч, тоологч нарыг сургах, судалгаа авах заавар боловсруулах үе шатууд болон мэдээлэл боловсруулалт, тооцооны төлөөлөх чадварын талаар товч дурьдав.

### 3.2 Судалгааны хамрах хүрээ

Ажиллах хүчний 2002-2003 оны судалгаатай хамтран явуулсан энэхүү судалгаа нь хүүхдийн хөдөлмөрийн талаарх бодит тоо мэдээг улсын хэмжээнд болон хот, хөдөө, бүс нутгаар цуглуулан тооцох зорилгоор явагдсан. Өрхийг түшиглэн явуулсан тул өрхийн 5-17 насны хүүхдүүд хамрагдаж асуулганд хариулсан болно. Харин гэр оронгүй, хараа хяналтгүй хүүхдүүд болон засан хүмүүжүүлэх газар, асрах газар, халамжийн төв зэрэг нийтийн байранд амьдарч буй хүүхдүүд хамрагдаагүй. Энэхүү судалгаа нь бие даасан судалгаа тул үндсэн үзүүлэлтүүдийг бүс нутгаар тооцож болохуйц хэмжээнд түүвэр болон хамрах хүрээг тогтоосон бөгөөд 5-17 насны хүүхдүүдийн эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагааны талаар аль болох олон үзүүлэлтийг тооцоход чиглэгдсэн.

МХХС-нд АХС-ны түүврийн дизайныг ашигласан. Үүнд: нийт улсын хэмжээнд 12,800 өрхийг түүвэрлэн авч Улаанбаатар хот, 4 бүс нутаг (Төв, Баруун, Зүүн, Хангай), хот, хөдөө гэсэн 9 шатлалаар тархаан хүүхдийн хүн ам зүйн болон хүүхдийн хөдөлмөр, хүүхдийн эдийн засгийн идэвхийн талаарх үзүүлэлтүүдийг тооцсон. Тоо мэдээллийг сар бүр цуглуулан, улирлаар үр дүнг нь нэгтгэсэн ба улирал тутамд нийт түүвэрлэгдсэн өрхийн дөрөвний нэг нь ногдож байв. Нийт 12 сар буюу бүтэн жилээр нэгтгэн тооцож гаргасан тоо мэдээ, үзүүлэлтүүдийг энэхүү тайланд тусгахын зэрэгцээ улирлын хэлбэлзлийг харуулах зорилгоор зарим тоо мэдээг улирлаар тооцсон.



Судалгааны түүврийн хүрээг Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогод үндэслэн тогтоож, сонгогдсон тооллогын нэгжүүдийн өрхийн жагсаалтыг шинэчилж байсан. Дотуур байр, цэргийн хуаран, засан хүмүүжүүлэх газар зэрэг нийтийн байрыг түүврийн хүрээнд хамруулаагүй. Ажиллах хүчний 2002-2003 оны судалгааны тайланд түүврийн дизайн, аргачлал, тооцооны талаар дэлгэрэнгүй өгүүлсэн. Энэ тайлангийн *Хүснэгт 3.1*-д нийт

түүвэрлэгдсэн 12,800 өрхийн тархаалтыг хот, хөдөө, Улаанбаатар хот, дөрвөн бүс нутгаар харуулсан бол *Хүснэгт 3.2*-т улирлын түүврийн тархаалтыг, бүсээр харуулав. Холбогдох тоо мэдээллийг 2002 оны 10-р сараас 2003 оны 9-р сарыг дуусталх хугацаанд цуглуулсан.

Хоёр шатлалт түүврийн аргыг судалгаанд хэрэглэсэн. Эхний шатанд тооллогын нэгж, хоёр дахь шатанд түүвэрлэгдсэн анхан шатны нэгж дэх өрхийг сонгосон. Эхний шатанд түүврийн анхан шатны нэгж (ТАШН)-ийг хэмжээнд нь пропорциональ магадлалт түүврийн аргаар, хоёр дахь шатанд сонгогдсон ТАШН бүрээс өрхийг энгийн санамсаргүй системчилсэн цикл түүврийн аргаар сонгосон. Тооллогын нэгж бүр нь санамсаргүй аргаар сонгогдсон 10 өрхөөс бүрдэж байв.

*Хүснэгт 3.1.* ***Бүс нутагт ногдох түүврийн хэмжээ***

| | Бүс | Байршил | | | | Бүгд | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хот | | Хөдөө | | | |
| | | ТН | Өрх | ТН | Өрх | ТН | Өрх |
| (0) | (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) |
| 1 | Улаанбаатар | 320 | 3,200 | — | —— | 320 | 3,200 |
| 2 | Төв | 80 | 800 | 160 | 1,600 | 240 | 2,400 |
| 3 | Зүүн | 80 | 800 | 160 | 1,600 | 240 | 2,400 |
| 4 | Баруун | 80 | 800 | 160 | 1,600 | 240 | 2,400 |
| 5 | Хангай | 80 | 800 | 160 | 1,600 | 240 | 2,400 |
| | Дүн | 640 | 6,400 | 640 | 6,400 | 1,280 | 12,800 |

*Хүснэгт 3.2.* ***Улирлын судалгаанд хамрагдсан тооллогын нэгж болон өрх, бүсээр***

| | Бүс | Байршил | | | | Бүгд | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хот | | Хөдөө | | | |
| | | ТН | Өрх | ТН | Өрх | ТН | Өрх |
| (0) | (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) |
| 1 | Улаанбаатар | 80 | 800 | — | —— | 80 | 800 |
| 2 | Төв | 20 | 200 | 40 | 400 | 60 | 600 |
| 3 | Зүүн | 20 | 200 | 40 | 400 | 60 | 600 |
| 4 | Баруун | 20 | 200 | 40 | 400 | 60 | 600 |
| 5 | Хангай | 20 | 200 | 40 | 400 | 60 | 600 |
| | Дүн | 160 | 1,600 | 160 | 1,600 | 320 | 3,200 |

Гэвч өрх эзгүй байсан зэрэг шалтгаанаар зарим тооллогийн нэгжийн сонгогдсон өрх бүр судалгаанд хамрагдаж чадаагүй. Судалгаанд нийт 12787 өрх хамрагдаж мэдээлэл өгсөн.

## 3.3 Тооцооны үе шат

Түүврийн үндсэн дээр тооцсон ихэнх тооцоо нь хувийн жингийн үзүүлэлт байдаг хэдий ч бүлгүүдийн хувьд тооцогдсон нийлбэрийн утга нь бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарт шаардлагатай байдаг. Тооцооны үе шатыг доор үзүүлэв[9].

### 3.3.1 Түүврийн жин

Түүврийн жин нь бүлгүүдийн хувьд хийгдсэн ялгаатай түүвэрлэлтийг засварлах ба түүврийн магадлалын урвуу үзүүлэлт юм.

[9] *Тооцооны арга зүйг Ажиллах хүчний 2002-2003 оны судалгааны дэлгэрэнгүй тайлангаас харна уу.*

***h*** бүлгээс $j^{th}$ өрхийг энгийн санамсаргүй түүврийн аргаар түүвэрлэх магадлал нь

$$p_h^{(i)} \times p_h^{(j/i)} = p_h^{(ij)}$$

үүнд $p_h^{(i)} = a_h M_{hi} / M_h$ ба $p_h^{(j/i)} = n_h / M_{hi}^{*}$

Өрх бүрийн хувьд тооцогдох түүврийн жин нь $w_{hij}$

$$w_{hij} = 1 / p_h^{(ij)}$$

$$= \frac{M_h \times M_{hi}^{*}}{a_h \times M_{hi} \times n_h}$$

Ажиллах хүчний судалгааны түүвэрлэлтийн загвар нь бие даасан жигнэсэн байдлаар хийгдээгүй учраас түүврийн анхан шатны нэгж тутамд (тооллогын нэгж) түүврийн жинг тооцох, улмаар тооцоололт хийхдээ түүврийн жинг ашиглах шаардлагатай.

### 3.3.2 Өрхийн тоо мэдээллийг ашиглан тооцоо хийх

**"y"** үзүүлэлтийн бүлгүүдийн нийлбэрийг тооцохдоо доорхи томьёог ашиглана.

$$\hat{Y}_h = \sum_i \sum_j w_{hij}\, y_{hij} \qquad \text{for} \quad i = 1, 2, 3, \ldots\ldots\ldots\ldots a_h \quad j = 1, 2, 3, \ldots\ldots\ldots n_{hi}$$

үүнд

$\hat{Y}_h$ = **"h"** бүлгийн ***"y"*** үзүүлэлтийн тооцооны утга

$y_{hij}$ = **"h"** бүлгийн "i" тооллогын нэгж дэх ***"j"*** дэх өрхийн ***k*** хүний хувьд тодорхойлогдсон утга

$n_{hi}$ = ***i*** тооллогын нэгж дэх түүвэрлэгдсэн өрхийн тоо

$a_h$ = ***h*** бүлэгт түүвэрлэгдсэн тооллогын нэгжийн тоо

$w_{hij} = 1 / f_h$

$f_h = 1 / w_{hij}$

Бүх 9 бүлгийн ***Y*** нийт утгыг тооцохдоо бүлэг тус бүрийн тооцооны нийт утгыг нэмнэ.

$$\hat{Y} = \sum \hat{Y}_h \qquad h = 1, 2, 3, \ldots.9.$$

АХС болон МХХС-ны ихэнх тооцооны үзүүлэлт нь хувийн жин болон дундаж утга болно. Бүлгийн тооцооны дундаж, харьцааны утга нь доорх байдлаар илэрхийлэгдэнэ.

$$r_h = \frac{\hat{Y}_h}{\hat{X}_h} = \frac{\sum_i \sum_j w_{hij}\, y_{hij}}{\sum_i \sum_j w_{hij}\, x_{hij}}$$

үүнд

$y_{hij},\ a_h,\ n_{hi},\ w_{hij}$ -ийг өмнө нь тайлбарласан болно.

ба $x_{hij} = 1$ for $j = 1, 2, 3, \ldots\ldots\ldots n_{hi}$

$i = 1, 2, 3, \ldots\ldots\ldots a_h$

Ерөнхий олонлогийн дундаж нь харьцаа **r** байх бөгөөд доорх байдлаар илэрхийлэгдэнэ.

$$r = \frac{\sum_h \sum_i \sum_j w_{hij}\, y_{hij}}{\sum_h \sum_i \sum_j w_{hij}\, x_{hij}}$$

### 3.3.3 Вариаци болон стандарт алдааны тооцоо

Судалгааны үр дүнгийн нарийвчлал, төлөөлөх чадварыг гаргах нь тооцооны нэг зайлшгүй хэсэг юм.

Үзүүлэлтийн вариацыг тооцох томьёо нь:

$$var(r) = 1 / X^2 \sum (1 - f_h)\ (a_h / a_h - 1) \sum (z_{hi}^2 - z_h^{\ 2} / a_h)$$

үүнд

$r = y / x$

$$y_{hi} = \sum_j w_{hij}\, y_{hij}$$

$$x_{hi} = \sum_j w_{hij}\, x_{hij} = \sum_j w_{hij}\, x_{hij}$$

$$r = \sum\sum\sum w_{hij}\, y_{hij} \,/\, \sum\sum\sum w_{hij}\, x_{hij}$$

$$x^2 = X^2 \hat{=} \Big( \sum_h \sum_i \sum_j w_{hij}\, x_{hij} \Big)^2$$

$$z_{hi} = y_{hi} - r\, x_{hi}$$

$a_h$ = ***h*** бүлэг дэх сонгогдсон тооллогын нэгжийн тоо

$w_{hij}$ = түүвэрт сонгогдсон өрхийн жин

***h*** бүлгээс харьцааны үзүүлэлт $\boldsymbol{r_h}$ вариацыг тооцох томьёо нь:

$$var(r_h) = (1 / x_h^{\ 2})(1 - f_h)\ (a_h / a_h - 1) \sum (z_{hi}^{\ 2} - z_h^{\ 2} / a_h)$$

Үүнд:

$$\hat{X}_h = x_h = \sum_i \sum_j w_{hij} \, x_{hij}$$

$f_h$, $a_h$, ба $z_{hi}$ -ийг өмнө нь тайлбарласан болно.

Судалгааны үр дүнгийн стандарт алдаа нь нэлэнхүй судалгааны аргаас бус түүврийн аргаар цуглуулсан мэдээллийн түүврийн тооцооны утга ерөнхий олонлогийн бодит утгаас хэр зэрэг хэлбэлзэж байгааг илэрхийлнэ. Стандарт алдааг **se(r)** түүврийн үндсэн дээр тооцохдоо дараах томъёог ашиглана.

$$se(r) = var(r)^{1/2}$$

Харьцангуй стандарт алдаа буюу вариацын коэффициент нь **cv**, түүврийн тооцооны утгын вариацын харьцангуй утгыг илэрхийлэх ба өөрөөр хэлбэл түүврийн алдаа нь тооцооны утгатайгаа харьцуулахад ямархуу далайцтай байна гэдгийг үзүүлнэ. Дундаж, харьцаа гэх мэт үзүүлэлтийн тооцооны утгын далайц, хэмжих нэгж нь өөр өөр байдгаас хамааран тухайн судлагдаж байгаа үзүүлэлтийн талаар хийгдсэн янз бүрийн судалгааны үр дүнгийн стандарт алдаануудыг шууд харьцуулах боломжгүй учраас **cv** буюу пропорциональ алдаа нь төлөөлөх чадварыг харьцуулах боломж олгодог. Вариацын коэффициентыг доорхи аргаар тооцно.

$$cv(r) = se(r)/r.$$

АХС болон МХХС-гаар тооллогын нэгжүүдийг түүвэрлэн авсан болохоор тооцооны утгуудын стандарт алдааг тооцох шаардлагатай. Стандарт алдаа нь нийт тооллогын нэгжийг судалгаанд хамруулахгүй зөвхөн тодорхой хэсгийг хамруулсанаас шалтгаалан гарах тооцооны утгын хэлбэлзлийг илэрхийлнэ. Түүврийн алдааг тооцохдоо түүврийн дизайн еффект буюу түүврийн аргын нөлөөллийг тооцдог бөгөөд энэ нь энгийн санамсаргүй түүврийн хувьд бодогдсон болон тухайн судалгааны түүврийн аргын хувьд тооцогдсон түүврийн вариацын харьцаа юм. Түүврийн аргын нөлөөллийн утга нь судлагдаж байгаа юмс үзэгдлийн тухайн бүлэг дотроо хэр зэрэг нэгэн жигд байгаагаас хамаарах бөгөөд энэхүү жигд байх нь багцын хэмжээнээс хамаарна. Түүврийн аргын нөлөөллийн утга нь стандарт алдаануудын харьцаагаар буюу тухайн түүврийн аргаар хийгдсэн судалгааны хувьд тооцсон түүврийн алдааг энгийн санамсаргүй түүврийн аргаар судалгааг хийсэн гэж таамаглан бодсон түүврийн алдаанд харьцуулж гаргах бөгөөд утга нь гол төлөв 1-ээс их байдаг ч хүн амын тоо, хүн амын орлого гэх мэт үзүүлэлтийн хувьд харьцангуй өндөр байдаг. Түүврийн хэмжээ, түүврийн арга нь стандарт алдааны далайц буюу хэр зэрэг их, бага байхыг тодорхойлох бөгөөд зарим үзүүлэлтийн хувьд түүврийн алдаа өндөр байх боломжтой бөгөөд эдгээр тоог ашиглахдаа анхааралтай байх хэрэгтэй.

### 3.4 Судалгааны бэлтгэл үе шат

Судалгааны бэлтгэл үе шатанд асуулга боловсруулах, тоологч, ахлагч нарыг сургах,

мэдээлэл цуглуулах, сурталчилгаа явуулах, мэдээлэл боловсруулах зэрэг ажлууд орно.

### 3.4.1 Асуулга

АХС+МХХС-ны асуулгыг боловсруулах үе шатны талаар Ажиллах хүчний 2002-2003 оны судалгааны тайланд дэлгэрэнгүй танилцуулсан. УИХ, НХХЯ, СЭЗЯ, ХЭГ, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо болон Үйлдвэрчний эвлэл, АХБ, ОУХБ-ын ХХУОУХ-ийн газар зэрэг дотоодын болон олон улсын байгууллагын төлөөлөгчдөөс бүрдсэн судалгааны Удирдах зөвлөлийг байгуулан ажиллуулж, судалгааны асуулгыг боловсруулах явцад бодлого боловсруулахад чухал ач холбогдол бүхий үзүүлэлтүүдийг гаргахад тэдний саналыг авч тусгасан. Энэ нь асуулгыг боловсруулахад судалгаанд төлөвлөсөн хөрөнгө нөөц, чадавхийн хэмжээг харгалзан үзэж, гол төлөөлөгч байгууллагуудын сонирхол, эрэлт хэрэгцээг тусгах ач холбогдолтой байсан юм. Асуулгын маягтыг энэхүү тайланд хавсаргав.

### 3.4.2 Ахлагч, тоологч нарын сургалт

Улсын хэмжээний энэхүү судалгааг чанартай сайн явуулах зорилгоор 2002 оны 10-р сарын эхээр судалгааны ахлагч, тоологч нарт зориулсан сургалтыг ҮСГ дээр зохион байгуулсан. Сургалтын үеэр хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн талаарх тоо мэдээг цуглуулахад ашиглагдах ойлголт, тодорхойлолт, асуулгын хуудасны бүтэц, зохион байгуулалт, асуулга авах аргачлал арга зүйн талаар төвлөрсөн сургалт хийв. Сургалтын эхний хэсэгт ойлголт, тодорхойлолт, асуулга, түүнийг хэрхэн авах талаар нэг бүрчлэн зааж, хэлэлцэн, хоёрдугаар хэсэгт асуулга авах дадлага сургуулилтыг хийлгэж, үр дүнг хэлэлцэн зөвшилцөж, тодруулга, тайлбар хийсэн. Ахлагч, тоологч нарыг сургалтын гарын авлагаар хангасан.

### 3.4.3 Тоо мэдээ цуглуулах, хяналт тавих

Улсын хэмжээнд нийт 1280 тооллогын нэгжийг (ТН) сонгон судалгааг явуулсан. Тооллогын нэгжийн газрын зураг, өрхийн жагсаалтыг



ашиглан түүвэрлэлт хийж, түүвэрлэгдсэн өрхийн жагсаалтыг улирал бүрээр гарган судалгааны ахлагч, тоологч нарт хүргүүлж байв. ҮСГ-ын АХС-ны ажлын хэсгийн ажилтнууд тоо мэдээлэл цуглуулах ажлын явцыг нийт 13 аймаг болон Улаанбаатар хотод хянаж шалган, гарсан ололт, дутагдлыг тухай бүр нь танилцуулж, шаардлагатай арга хэмжээ авч ажилласан.

### 3.4.4 Сурталчилгааны арга хэмжээ

Судалгаанд хамрагдсан өрхийн сонирхол, идэвхийг өрнүүлэх, судалгааны талаар тодорхой ойлголт, мэдээллийг олон нийтийн дунд бий болгоход чиглэсэн сурталчилгааны арга хэмжээг судалгаа эхлэхийн өмнөхөн

зохион байгуулсан. ҮСГ-ын Даргын гарын үсэгтэй захидлыг сонгогдсон өрхүүдэд илгээж, судалгааны зорилтын талаар мэдээлж, идэвхитэй оролцон мэдээлэл өгөхийг хүссэнээс гадна орон нутгийн удирдлагад урьдчилан мэдээлэл өгч байв.

### 3.4.5 Мэдээлэл боловсруулалт

Судалгааны тоо мэдээллийг цуглуулах, кодлох, анхан шатанд шалгаж, шивэх ажлыг судалгааны ахлагч, тоологчид гүйцэтгэсэн. Ахлагч, тоологч нараас ирүүлсэн тоо мэдээ, ажил мэргэжлийн ангилал, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын кодлолт зэрэг үзүүлэлтүүдийг ҮСГ дээр давхар хянан алдааг засварлаж байв. Мэдээллийг шалгасны дараагаар ҮСГ-ын мэдээлэл боловсруулах нэгжийнхэн мэдээллийн уялдаа холбоо, алдаа зэргийг программд уншуулан эцсийн засварыг хийсэн. Үүний дараагаар улсын хэмжээнд төлөөлөхүйц тоо мэдээ гаргах зорилгоор нийт дүнд тархаан үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулж гаргав.

## 3.5 Түүврийн жин, стандарт алдаа

Тооцооны төлөөлөх чадварт үнэлгээ өгөхийн тулд 2002-2003 оны МХХС-ны үндсэн параметрүүд, стандарт алдаа, вариацын коеффициентийг тооцож *Хүснэгт 3.3*-т үзүүлэв. 2002-2003 оны МХХС-нд хамрагдсан 5-17 насны нийт 676,911 хүүхдийн 68,580 нь хөдөлмөр эрхэлж байгаа буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд байна. Өөрөөр хэлбэл 5-17 насны нийт хүүхдийн 10.1 хувь нь хөдөлмөр эрхэлж байна.

*Хүснэгт 3.3.* ***МХХС-ны зарим үзүүлэлтүүдийн стандарт алдааны тооцоо***

| Үзүүлэлт | Тооцооны утга | Стандарт алдаа | Вариацын коеффициент (%) | 95% итгэмжлэгдэх интервал Доод | 95% итгэмжлэгдэх интервал Дээд | Дизайн еффект (%) | Ажиг-лалтын тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) |
| Ажиллаж байгаа хүүхдийн тоо | 68,580 | 3,969 | 5.79 | 60,801 | 76,359 | 5.71 | 15,176 |
| Хүйсээр | | | | | | | |
| Хөвгүүд | 41,874 | 2,433 | 5.81 | 37,104 | 46,643 | 3.37 | 7,787 |
| Охид | 26,706 | 1,950 | 7.30 | 22,885 | 30,528 | 3.31 | 7,693 |
| Байршлаар | | | | | | | |
| Хот | 6,894 | 876 | 12.71 | 5,177 | 8,611 | 2.51 | 7,483 |
| Хөдөө | 61,686 | 3,871 | 6.28 | 54,099 | 69,274 | 5.97 | 7,693 |
| Бүсээр | | | | | | | |
| Баруун | 27,053 | 2,727 | 10.08 | 21,708 | 32,399 | 6.40 | 3,573 |
| Хангай | 26,231 | 2,587 | 9.86 | 21,161 | 31,302 | 5.93 | 2,954 |
| Төв | 9,858 | 1,114 | 11.30 | 7,674 | 12,042 | 2.86 | 2,808 |
| Зүүн | 3,904 | 465 | 11.91 | 2,993 | 4,815 | 1.24 | 2,482 |
| Улаанбаатар | 1,533 | 407 | 26.57 | 735 | 2,332 | 2.43 | 3,359 |
| Насны бүлгээр | | | | | | | |
| 05-09 | 15,320 | 1,659 | 10.83 | 12,068 | 18,571 | 4.11 | 4,823 |
| 10-14 | 21,407 | 1,721 | 8.04 | 18,034 | 24,779 | 3.19 | 6,527 |
| 15-17 | 31,854 | 1,615 | 5.07 | 28,689 | 35,018 | 1.92 | 3,826 |
| Ажиллаж байгаа хүүхдүүдийн сургуульд хамрагдалт | | | | | | | |
| Сургуульд сурч байгаа | 24,815 | 2,589 | 10.43 | 19,742 | 29,889 | 6.26 | 3,949 |
| Сургуульд суралцдаггүй | 43,765 | 2,394 | 5.47 | 39,072 | 48,458 | 3.13 | 11,227 |

2002-2003 оны МХХС-ны тоо мэдээг ашиглахдаа дараах зүйлийг харгалзан үзэх хэрэгтэй. Үүнд:

1. Хэлбэлзлийн коэффициент харьцангуй өндөр байгаа тул ажил, хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг бүс нутгаар тооцохдоо болгоомжтой хандах ёстой. Иймд дараачийн ХХС-ны түүврийн хэмжээг аймгийн түвшинд үр дүнг тооцож болохуйц хэмжээнд авах хэрэгтэй.

2. Түүврийн хэмжээ харьцангуй бага тул хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг ажил мэргэжил, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар тооцохдоо болгоомжтой хандах хэрэгтэй.

3. МХХС нь өрхөд суурилсан судалгаа тул дотуур байр, нийтийн байранд байгаа хүүхдүүд болон хараа хяналтгүй, тэнүүчлэн амьдарч байгаа хүүхдүүдийг (эсвэл янз бүрийн шалтгаанаар гэр орноосоо дайжин зугтсан) хамруулаагүй.

4. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг энэ судалгаагаар тодорхойлох боломжгүй байв. Иймд цаашид дахин мэдээлэл цуглуулан судлах шаардлагатай.

### 3.6 Ойлголт, тодорхойлолт

_Хүүхэд_: 1989 онд тунхагласан НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Конвенц, 1999 онд баталсан ОУХБ-ын Хүүхдийн Хөдөлмөрийн Тэвчишгүй Хөдөлмөрийн Конвенцэд (182) тодорхойлсноор 18-аас доош насны хүн амыг хүүхэд гэж үзнэ. 5 хүртэлх насны хүүхэд ажил хөдөлмөр эрхлэх, сурах насанд хүрээгүй, балчир гэж нийтээр хүлээн зөвшөөрсний дагуу МХХС-нд 5-17 насны хүүхдийг хамруулсан.

_Нас:_ Насыг тодорхойлохдоо бүтэн насаар авна. Төрсөн он, сар, өдрөөр тооцож бүтэн насыг тогтооно. Гэхдээ судалгаа авч байгаа өдрөөс буцааж тооцно.

_Хүүхдийн насны бүлэг:_ 2002-2003 оны МХХС-нд хүүхдийн насыг 5-9, 10-14 ба 15-17 гэж бүлэглэв.

_Ажил/Эдийн засгийн үйл ажиллагаа:_ НҮБ-ын 1993 оны ҮТС-ийн хүрээнд эдийн засгийн үйл ажиллагааг тодорхойлсоны дагуу цалин хөлс, ашиг орлого олох зорилгоор болон өөрсдийн хэрэглээндээ зориулан эрхэлж буй өрхийн аж ахуйн үйл ажиллагааг ажил гэж хэлнэ. Ажил нь цалин хөлстэй болон цалин хөлсгүй, албан болон албан бус хэлбэртэй байж болно. Жишээлбэл, өөрийн өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцож буй хүүхдийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байна гэж үзнэ. Түүнчлэн бусдын өрхийн аж ахуйд ажиллаж буй хүүхэд (гэрийн ажилд туслах зэрэг) эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу эдийн засгийн идэвхитэй гэж үзнэ. Харин өөрийн өрхөд гэрийн ажил хийхэд оролцож буй хүүхдийг эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн буюу эдийн засгийн идэвхигүй гэж үзнэ.

_Эдийн засгийн бус үйл ажиллагаа:_ Өөрийн өрхийн гэрийн ажилд оролцож буй хүүхэд нь

эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн буюу эдийн засгийн идэвхигүйд тооцогдоно. Үүнд:

- Гэр орон цэвэрлэх, хувцас бусад нэхмэл, сүлжмэл эдлэл оёх, арчлах;
- Хувцас угаах, индүүдэх, гэр байшин, эд хогшил сэргээн засах;
- Хоол унд хийх, аяга таваг угаах;
- Хүүхэд асрах;
- Өвчтэй хүн, өндөр настангуудыг асрах
- Гэрийнхээ хэрэгцээт зүйлийг худалдаж авах, дэлгүүр явах.

*__Ажиллагч:__* Ажиллагч гэдэг нь ажиллах хүчинд хамаарагдах тухайн хугацаанд ажил, хөдөлмөр эрхэлж байгаа болон тухайн долоо хоногт ажил эрхлээгүй ч ажилтай байсан хүнийг хэлнэ. Тухайн хугацаанд (сүүлийн долоо хоногт) ямар нэг байдлаар ажил хөдөлмөр эрхэлсэн (нэг цагаас дээш хугацаагаар) хүнийг ажилтай гэнэ. Өвчлөл, гэмтэл, амралт, чөлөө, цаг агаарын таагүй байдал, ажил хаялт болон бусад шалтгаанаар түр хугацаагаар ажил эрхлэхгүй байгаа ч ажилтай, бизнес эрхэлдэг бол тухайн хүнийг ажиллагч гэж үзнэ.

*__Өрх:__* Өрх гэдэг нь байнга хамтран амьдарч, орлогоо нэгтгэн хоол хүнсээ бэлтгэж, нэг тогооноос хоол иддэг нэг буюу хэд хэдэн хүмүүсийг хэлнэ. Эдгээр хүмүүс нь хамаатан садан болон ажил олгогчтойгоо хамтран амьдардаг, цусан төрлийн хамааралгүй, гэрийн үйлчлэгч, бусад хөлсний ажилчид ч байж болно.

*__Өрхийн тэргүүлэгч:__* Өрхийн тэргүүлэгч гэдэг нь бусад гишүүд нь өрхийн тэргүүн хэмээн хүлээн зөвшөөрсөн, насанд хүрсэн, өрхийн гишүүн юм. Хэрвээ тухайн сууцанд нэгээс олон өрх амьдран сууж байвал төдий тооны өрхийн тэргүүн байна.

*__Судалгааны тайлант хугацаа :__* Судалгааны тайлант хугацаа нь 2002 оны 10-р сараас 2003 оны 9-р сарыг дуусталх хугацааг хамарна.

*__Хүүхдийн хөдөлмөр:__* ОУХБ-аас 1973 онд баталсан Хөдөлмөрийн Насны Доод Хязгаарыг Тогтоох Конвенц (138)-д үндэслэн хүүхдийн хөдөлмөрийг тодорхойлно. Энэ конвенцид ажил, хөдөлмөр буюу "эдийн засгийн үйл ажиллагаа" эрхлэх насны доод хязгаарыг дэлгэрэнгүй тодорхойлон заасан. МХХС-нд 18-аас доош насны эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу эдийн засгийн идэвхитэй хүүхдүүдийг хамруулсан. Харин (1) тав хүртэлх насны хүүхэд, (2) долоо хоногт 14-өөс доош цагийг хүнд хэцүү, хортой бус нөхцөлд ажил хийхэд зарцуулж буй 12-14 насны хүүхдүүдийг хамруулахгүй. Хүүхдийн хөдөлмөрийг тооцохдоо тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй 15-17 насны хүүхдийг (хүнд хэцүү, хортой нөхцөлд хөдөлмөр эрхэлж буй хүүхэд, ажлын нөхцөл нь хүнд хэцүү, хортой бус боловч долоо хоногт 43 болон түүнээс дээш цагаар ажиллаж буй хүүхэд зэрэг) оруулна.

*__Хөдөлмөр эрхэлж буй/эдийн засгийн идэвхитэй/ажиллаж буй хүүхэд:__* 2002-2003 оны МХХС-д энэ гурван нэр томьёо ижил утгатай хэрэглэгдэж байгаа. Сүүлийн 7 хоногт нэг болон түүнээс дээш цагаар орлого олох зорилгоор бусдад хөлслөгдөн ажилласан эсхүл өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй оролцсон, мөн ажлын байртай боловч сүүлийн 7 хоногт

ажиллаагүй хүүхдийг тухайн үед хөдөлмөр эрхэлсэн гэж үзнэ.

_Эдийн засгийн идэвхигүй хүүхэд:_ Эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй, зөвхөн гэрийн ажилд оролцож тусалсан хүүхдийг эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзэн хүүхдийн хөдөлмөрийг тооцоход оруулахгүй.

_Хувиараа хөдөлмөр эрхлэгч хүүхэд:_ Бусдын оролцоогүйгээр ашиг, орлого олох зорилгоор аж ахуй эрхлэх, эсвэл ажиллаж буй хүүхдийг хэлнэ.

_Ажил олгогч:_ Өөрийн ажил мэргэжлээс үл хамааран нэг болон түүнээс дээш ажиллагчидтай аж ахуйн нэгж, хамтарсан үйлдвэрийг удирдаж байгаа хүн. Энэ судалгаанд гэрийн ажлыг бусдаар цалин хөлстэйгээр хийлгэж байгаа хүнийг ажил олгогч гэж үзнэ.

_Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч:_ Өрхийн аж ахуйн нэгжид цалин хөлсгүйгээр нэг цагаас доошгүй ажилласан хүн. Ялангуяа хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуурын салбарт өрхийн аж ахуй зонхилж байдаг тул цалин хөлсгүй оролцогч их байдаг. Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүүхдүүдийг хөдөлмөр эрхэлсэн гэж үздэг.

_Ажилгүй хүн:_ Ажиллах хүчинд хамаарагдах тухайн хугацаанд ажил, хөдөлмөр эрхлээгүй байгаа болон тухайн долоо хоногт ажил эрхлээгүй боловч ажил эрхлэхэд бэлэн байсан, ажил хөдөлмөр идэвхитэй хайсан хүнийг хэлнэ. Ажил хөдөлмөр эрхлээгүй ч ажил эрхлэх боломжтой байгаа, ажилд орох өргөдлөө өгсөн болон ярилцлаганд орохоор хүлээж байгаа хүнийг мөн ажилгүй хүн гэж тодорхойлно.

_Эдийн засгийн идэвхитэй хүн ам:_ Ажиллагчид болон ажилгүйчүүдийн нийлбэрийг ажиллах хүчин гэнэ. Ажиллах хүчин нь эдийн засгийн идэвхитэй хүн амтай нэг утгатай тул энэ хоёр нэр томьёо бие биенээ орлон ашиглагдаж болно.

_Хүүхдийн эдийн засгийн идэвхийн оролцооны түвшин:_ эдийн засгийн идэвхитэй хүүхдийн тоог 5-17 насны нийт хүүхдийн тоонд харьцуулж гаргана.

_Ажилласан цаг:_ Сүүлийн 7 хоногт ажилласан нийт цаг. Хүүхэд нэгээс илүү тооны ажил хийсэн бол бүх ажлыг хийхэд зарцуулсан цагийг хооронд нь нэмж нийт ажилласан цагийг тооцно.

_Ажил мэргэжил:_ Цалин, хөлс, орлого олох зорилгоор тухайн хүний хийж гүйцэтгэж буй эдийн засгийн үйл ажиллагааны ажил, мэргэжлийн төрлийг ажил, мэргэжил гэнэ. Хэрвээ тухайн хүн ажилгүй байгаа бол эрхлэхэд бэлэн байгаа ажил, мэргэжлийн төрлийг тухайн хүний ажил, мэргэжил гэж үзнэ.

_Үндсэн ажил:_. Тухайн хугацаанд нэгээс олон ажил цалинтай буюу хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бол нийгмийн болон хууль зүйн тал, цалин хөлсний хэмжээ, ажиллаж байгаа цагаас хамааруулан үндсэн ажлыг тодорхойлно. Хэрвээ хүүхэд нэгээс илүү ажил гүйцэтгэсэн бол хамгийн их цаг зарцуулсан ажлыг үндсэн ажилд тооцно. Хэрвээ адил

хэмжээний цаг зарцуулсан бол хамгийн их орлого оруулж буй ажлыг үндсэн ажилд тооцно.

*Эдийн засгийн үйл ажиллагааны салбар:* Тухайн хүний ажиллаж байгаа ажлын байр, үйлдвэрийн газар, байгууллагын үйлдвэрлэдэг үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний төрлөөр тодорхойлогдоно. Олон Улсын Стандарт Ангилал 3-т нийцрүүлэн боловсруулсан "Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал"-ыг ашигласан.

*Хүнд хүчир, хортой ажил:* Хүүхдийн аюулгүй байдал, эрүүл мэнд, ес суртахуун, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх аливаа ажил, үйл ажиллагааг хэлнэ. Илүү цагаар их ачаалалтай ажиллаж байгаа бол хүнд хүчир, хортой нөхцөлд ажиллаж байна гэж үзнэ. Иймд долоо хоногт 43 болон түүнээс илүү цаг ажиллаж буй 18 наснаас доошхи насны хүүхдийг хүнд хүчир, хортой нөхцөлд ажиллаж байгаад тооцно.

*Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд (ХХТХ):* Үүнд:

- Хүүхдийг худалдаалах, хил дамжуулан наймаалах, өрийн барьцаа болгох, албадан хүчээр хөдөлмөрлүүлэх, зэвсэгт мөргөлдөөнд ашиглах;
- Хүүхдийг биеийг нь үнэлүүлэх, садар самуунд татан оруулах;
- Хүүхдийг хууль бус үйл ажиллагаанд татан оруулах, тухайлбал мансууруулах бодис, хар тамхи үйлдвэрлэх, наймаалах.

Бүлэг 4

# ӨРХИЙН ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

### 4.1 Удиртгал

Энэ бүлэгт судалгаанд хамрагдсан нийт өрхийн гишүүдийн хүн ам зүй, өрхийн бүтэц, боловсрол, сургуульд хамрагдалт зэрэг үзүүлэлтүүдийг танилцуулж байна. Эдгээр үзүүлэлт нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал болон хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийг тодорхойлоход чухал ач холбогдолтой. Судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийг байршил, нас, хүйсийн бүтэц зэрэг хүн ам зүйн талаас судлан тооцохын хамт ядуурал, хүүхдийн аж байдлыг тооцоход чухал үзүүлэлт болдог өрх толгойлсон эмэгтэйчүүдийг судалсан. Мөн өрхийн гишүүдийн боловсрол, сургуульд хамрагдалт, бичиг үсгийн мэдлэгийн түвшинг тооцов. АХС+МХХС-нд нэг асуулга ашиглан мэдээлэл цуглуулсан тул энэхүү бүлгийг 2002-2003 оны АХС-ны тайланд үндэслэн бичсэн болно.

### 4.2 Хүн ам зүйн үзүүлэлтүүд

2002-2003 оны АХС+МХХС–гаар хүн амын нас, хүйс, өрхийн бүтэц, сургуульд хамрагдалт, боловсрол, гэрлэлт зэрэг судалгаанд хамрагдсан өрхийн гишүүдийн хүн ам зүйн үзүүлэлтүүдийг тооцов. Судалгаанд хоёр шатлалт санамсаргүй түүврийн аргыг ашигласан тул хүн ам зүйн үзүүлэлтүүдийг хот, хөдөөгөөр дөрвөн бүс нутаг ба Улаанбаатар хотоор тооцож гаргасан. Нийт дөрвөн улирлыг хамран хангалттай хэмжээнд түүвэрлэлтийг[10] хийсэн тул үзүүлэлтүүдийг нийслэл хот, бүс нутаг, хот, хөдөөгөөр тооцох боломжтой байв. Дөрвөн улирлаар нэгтгэсэн тоо мэдээ, үзүүлэлтүүдийг дээрх ангиллаар тооцсон үр дүнгийн хүснэгтүүдийг боловсруулснаас гадна улирал тус бүрээр мөн боловсруулан гаргасан болно.



#### 4.2.1 Хүн амын байршил

2002-2003 оны АХС+МХХС-ны түүврийн тархаалтаас харахад Монголын нийт хүн ам 2.403 мянга байгаагийн 174 мянга нь 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа хүмүүс байна. Судалгаанд хамрагдсан өрхүүд эдгээр хүмүүсийг өрхийн гишүүдэд тооцож байв. Судалгаагаар нийт 568,800 өрх байгаа бөгөөд өрхийн ам бүлийн дундаж тоо 4.2 байна. Өрхийн ам бүлийн тоог тооцохдоо дотуур байр, цэргийн хуаран, асран хүмүүжүүлэх газар, эмнэлэг зэрэг нийтийн байранд амьдарч буй хүмүүсийг оруулаагүй. *Хүснэгт 4.1*-д өрх, хүн амын тоог хот, хөдөө, бүс нутгаар харуулав. Хот, суурин газарт нийт хүн амын 52.3 хувь буюу 1.256 мянган хүн амьдарч байна. Өрхийн ам бүлийн тоо хөдөө орон нутагт өндөр 4.4 байхад харин нийт өрхийн

*[10] Судалгааны мэдээллийг 2002 оны 10 дугаар сараас 2003 оны 9 дүгээр сарыг дуустал хугацаанд 4 улирлаар цуглуулав. Судалгааны эхний буюу 1 дүгээр улиралд 2002 оны 10-12-р сар, судалгааны 2 дугаар улиралд 2003 оны 1-3-р сар, судалгааны 3 дугаар улиралд 2003 оны 4-6-р сар, харин судалгааны сүүлийн буюу 4 дүгээр улиралд 2003 оны 7-9-р сарууд хамрагдсан болно.*

бараг 30.0 орчим хувь нь төвлөрсөн Улаанбаатар хотод 3.9 байна. Хүн амын тоо бүс нутгаар ялгаатай байгаа бөгөөд зүүн бүс нутагт нийт хүн амын ердөө 8.4 хувь нь амьдарч байна.

*Хүснэгт 4.1.* ***Өрх, хүн амын тоо, байршил, бүсээр***

| Байршил/ Бүс | Өрх | | Хүн ам | Өрхөөс түр гадуур байгаа | Нийт хүн ам* | | Өрхийн ам бүлийн дундаж тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | % | Тоо | Тоо | Тоо | % | |
| Хот | 311,000 | 54.7 | 1,198,300 | 57,800 | 1,256,100 | 52.3 | 4.0 |
| Хөдөө | 257,800 | 45.3 | 1,030,500 | 116,200 | 1,146,700 | 47.7 | 4.4 |
| Төв | 114,700 | 20.2 | 445,300 | 36,300 | 481,600 | 20.0 | 4.2 |
| Зүүн | 48,500 | 8.5 | 173,000 | 30,000 | 203,000 | 8.4 | 4.2 |
| Баруун | 97,900 | 17.2 | 425,500 | 40,200 | 465,700 | 19.4 | 4.8 |
| Хангай | 138,900 | 24.4 | 541,800 | 55,800 | 597,600 | 24.9 | 4.3 |
| Улаанбаатар | 168,800 | 29.7 | 643,200 | 11,700 | 654,900 | 27.3 | 3.9 |
| Дүн | 568,800 | 100.0 | 2,228,800 | 174,000 | 2,402,800 | 100.0 | 4.2 |

*6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа өрхийн нишүүдийг оруулаад

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогоор цэргийн хуаран, засан хүмүүжүүлэх газар, асрах газар, дотуур байр, нийтийн байранд амьдарч байгаа 38,855 хүнийг оруулаад нийт 2.373 мянган хүн тоологдсон. Энэ тооллогын дүнгээс харахад нийт 541,000 өрхөд 2.338 мянган хүн амьдарч өрхийн ам бүлийн дундаж тоо 4.2 байв. Засаг захиргааны нэгжээр гаргуулан авдаг Хүн амын ажил эрхлэлтийн 2003 оны жилийн эцсийн тайлангийн дүнгээр суурин хүн амын тоо 2,488 мянга байна.

АХС-нд нийтийн байранд амьдрагчид болон 6 сараас дээш хугацаагаар эзгүй байгаа өрхийн гишүүдийг хамруулаагүй. *Хүснэгт 4.2*-т өрхөөс гадуур амьдарч буй хүн амын тоог хот, хөдөө, бүс нутгаар харуулав.

*Хүснэгт 4.2.* ***6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур байгаа өрхийн гишүүдтэй өрхийн тоо, хот, хөдөө, бүсээр***

| Хот, хөдөө/ Бүс | Өрхийн тоо | Өрхийн гишүүдийн тоо | Өрхөөс гадуур амьдарч байгаа хүний тоо | Үүнээс: | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Суралцаж байгаа | Ажиллаж байгаа | Бусад |
| Хот | 36,500 | 131,400 | 57,800 | 32,200 | 19,100 | 6,500 |
| Хөдөө | 64,600 | 245,500 | 116,200 | 88,800 | 15,500 | 11,900 |
| Төв | 20,800 | 75,000 | 36,300 | 25,000 | 8,000 | 3,300 |
| Зүүн | 15,400 | 52,000 | 30,000 | 21,800 | 5,400 | 2,800 |
| Баруун | 24,700 | 106,600 | 40,200 | 28,700 | 5,900 | 5,600 |
| Хангай | 31,600 | 113,200 | 55,800 | 42,200 | 8,100 | 5,500 |
| Улаанбаатар | 8,600 | 30,100 | 11,700 | 3,300 | 7,200 | 1,200 |
| Дүн | 101,100 | 376,900 | 174,000 | 121,000 | 34,600 | 18,400 |

Ойролцоогоор 5 өрх тутмын нэг өрхийн аль нэг гишүүн нь өрхөөс гадуур амьдарч байгаа бөгөөд эдгээр өрхийн гишүүд судалгааны нийт хүн амын 7.0 хувийг эзэлж байгаа тул хүн амын тоо, байршлаар болон өрхийн ам бүлийн дундаж тоог тооцож гаргасан үр дүнд нөлөөлсөн. 121,000 хүн ямар нэг сургуульд суралцаж, 34,600 хүн ажил хийх шалтгаанаар өрхөөс гадуур амьдарч байна. Судалгаагаар 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч буй өрхийн гишүүдийн талаарх мэдээллийг цуглуулаагүй. Иймд тайланд орж байгаа хүснэгтүүд нь өрхөөс гадуур амьдарч байгаа цэргийн хуаран, засан хүмүүжүүлэх газар, асрах газар, дотуур байр болон нийтийн байранд амьдарч байгаа хүмүүс зэрэг 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдрагчдыг оруулаагүйгээр тооцсон хүн амын тоонд үндэслэн хийгдсэн тул судалгааны дүнг ашиглах, гүнзгийрүүлэн судлах явцад анхаарах нь зүйтэй. Судалгаанд хамрагдсан хүн амын тоог хот, хөдөө, бүс нутгаар тооцож дүнг нь *Хүснэгт 4.3*-т танилцуулж байна.

*Хүснэгт 4.3.* ***Өрх, хүн амын тоо, хот, хөдөө, бүсээр***

| Байршил/ Бүс | Өрх | | Өрхийн ам бүлийн дундаж тоо* | Бүгд | | Эрэгтэй | Эмэгтэй |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | % | | Тоо | % | % | % |
| Хот | 311,000 | 54.7 | 3.9 | 1,198,300 | 100.0 | 48.9 | 51.1 |
| Хөдөө | 257,800 | 45.3 | 4.0 | 1,030,500 | 100.0 | 50.5 | 49.5 |
| | | | | | | | |
| Төв | 114,700 | 20.2 | 3.9 | 445,300 | 100.0 | 49.6 | 50.4 |
| Зүүн | 48,500 | 8.5 | 3.6 | 173,000 | 100.0 | 50.8 | 49.2 |
| Баруун | 97,900 | 17.2 | 4.3 | 425,500 | 100.0 | 50.2 | 49.8 |
| Хангай | 138,900 | 24.4 | 3.9 | 541,800 | 100.0 | 49.9 | 50.1 |
| Улаанбаатар | 168,800 | 29.7 | 3.8 | 643,200 | 100.0 | 48.7 | 51.3 |
| | | | | | | | |
| Улсын дүн | 568,800 | 100.0 | 3.9 | 2,228,800 | 100.0 | 49.6 | 50.4 |

Тайлбар: * Энэ тооцоонд 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа хүмүүсийг оруулаагүй тул өмнөх хүснэгт 4.1-ээс ялгаатай байгаа юм.

### 4.2.2 Хүн амын нас, хүйсийн бүтэц

*Хүснэгт 4.4*-т судалгаанд хамрагдсан хүн амын нас, хүйсийн бүтцийг харуулав. 0-14 насны хүн ам 30.9 хувийг эзэлж байгаа бөгөөд хүйсээр нь авч үзэхэд эрэгтэйчүүдийн 32.1 хувь, эмэгтэйчүүдийн 29.8 хувь нь энэ насны бүлэгт хамрагдаж байна. 15-64 насны хүмүүс нийт хүн амын 65.3 хувийг, 65 ба түүнээс дээш насны хүмүүс 3.8 хувийг тус тус эзэлж байна. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын дүнгээс үзэхэд 0-14 насны хүүхэд нийт хүн амын 35.8 хувийг, 65 ба түүнээс дээш насны хүмүүс 3.5 хувийг эзэлж байв. Энэ судалгаанд 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч буй өрхийн гишүүдийг хамруулаагүй тул хүүхэд, залуучуудын эзлэх хувь доогуур гарсан байх талтай юм. Судалгаанд хамрагдаагүй өрхийн гишүүдийн бараг 70.0 хувь буюу 121,000 хүн нь сургууль, курст суралцагчид байна. *Хүснэгт 4.4*-өөс үзэхэд 20-24 наснаас дээш бүлэгт (60-64 насны бүлгийг оруулахгүйгээр) хүйсийн харьцаа 100-д хүрэхгүй болж байгаа нь эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдийнхээс өндөр байгаатай холбоотой. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогоор ч гэсэн насны бүтцэд ийм байдал ажиглагдсан билээ.

*Хүснэгт 4.4.* **Хүн амын нас, хүйсийн бүтэц, хүйсийн харьцаа**

| Насны бүлэг | Бүгд | | Эрэгтэй | | Эмэгтэй | | Хүйсийн харьцаа[1] |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | % | Тоо | % | Тоо | % | |
| 00 – 04 | 182,700 | 8.2 | 94,100 | 8.5 | 88,600 | 7.9 | 106.2 |
| 05 – 09 | 212,100 | 9.5 | 109,200 | 9.9 | 102,900 | 9.2 | 106.1 |
| 10 – 14 | 294,800 | 13.2 | 152,000 | 13.7 | 142,800 | 12.7 | 106.4 |
| 15 – 19 | 265,300 | 11.9 | 134,700 | 12.2 | 130,600 | 11.6 | 103.1 |
| 20 – 24 | 191,500 | 8.6 | 96,000 | 8.7 | 95,500 | 8.5 | 100.5 |
| 25 – 29 | 178,500 | 8,0 | 87,000 | 7.9 | 91,500 | 8.1 | 95.1 |
| 30 – 34 | 175,200 | 7.9 | 84,100 | 7.6 | 91,100 | 8.1 | 92.3 |
| 35 – 39 | 171,000 | 7.8 | 79,700 | 7.2 | 91,300 | 8.2 | 87.3 |
| 40 – 44 | 161,600 | 7.2 | 76,800 | 6.9 | 84,800 | 7.6 | 90.6 |
| 45 – 49 | 116,000 | 5.2 | 57,000 | 5.2 | 59,000 | 5.2 | 96.6 |
| 50 – 54 | 76,600 | 3.4 | 35,900 | 3.2 | 40,700 | 3.7 | 88.2 |
| 55 – 59 | 58,400 | 2.6 | 27,800 | 2.5 | 30,600 | 2.7 | 90.8 |
| 60- 64 | 59,700 | 2.7 | 31,700 | 2.9 | 28,000 | 2.5 | 113.2 |
| 65-69 | 34,200 | 1.5 | 16,400 | 1.5 | 17,800 | 1.6 | 92.1 |
| 70+ | 51,200 | 2.3 | 23,700 | 2.1 | 27,500 | 2.4 | 86.2 |
| Дүн | 2,228,800 | 100.0 | 1,106,100 | 100.0 | 1,122,700 | 100.0 | 98.5 |

[1] 100 эмэгтэйд ногдох эрэгтэйчүүдийн тоо

## 4.3 Өрхийн бүтэц

*Хүснэгт 4.5*-д нийт өрхийн тоог ам бүлийн тоо, хот, хөдөө, бүс нутгаар тооцож харуулав. Янз бүрийн шалтгаанаар өрхөөс түр гадуур амьдрагчдыг хамруулаагүй тул өрхийн ам бүлийн тоо буурч гарав. Улсын хэмжээнд нэг ам бүлтэй өрх 6.5 хувийг, 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрх 2.8 хувийг эзэлж байна.

*Хүснэгт 4.5.* **Өрхийн дүнд эзлэх хувь, ам бүлийн тоо, хот, хөдөө, бүсээр**

| Өрхийн ам бүлийн тоо | Улсын дүн | Хот | Хөдөө | Төв | Зүүн | Баруун | Хангай | УБ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | % | % | % | % | % | % | % | % |
| 1 | 6.5 | 6.8 | 6.2 | 6.5 | 8.5 | 4.2 | 6.8 | 7.2 |
| 2 | 13.8 | 13.9 | 13.7 | 15.1 | 18.2 | 10.6 | 12.6 | 14.6 |
| 3 | 21.4 | 22.5 | 20.2 | 21.5 | 24.3 | 17.8 | 21.2 | 22.9 |
| 4 | 25.4 | 25.6 | 25.2 | 24.8 | 24.0 | 22.8 | 27.6 | 26.0 |
| 5 | 17.2 | 17.0 | 17.1 | 17.0 | 14.0 | 20.7 | 17.6 | 15.4 |
| 6 | 8.5 | 7.9 | 9.3 | 7.9 | 6.2 | 13.5 | 7.6 | 7.5 |
| 7 | 4.4 | 3.8 | 5.0 | 4.1 | 3.1 | 6.2 | 4.2 | 3.9 |
| 8+ | 2.8 | 2.5 | 3.3 | 3.1 | 1.7 | 4.2 | 2.4 | 2.5 |
| Дүн , % | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| **Тоо** | **568,800** | **311,000** | **257,800** | **114,700** | **48,500** | **97,900** | **138,900** | **168,800** |
| Түр эзгүй байгаа хүнийг оруулаагүй өрхийн ам бүлийн дундаж тоо | 3.9 | 3.9 | 4.0 | 3.9 | 3.6 | 4.3 | 3.9 | 3.8 |

Зүүн бүсийн нутагт 8 ба түүнээс дээш ам бүлтэй өрхийн эзлэх хувь бусад бүсээс доогуур 1.7 хувьтай байхад Баруун бүсийн нутагт 4.2 хувьтай байна. Бараг зургаан өрхийн нэг нь 6 ба түүнээс дээш ам бүлтэй өрх байна.

### 4.3.1 Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх

Нийт өрхийн 16.4 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байгаа ба энэ үзүүлэлт хөдөө орон нутагт доогуур буюу 11.9 хувьтай байна. Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхүүдийг өрхийн ам бүлийн тоо болон хот, хөдөөгөөр тооцож, дүнг нь *Хүснэгт 4.6*-д танилцуулав. Өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн тоо буурч байна. Нэг ам бүлтэй нийт өрхийн 44.1 хувийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байхад, гурван ам бүлтэй таван өрх тутмын гурав нь эмэгтэй тэргүүлэгчтэй байна. Хот, суурин газарт гурван ам бүлтэй дөрвөн өрх тутмын нэгийг, хөдөө орон нутагт найман өрх тутмын нэгийг эмэгтэйчүүд тэргүүлж байна. 4 ба түүнээс дээш ам бүлтэй өрхийн 7.9 хувийг эмэгтэй тэргүүлэгчтэй өрх эзэлж байна.

*Хүснэгт 4.6.* ***Нийт өрхөд эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн эзлэх хувь, ам бүлийн тоогоор***

| Өрхийн ам бүлийн тоо | Эмэгтэй тэргүүлэгчтэй өрх | | |
|---|---|---|---|
| | Бүгд | Хот | Хөдөө |
| | % | % | % |
| 1 | 44.1 | 44.8 | 43.2 |
| 2 | 30.1 | 36.0 | 22.8 |
| 3 | 18.7 | 23.6 | 12.1 |
| 4 | 9.7 | 12.5 | 6.2 |
| 5 | 9.0 | 11.0 | 6.6 |
| 6 | 9.0 | 12.0 | 5.8 |
| 7 | 8.7 | 10.9 | 6.8 |
| 8+ | 7.9 | 14.5 | 2.0 |
| Улсын дундаж , % | 16.4 | 20.2 | 11.9 |

*Хүснэгт 4.7*-гоос харахад эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн хоёр өрхийн нэг нь 2-3 ам бүлтэй, зургаан өрхийн нэг нь 1 ам бүлтэй өрх байна.

*Хүснэгт 4.7.* ***Эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн ам бүлийн бүтэц, хот, хөдөөгөөр***

| Өрхийн ам бүлийн тоо | Бүгд | Хот | Хөдөө |
|---|---|---|---|
| 1 | 17.5 | 15.1 | 22.6 |
| 2 | 25.3 | 24.8 | 26.2 |
| 3 | 24.4 | 26.3 | 20.5 |
| 4 | 15.0 | 15.9 | 13.2 |
| 5 | 9.4 | 9.3 | 9.5 |
| 6 | 4.7 | 4.7 | 4.6 |
| 7 | 2.3 | 2.1 | 2.8 |
| 8+ | 1.4 | 1.8 | 0.5 |
| Дүн, % | 100.0 | 100.0 | 100.0 |

## 4.4 Боловсролын түвшин, сургуульд хамрагдалт

Эдийн засгийн идэвхи, эрхэлж байгаа ажлын төрөл, хэлбэр нь боловсролын түвшинтэй хамааралтай байдаг. Иймд судалгаагаар өрхийн гишүүдийн боловсролын түвшин болон сургуульд хамрагдалт, бичиг үсгийн мэдлэгийн талаар мэдээлэл цуглуулсан.

### 4.4.1 Боловсролын түвшин

15 ба түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшинг *Хүснэгт 4.8*-д үзүүлэв. Хот, суурин газар, хөдөө орон нутгийн аль алинд нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн боловсролын түвшин ерөнхийдөө адилхан, гэхдээ эмэгтэйчүүдийнх эрэгтэйчүүдийнхээс арай дээгүүр байна. *Хүснэгт 4.8*-аас харахад эрэгтэйчүүдийн 4.6 хувь, эмэгтэйчүүдийн 5.0 хувь нь сургуульд огт сурч байгаагүй, харин эрэгтэйчүүдийн 17.8 хувь, эмэгтэйчүүдийн 16.2 хувь нь бага боловсрол эзэмшсэн байна. Эндээс үзэхэд 15, түүнээс дээш насны таван хүний нэг нь бага боловсролтой эсвэл боловсролгүй байна. Ялангуяа хөдөө орон нутагт боловсролгүй, эсвэл бага боловсрол эзэмшсэн хүмүүсийн эзлэх хувь өндөр, 8.0 орчим хувь нь боловсролгүй, харин 25.3-28.6 хувь нь бага боловсролтой байна. Найман хүний нэг нь их дээд сургууль төгссөн, хот, суурин газрын хүн амын 20.0 орчим хувь нь бакалаврын болон магистрийн цол эзэмшжээ. Харин хөдөө орон нутагт ийм хүмүүс гурав хүрэхгүй хувийг эзэлж байна. Хүн амын боловсролын түвшинг хот, хөдөөгөөр харьцуулж үзэхэд хөдөөд доогуур гарч байна.

*Хүснэгт 4.8.* ***15, түүнээс дээш насны хүн амын боловсролын түвшин, хүйс, байршил, дунд эзлэх хувиар***

| Боловсролын түвшин | Бүгд | | | Хот | | Хөдөө | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Эрэгтэй | Эмэгтэй | Эрэгтэй | Эмэгтэй |
| | % | % | % | % | % | % | % |
| Боловсролгүй | 4.8 | 4.6 | 5.0 | 2.0 | 2.6 | 7.8 | 8.1 |
| Бага | 16.9 | 17.8 | 16.2 | 8.7 | 9.1 | 28.6 | 25.3 |
| Бүрэн бус дунд | 27.7 | 30.4 | 25.1 | 23.4 | 18.0 | 38.8 | 34.3 |
| Бүрэн дунд | 24.3 | 22.9 | 25.7 | 31.1 | 31.7 | 13.1 | 17.8 |
| Мэргэжлийн анхан шатны | 5.1 | 5.7 | 4.5 | 6.5 | 5.1 | 4.6 | 4.0 |
| Тусгай мэргэжлийн/ бүрэн бус дээд | 9.3 | 7.2 | 11.2 | 9.5 | 13.9 | 4.5 | 7.7 |
| Дээд | 11.9 | 11.4 | 12.3 | 18.8 | 19.6 | 2.6 | 2.8 |
| Дүн, % | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| **Тоо** | **1,539,200** | **750,800** | **788,400** | **408,600** | **446,500** | **342,200** | **341,900** |

### 4.4.2 Сургуульд хамрагдалт

Судалгааны үр дүнгээр 7-19 насны хүн амын 79.1 хувь нь, үүнээс хөвгүүдийн 76.7 хувь, охидын 81.6 хувь нь сургуульд суралцаж байна. Сургуулийн насанд хүрсэн болович сургуульд оройтож орж байгаа нь сургуульд хамрагдалтын түвшинг бууруулахад нөлөөлж байгааг *Хүснэгт 4.9*-өөс үзэж болно. Хот,

хөдөөгийн алинд ч охидын сургуульд хамрагдалтын хувь хөвгүүдийнхээс дээгүүр байгаа сонирхолтой дүр зураг харагдаж байна. Хот, суурин газарт сургуулийн бага ангид охид, хөвгүүдийн сургуульд хамрагдалтын түвшин бараг адил байснаа 10 наснаас эхлэн өөрчлөгдөж эхэлжээ. Хөдөө орон нутагт анх сургуульд орохоос эхлэн сургууль төгсөх хүртэлх бүх шатанд охидын сургуульд хамрагдалтын түвшин хөвгүүдийнхээс өндөр байна. Ялангуяа, хөдөөгийн өсвөр насны охидын сургуульд хамрагдалтын түвшин мөн насны хөвгүүдийнхээс нилээд дээгүүр байгаа нь бусад хөгжиж буй орнуудаас ялгаатай дүр зургийг харуулж байна. Энэ нь эрэгтэйчүүд яаж ийгээд амьдраад явна, харин охид боловсролгүй бол хүний эрхэнд, арчаагүй байдалд орно гэсэн сэтгэлгээ нэг үндсэн шалтгаан болсон байж болох талтай. Хөдөө орон нутагт мал аж ахуйд туслах зорилгоор хөвгүүд сургууль завсардаж, мөн боловсрол эзэмшсэн залуучууд ажил олоход хэцүү болж байгаа зэрэг нь сургуульд хамрагдалтын түвшинд нөлөөлж байгаа юм. Хот, суурин газарт 16 настай хөвгүүд, охидын 90.0 гаруй хувь нь сургуульдаа үргэлжлүүлэн суралцаж байхад хөдөө орон нутагт энэ үзүүлэлт харьцангүй доогуур байгаа нь хөвгүүд, охидын сургууль завсардалт их байгаатай холбоотой юм.

*Хүснэгт 4.9.* ***7-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын түвшин, хот, хөдөө, хүйсээр***

| Бүтэн нас | Улсын дүн | | | Хот | | | Хөдөө | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| | % | % | % | % | % | % | % | % | % |
| 7 | 39.4 | 38.2 | 40.7 | 51.3 | 48.2 | 54.5 | 29.5 | 30.1 | 28.9 |
| 8 | 81.0 | 80.2 | 81.8 | 88.5 | 89.3 | 87.7 | 73.8 | 71.4 | 76.2 |
| 9 | 94.8 | 94.2 | 95.5 | 97.9 | 99.4 | 96.3 | 91.7 | 89.0 | 94.6 |
| 10 | 96.8 | 95.7 | 97.7 | 98.7 | 98.5 | 98.8 | 94.6 | 92.6 | 96.6 |
| 11 | 95.8 | 95.2 | 96.3 | 97.9 | 97.5 | 98.5 | 92.8 | 92.2 | 93.4 |
| 12 | 94.9 | 93.0 | 97.2 | 98.7 | 98.2 | 99.3 | 90.0 | 85.9 | 94.6 |
| 13 | 92.1 | 90.8 | 93.5 | 97.0 | 97.1 | 97.0 | 85.2 | 82.2 | 88.7 |
| 14 | 90.3 | 87.9 | 92.7 | 96.6 | 96.2 | 97.0 | 81.4 | 76.9 | 86.4 |
| 15 | 86.9 | 83.8 | 89.8 | 95.7 | 94.9 | 96.5 | 76.1 | 70.4 | 81.6 |
| 16 | 78.3 | 74.4 | 82.4 | 91.9 | 90.5 | 93.4 | 59.7 | 53.0 | 66.9 |
| 17 | 70.5 | 65.4 | 75.8 | 87.2 | 83.2 | 91.2 | 50.5 | 43.8 | 57.3 |
| 18 | 47.8 | 43.5 | 52.2 | 67.1 | 62.7 | 71.4 | 25.2 | 22.1 | 28.5 |
| 19 | 41.3 | 37.1 | 46.2 | 61.2 | 58.3 | 64.3 | 15.6 | 10.6 | 21.5 |
| 7-19 насны хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь | 79.1 | 76.7 | 81.6 | 88.6 | 87.5 | 89.7 | 67.6 | 62.8 | 71.7 |
| Сургуульд хамрагдсан хүүхдийн тоо | 545,500 | 270,400 | 275,100 | 333,900 | 167,900 | 166,000 | 211,600 | 102,500 | 109,100 |
| 7-19 насны нийт хүүхдийн тоо | 689,800 | 352,600 | 337,200 | 377,100 | 192,000 | 185,100 | 312,700 | 160,600 | 152,100 |

### 4.4.3 Бичиг үсгийн мэдлэг

Судалгаагаар бичиг үсэг мэддэг эсэхийг тодорхойлохын тулд энгийн захиа уншиж бичиж чадах уу гэж асуусан. Энгийн бичиг, захиаг уншиж, бичиж чадаж байвал бичиг үсэгт тайлагдсанд тооцсон. Харин зөвхөн өөрийнхөө нэрийг унших эсвэл тоо уншиж чаддаг боловч бичиж чаддаггүй бол тэр хүнийг бичиг үсэгт тайлагдсанд тооцоогүй. Насанд хүрэгчдийн бичиг үсэгт тайлагдалтын хувийг тодорхойлохдоо 15, түүнээс дээш насны нийт хүн амын дотор энгийн бичиг захиа уншиж, бичиж чаддаг хүний эзлэх хувиар тооцлоо. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогоор бичиг үсгийн мэдлэгийн түвшин 97.8 хувь гарсан бол энэ удаагийн судалгаагаар эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин ойролцоо 97.0 хувьтай байна. Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын дүнтэй харьцуулахад бичиг үсгийн мэдлэгийн түвшин нь суралцах, ажиллах зорилгоор 6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч байгаа хүмүүсийг оруулаагүйгээс шалтгаалан арай доогуур гарсан байж болох талтай.

*Хүснэгт 4.10.* ***Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин, хот, хөдөө, бүсээр***

| Хот, хөдөө/бүс | Бүгд % | Эрэгтэй % | Эмэгтэй % |
|---|---|---|---|
| Хот | 98.5 | 98.7 | 98.3 |
| Хөдөө | 95.0 | 94.9 | 95.0 |
| Төв | 97.1 | 96.9 | 97.3 |
| Зүүн | 95.1 | 95.5 | 94.7 |
| Баруун | 94.7 | 94.8 | 94.6 |
| Хангай | 96.4 | 96.5 | 96.4 |
| Улаанбаатар | 98.9 | 99.1 | 98.7 |
| Улсын дүн | 96.9 | 97.0 | 96.9 |

*Хүснэгт 4.11*-д хөдөөд бичиг үсгийн мэдлэгийн түвшин 95.0 хувь байхад хотод үүнээс 3 пунктээр дээгүүр байгааг харуулж байна. *4.11*-р хүснэгтээс харахад 64 хүртэлх насны эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин 90.0-ээс дээш хувьтай байна.

*Хүснэгт 4.11.* ***Насанд хүрэгчдийн бичиг үсгийн мэдлэгийн түвшин, насны бүлэг, хот, хөдөөгөөр***

| Насны бүлэг | Улсын дүн | | | Хот | | | Хөдөө | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| 15 – 24 | 97.3 | 96.8 | 97.8 | 99.3 | 99.2 | 99.4 | 94.8 | 93.9 | 95.9 |
| 25 – 34 | 99.0 | 98.7 | 99.2 | 99.6 | 99.5 | 99.7 | 98.2 | 97.9 | 98.6 |
| 35 – 44 | 98.9 | 98.7 | 99.1 | 99.5 | 99.4 | 99.6 | 98.0 | 97.7 | 98.2 |
| 45 – 54 | 98.3 | 98.6 | 98.1 | 99.4 | 99.5 | 99.2 | 97.0 | 97.4 | 96.6 |
| 55 – 64 | 95.3 | 96.4 | 94.3 | 97.7 | 98.4 | 96.9 | 92.1 | 93.7 | 90.4 |
| 65+ | 78.0 | 81.4 | 74.9 | 84.8 | 88.4 | 81.9 | 69.4 | 73.6 | 65.2 |
| Дүн | 96.9 | 97.0 | 96.9 | 98.5 | 98.7 | 98.3 | 95.0 | 94.9 | 95.0 |

Бүлэг 5

# ХҮҮХДИЙН ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## 5.1 Удиртгал

Монголын Хүүхдийн Хөдөлмөрийн Судалгаа (МХХС)-г 5-17 насны хүүхдүүдийн эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаан дахь оролцоог тодорхойлох зорилгоор явуулсан билээ. Энэ бүлэгт энэ насны хүүхдүүдийн эдийн засгийн идэвхийн талаарх зарим гол үр дүнг нарийвчлан тооцов. МХХС-гаар 5-17 насны хүүхдүүдийг (1) насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, (2) хүйс, боловсролын түвшингээр, (3) сургуульд хамрагдалт, (4) сургуульд хамрагдаагүй шалтгаан зэргээр тооцсон. Дараачийн бүлэгт ажил эрхэлж буй хүүхдүүдийн талаарх дүнг танилцуулах болно.

## 5.2 5-17 насны хүүхдүүдийн тоо

Судалгааны түүврийн тархаалтын тооцоогоор 5-17 насны нийт 679049 хүүхэд байгаагийн 360750 (53.1 хувь) нь хот, суурин газарт, 318299 (46.9 хувь) нь хөдөө орон нутагт амьдарч байна. Насны бүлгээр тооцвол 5-9 насны 212145 (31.2 хувь) хүүхэд, 10-14 насны 294841 (43.4 хувь) хүүхэд, 15-17 насны 172063 (25.4 хувь) хүүхэд байна (*Хүснэгт 5.1*). 5-17 насны нийт хүүхдийн 347652 нь буюу 51.2 хувийг хөвгүүд, 331397 нь буюу 48.8 хувийг охид эзэлж байна.

*Хүснэгт 5.1.* ***5-17 насны хүүхдүүдийн тоо, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр***

| Насны бүлэг | Бүгд | | | Хот | | | Хөдөө | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| Хүн амын тоо | 2228829 | 1106133 | 1122695 | 1198320 | 585996 | 612324 | 1030509 | 520137 | 510372 |
| Насны бүлгээр: | | | | | | | | | |
| 5-9 | 212145 | 109205 | 102940 | 97575 | 50591 | 46984 | 114570 | 58614 | 55956 |
| 10-14 | 294841 | 151999 | 142843 | 167360 | 86365 | 80995 | 127482 | 65634 | 61848 |
| 15-17 | 172063 | 86449 | 85614 | 95816 | 47976 | 47839 | 76247 | 38472 | 37775 |
| Нийт 5-17 | 679049* | 347652 | 331397 | 360750 | 184932 | 175818 | 318299 | 162720 | 155579 |

*- Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн тоо

*Хүснэгт 5.1а.* ***5-17 насны хүүхдүүдийн, нас, хүйсийн бүтэц, хот, хөдөөгөөр***

| Насны бүлэг | Бүгд | | | Хот | | | Хөдөө | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| 5-17 насны хүүхэд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Үүнээс: | | | | | | | | | |
| 5-9 | 31.2 | 31.4 | 31.1 | 27.0 | 27.4 | 26.7 | 36.0 | 36.0 | 36.0 |
| 10-14 | 43.4 | 43.7 | 43.1 | 46.4 | 46.7 | 46.1 | 40.0 | 40.3 | 39.8 |
| 15-17 | 25.4 | 24.9 | 25.8 | 26.6 | 25.9 | 27.2 | 24.0 | 23.7 | 24.2 |

Хүүхдүүдийн тоог насны бүлэг, хүйсээр нарийвчлан тооцсон дүнг *Хүснэгт 5.1а*, *Хүснэгт 5.1б*-д тус тус танилцуулав.

*Хүснэгт 5.1б.* ***5-17 насны хүүхдүүд, насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр, дүнд эзлэх хувиар***

| Насны бүлэг | Бүгд | | | Хот | | | Хөдөө | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| Нийт хүн ам | 100.0 | 49.6 | 50.4 | 100.0 | 48.9 | 51.1 | 100.0 | 50.5 | 49.5 |
| Үүнээс: | | | | | | | | | |
| 5-9 | 100.0 | 51.5 | 48.5 | 100.0 | 51.8 | 48.2 | 100.0 | 51.2 | 48.8 |
| 10-14 | 100.0 | 51.6 | 48.4 | 100.0 | 51.6 | 48.4 | 100.0 | 51.5 | 48.5 |
| 15-17 | 100.0 | 50.2 | 49.8 | 100.0 | 50.1 | 49.9 | 100.0 | 50.5 | 49.5 |
| 5-17 насны-бүгд | 100.0 | 51.2 | 48.8 | 100.0 | 51.3 | 48.7 | 100.0 | 51.1 | 48.9 |

*Хүснэгт 5.2*-оос харахад МХХС-ны хүүхдийн тоо (насны бүлгээр) хүн амын 2003 оны жилийн эцсийн тоотой ойролцоо гарчээ.

*Хүснэгт 5.2.* ***Судалгаагаар тооцсон хүүхдийн тоо болон 2003 оны хүн амын жилийн эцсийн тоотой харьцуулсан нь, насны бүлгээр***

| Насны бүлэг | 2003 оны эцэст | | Судалгаанд хамрагдсан хүн ам (2002 оны 10-р сараас 2003 оын 10-р сар хүртэл) | |
|---|---|---|---|---|
| Нийт хүн ам | 2,504,023 | (Нийт хүн амд эзлэх хувь) | 2,228,829 | (Нийт хүн амд эзлэх хувь) |
| Үүнээс: | | | | |
| 5 – 9 | 268,766 | 10.7 | 212,145 | 9.5 |
| 10 – 14 | 316,966 | 12.7 | 294,841 | 13.2 |
| 15 – 17 | 179,914 | 7.2 | 172,063 | 7.7 |
| 5-17 насны хүүхэд | 765,646 | 30.6 | 679,049* | 30.4 |

Дээрх хүснэгтээс харахад 5-17 насны хүүхдийн нийт хүн амд эзлэх хувь бараг ижил гарсан байна. Гэхдээ АХС+МХХС нь өрхийн судалгаа тул өрхөөс гадуурх ажлын байр, дотуур байр болон бусад газарт амьдарч буй хүүхдүүд болон орон гэргүй, хараа хяналтгүй хүүхдүүдийг хамруулаагүйгээс шалтгаалан 5-17 насны хүүхдийн тоо буурч гарсан.

## 5.3 5-17 насны хүүхдүүдийн боловсролын түвшин

Судалгаанд хамрагдсан 5-17 насны хүүхдийн боловсролын түвшинг насны бүлэг, хүйсээр тооцсон дүнг *Хүснэгт 5.3*-т үзүүлэв.



*Хүснэгт 5.3.* ***5-17 насны хүүхдийн тоо, боловсролын түвшин, насны бүлэг, хүйсээр***

| Насны бүлэг/хүйс | Нийт | Сургуульд огт сураагүй | Бага сургууль төгсөөгүй | Анги | | | Техник мэргэжлийн анхан шатын сургууль |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бага анги | 4-8-р анги | 9-10-р анги | |
| Нийт хүүхэд | 676911* | 129984 | 163531 | 280116 | 92860 | 9660 | 761 |
| Үүнээс: | | | | | | | |
| Насны бүлгээр | | | | | | | |
| 5-9 | 211441 | 119651 | 91790 | 0 | 0 | 0 | 0 |
| 10-14 | 293964 | 6225 | 67872 | 212816 | 7051 | 0 | 0 |
| 15-17 | 171506 | 4108 | 3869 | 67300 | 85809 | 9660 | 761 |
| Эрэгтэй | 346867 | 69811 | 81695 | 145396 | 45604 | 3904 | 457 |
| 5-9 | 108945 | 62823 | 46122 | 0 | 0 | 0 | 0 |
| 10-14 | 151656 | 4288 | 33242 | 110414 | 3712 | 0 | 0 |
| 15-17 | 86266 | 2699 | 2332 | 34982 | 41892 | 3904 | 457 |
| Эмэгтэй | 330045 | 60173 | 81835 | 134720 | 47256 | 5756 | 304 |
| 5-9 | 102496 | 56828 | 45668 | 0 | 0 | 0 | 0 |
| 10-14 | 142309 | 1937 | 34630 | 102402 | 3339 | 0 | 0 |
| 15-17 | 85240 | 1408 | 1537 | 32317 | 43917 | 5756 | 304 |

*- Нийт судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс 2,138 хүүхэд асуулганд хариулаагүйтэй холбоотой (679049-2138=676911).

*Хүснэгт 5.3а.* ***5-17 насны хүүхдийн дунд эзлэх хувь, боловсролын түвшин, насны бүлэг, хүйсээр***

| Насны бүлэг/хүйс | Бүгд | Сургуульд огт сураагүй | Бага сургууль төгсөөгүй | Анги | | | Техник мэргэжлийн анхан шатны сургууль |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бага анги | 4-8-р анги | 9-10-р анги | |
| Нийт хүүхэд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Үүнээс: | | | | | | | |
| Насны бүлгээр | | | | | | | |
| 5-9 | 31.2 | 92.0 | 56.1 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 43.4 | 4.8 | 41.5 | 76.0 | 7.6 | 0.0 | 0.0 |
| 15-17 | 25.4 | 3.2 | 2.4 | 24.0 | 92.4 | 100.0 | 100.0 |
| Эрэгтэй | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 5-9 | 31.4 | 90.0 | 56.5 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 43.7 | 6.1 | 40.7 | 75.9 | 8.1 | 0.0 | 0.0 |
| 15-17 | 24.9 | 3.9 | 2.8 | 24.1 | 91.9 | 100.0 | 100.0 |
| Эмэгтэй | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 5-9 | 31.1 | 94.4 | 55.8 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 43.1 | 3.2 | 42.3 | 76.0 | 7.1 | 0.0 | 0.0 |
| 15-17 | 25.8 | 2.3 | 1.9 | 24.0 | 92.9 | 100.0 | 100.0 |

Судалгаагаар 5-17 насны нийт хүүхдийн 19.2 хувь нь сургуульд огт сураагүй байгаагийн дийлэнх нь 5-9 насны хүүхдүүд байгаа нь сургуульд орох насны доод хязгаар 7 нас байгаатай холбон үзэх хэрэгтэй. Сургуульд огт сураагүй хүүхдийн дотор 10-17 насны хүүхдүүд 8.0 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна. Түүнчлэн нийт хүүхдийн дөрөвний нэг нь (24.2 хувь) бага сургууль

төгсөөгүй байгаагийн бараг 44.0 хувь нь 10–17 насныхан байна. Хүүхдүүдийн боловсролын түвшинг хүйсээр авч үзэхэд нэг их ялгаа гарахгүй байгаа боловч 10-17 насны хөвгүүдийн 2.9 хувь нь сургуульд суралцаагүй байхад мөн насны охидын зөвхөн 1.5 хувь нь сургуульд суралцаагүй байна. 15-17 насныханд 4-8-р анги болон 9-10-р ангид сурсан охидын эзлэх хувь 51.5 болон 6.7 байхад харин хөвгүүдийнх 48.6 болон 4.5 хувьтай байна. Эндээс дүгнэхэд охидын боловсролын түвшин хөвгүүдийнхээс өндөр байх хандлагатай байна.

*Хүснэгт 5.3б.* ***5-17 насны хүүхдийн боловсролын түвшин, насны бүлэг, хүйсээр, хувиар***

| Насны бүлэг/хүйс | Бүгд | Сургуульд огт сураагүй | Бага сургууль төгсөөгүй | Анги | | | Техник мэргэжлийн анхан шатны сургууль |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бага | 4-8-р анги | 9-10-р анги | |
| Нийт | 100.0 | 19.2 | 24.2 | 41.4 | 13.7 | 1.4 | 0.1 |
| Насны бүлгээр: | | | | | | | |
| 5-9 | 100.0 | 56.6 | 43.4 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 100.0 | 2.1 | 23.1 | 72.4 | 2.4 | 0.0 | 0.0 |
| 15-17 | 100.0 | 2.4 | 2.3 | 39.2 | 50.1 | 5.6 | 0.4 |
| Эрэгтэй | 100.0 | 20.1 | 23.6 | 41.9 | 13.1 | 1.2 | 0.1 |
| 5-9 | 100.0 | 57.7 | 42.3 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 100.0 | 2.8 | 21.9 | 72.8 | 2.5 | 0.0 | 0.0 |
| 15-17 | 100.0 | 3.1 | 2.7 | 40.6 | 48.6 | 4.5 | 0.5 |
| Эмэгтэй | 100.0 | 18.2 | 24.8 | 40.8 | 14.3 | 1.8 | 0.1 |
| 5-9 | 100.0 | 55.4 | 44.6 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 100.0 | 1.4 | 24.3 | 72.0 | 2.3 | 0.0 | 0.0 |
| 15-17 | 100.0 | 1.7 | 1.8 | 37.9 | 51.5 | 6.7 | 0.4 |

## 5.4 5-17 насны хүүхдийн сургуульд хамрагдалт, эдийн засгийн идэвхи

Энэ хэсэгт 5-17 насны хүүхдийг 2002-2003 онд сургуульд суралцсан, эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн болон эрхлээгүй гэж ангилан тооцов. Бүлэг 3-т тодорхойлсончлон эдийн засгийн идэвхийг *тухайн үеийн* (сүүлийн 7 хоногт) *болон* байнгын (сүүлийн 12 сард) идэвхийн байдлаар тооцож болох бөгөөд ойлгоход амар байх үүднээс энэ судалгаанд ангилалыг зөвхөн тухайн үеийн эдийн засгийн идэвхээр тооцсон[11]. Ингээд нийт хүүхдийг сургуульд суралцсан, сургуульд суралцаагүй гэж ангилаад, ангилал бүрийг (1) эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн (түүнчлэн гэрийн ажил хийхэд оролцсон хүүхэд ч байж болно), (2) зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон (эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлсэн), (3) зөвхөн сургуульд суралцсан, (4) юунд ч оролцоогүй буюу эдийн засгийн идэвхигүй, өвчтэй, тахир дутуу зэрэг хүүхдүүдийг оролцуулаад гэсэн бүлгүүдэд хуваасан. *Хүснэгт 5.4*-д сүүлийн 7 хоногт сургуульд суралцсан болон суралцаагүй 5-17 насны хүүхдийг насны бүлэг, хүйсээр тооцсоноос харахад энэ насны дийлэнх хүүхэд сургуульд сурч байна. Судалгаанд хамрагдсан 5-17 насны 676911 хүүхдээс сүүлийн 7 хоногийн байдлаар 74.6 хувь буюу 505234 нь сургуульд сурч байна. Насны

[11] *Эдийн засгийн идэвхийг Бүлэг V-д тодорхойлов.*

бүлгээр тооцоход сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийн эзлэх хувь 10-14 насанд хамгийн өндөр 93.7 хувь байна. 15-17 насны сургуульд сурч буй хүүхдүүдийн 52.3 хувь нь (135064 хүүхдийн 70632 нь) охид, 47.7 хувь нь (64433 нь) хөвгүүд байна. *Хүснэгт 5.4*-д 5-17 насны нийт хүүхдийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн, гэрийн ажил хийхэд оролцсон, зөвхөн сургуульд сурдаг, эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаа (гэрийн ажил)-нд оролцоогүй буюу аль алиныг нь хийгээгүй гэсэн ангилалд хуваав. Нийт хүүхдийн дийлэнх нь гэрийнхээ ажилд тусалж байна. 5-17 насны бүх хүүхдийн 74.8 хувь, үүнээс охидын 78.1 хувь, хөвгүүдийн 71.6 хувь нь гэрийн



ажилд тусалж байна[12]. Бүх насны бүлэгт гэрийн ажилд тусалж байгаа охидын эзлэх хувь хөвгүүдийнхээс өндөр байна. 5-17 насны нийт хүүхдийн 10.0 орчим хувь нь эдийн засгийн үйл ажиллагаанд татагдан орсон байна (*Хүснэгт 5.4б*-д). Энэ тоог хүйсээр задлан харуулбал хөвгүүдийнх өндөр 11.6 хувьтай байхад охидынх 7.7 хувь байна. Ерөнхийдөө бүх насны бүлэгт эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон хөвгүүдийн тоо охидынхоос өндөр байгаа бөгөөд ийм хүүхдийн дийлэнх нь 15-17 насны хүүхдүүд байна. Гэрийн ажил хийхэд оролцож буй хүүхдийн дийлэнх нь 10-14 насныхан байна. Сургуульд ч сураагүй, эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаа (гэрийн ажил)-нд оролцоогүй хүүхдүүд нийт хүүхдийн 7.3 хувийг эзэлж байна. Энэ хүүхдүүдийн дөрөвний гурав нь сургуульд сурах, ажил хөдөлмөр эрхлэхэд дэндүү балчир өөрөөр хэлбэл 5-6 настай хүүхдүүд байгаа юм. 5-17 насны хүүхдүүдийн 8.2 орчим хувь нь зөвхөн сургуульд сурч байгаа бөгөөд сургуульд хамрагдсан бүх хүүхдийн 11.0 хувь нь зөвхөн сургуульд сурч (эдийн засгийн ямарваа нэгэн үйл ажиллагаа эрхэлдэггүй, гэрийн ажил хийхэд оролцдоггүй), 4.7 хувь нь сурахын хажуугаар ажил эрхэлж байна. Сургуулийн сурагчдын дийлэнх (84.2 хувь) нь сургуульд сурахын зэрэгцээ гэрийн ажилд тусалж байна. *Хүснэгт 5.5*-д 5-17 насны хүүхдийн сургуульд хамрагдсан эсэх, ажил эрхэлж буй байдлыг өрхийн ам бүлийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйстэй уялдуулан тооцов. *Хүснэгт 5.5а*-д дүнд эзлэх хувиар нь тооцож гаргасан. Ам бүл олонтой өрхөд, өөрөөр хэлбэл 7-8 эсвэл 9 болон түүнээс дээш ам бүлтэй өрхөд гэрийн ажилд туслалцаж буй хүүхдийн тоо багасч байгаа нь өрхийн насанд хүрсэн бусад гишүүн энэ ажлыг хийж байгаатай холбоотой байж болох юм. Түүнчлэн сургуульд сурч буй хүүхдийн эзлэх хувь өрхийн ам бүлийн тоо нэмэгдэх тусам өсч байна. Гэхдээ судалгаанд хамрагдсан ахлах насны дийлэнх хүүхэд өнөр ам бүлтэй өрхийн гишүүд тул сургуульд сурах болон ам бүлийн тоо хоорондоо нэг их хамааралгүй байна. Нийт хүүхдийн наймны нэг нь (676911 хүүхдийн 86763 нь) эмэгтэй тэргүүлэгчтэй өрхөд амьдарч байгаа бөгөөд хүүхдүүдийн сургуульд хамрагдалт, ажил эрхлэлтэнд онцын ялгаатай зүйл ажиглагдсангүй.

[12] *Бүлэг 5-д гэрийн ажилд тусалж байгаа 5-17 насны хүүхдүүд 576,414 (Хүснэгт 5.8) байгаагаас 506,284 (Хүснэгт 4.4) нь зөвхөн гэрийн ажилд тусалж, 61,130 нь хөдөлмөр эрхэлж, мөн гэр орны ажилд тусалж байна.*

*Хүснэгт 5.4.* ***Сүүлийн 7 хоногт сургуульд суралцсан, эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаанд оролцсон 5-17 насны хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр***

| Насны бүлэг/хүйс | Нийт хүүхэд | | | | | Сургуульд сурсан | | | | Сургуульд сураагүй | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн * | Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон | Зөвхөн сурсан | Аль алиныг нь хийгээгүй | Бүгд | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн * | Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон | Зөвхөн сурсан | Бүгд | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн * | Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон | Аль алиныг нь хийгээгүй |
| Нийт | 676911 | 65729 | 506284 | 55647 | 49251 | 505234 | 23931 | 425656 | 55647 | 171677 | 41798 | 80628 | 49251 |
| 5-6 | 82302 | 5523 | 37908 | 545 | 38325 | 3483 | 0 | 2937 | 545 | 78819 | 5523 | 34971 | 38325 |
| 7-9 | 129139 | 9110 | 93163 | 19061 | 7805 | 91127 | 3295 | 68771 | 19061 | 38013 | 5815 | 24392 | 7805 |
| 10-14 | 293964 | 20436 | 243657 | 28140 | 1731 | 275560 | 11871 | 235550 | 28140 | 18404 | 8565 | 8108 | 1731 |
| 15-17 | 171506 | 30660 | 131556 | 7901 | 1390 | 135064 | 8765 | 118399 | 7901 | 36442 | 21895 | 13158 | 1390 |
| Эрэгтэй | 346867 | 40406 | 248523 | 30292 | 27646 | 252049 | 13378 | 208379 | 30292 | 94818 | 27028 | 40144 | 27646 |
| 5-6 | 43181 | 3240 | 18285 | 206 | 21451 | 1797 | 0 | 1591 | 206 | 41384 | 3240 | 16694 | 21451 |
| 7-9 | 65764 | 5422 | 46183 | 9819 | 4339 | 45895 | 1753 | 34323 | 9819 | 19868 | 3669 | 11860 | 4339 |
| 10-14 | 151656 | 13302 | 121747 | 15602 | 1004 | 139924 | 6991 | 117331 | 15602 | 11731 | 6311 | 4416 | 1004 |
| 15-17 | 86266 | 18442 | 62307 | 4665 | 852 | 64433 | 4634 | 55134 | 4665 | 21834 | 13809 | 7173 | 852 |
| Эмэгтэй | 330045 | 25323 | 257761 | 25356 | 21605 | 253185 | 10553 | 217277 | 25356 | 76860 | 14770 | 40485 | 21605 |
| 5-6 | 39120 | 2283 | 19622 | 340 | 16875 | 1686 | 0 | 1346 | 340 | 37434 | 2283 | 18276 | 16875 |
| 7-9 | 63376 | 3688 | 46980 | 9242 | 3466 | 45231 | 1542 | 34447 | 9242 | 18145 | 2146 | 12532 | 3466 |
| 10-14 | 142309 | 7134 | 121910 | 12538 | 727 | 135636 | 4880 | 118219 | 12538 | 6673 | 2255 | 3691 | 727 |
| 15-17 | 85240 | 12217 | 69249 | 3236 | 538 | 70632 | 4131 | 63264 | 3236 | 14608 | 8086 | 5985 | 538 |

*Хүснэгт 5.4а.* ***Сүүлийн 7 хоногт сургуульд суралцсан, ажил эрхэлсэн, гэрийн ажилд оролцсон 5-17 насны хүүхдүүд, насны бүлэг, хүйсээр***

(Хувиар)

| Насны бүлэг/хүйс | Нийт хүүхэд | | | | | Сургуульд сурсан | | | | Сургуульд сураагүй | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн * | Зөвхөн гэрийн ажилд хийхэд оролцсон | Зөвхөн сурсан | Аль алиныг нь хийгээгүй | Бүгд | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн * | Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон | Зөвхөн сурсан | Бүгд | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн | Зөвхөн гэрийн ажилд оролцсон | Аль алиныг нь хийгээгүй |
| Нийт | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 5-6 | 12.2 | 8.4 | 7.5 | 1.0 | 77.8 | 0.7 | 0.0 | 0.7 | 1.0 | 45.9 | 13.2 | 43.3 | 77.8 |
| 7-9 | 19.1 | 13.9 | 18.4 | 34.2 | 15.9 | 18.1 | 13.8 | 16.2 | 34.3 | 22.2 | 13.9 | 30.3 | 15.8 |
| 10-14 | 43.4 | 31.1 | 48.1 | 50.6 | 3.5 | 54.5 | 49.6 | 55.3 | 50.5 | 10.7 | 20.5 | 10.1 | 3.6 |
| 15-17 | 25.3 | 46.6 | 26.0 | 14.2 | 2.8 | 26.7 | 36.6 | 27.8 | 14.2 | 21.2 | 52.4 | 16.3 | 2.8 |
| Эрэгтэй | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 5-6 | 12.4 | 8.1 | 7.3 | 0.7 | 77.6 | 0.7 | 0.0 | 0.8 | 0.7 | 43.6 | 12.0 | 41.6 | 77.6 |
| 7-9 | 19.0 | 13.4 | 18.6 | 32.4 | 15.7 | 18.2 | 13.1 | 16.4 | 32.4 | 21.0 | 13.6 | 29.5 | 15.7 |
| 10-14 | 43.7 | 32.9 | 49.0 | 51.5 | 3.6 | 55.5 | 52.3 | 56.3 | 51.5 | 12.4 | 23.3 | 11.0 | 3.6 |
| 15-17 | 24.9 | 45.6 | 25.1 | 15.4 | 3.1 | 25.6 | 34.6 | 26.5 | 15.4 | 23.0 | 51.1 | 17.9 | 3.1 |
| Эмэгтэй | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 5-6 | 11.9 | 9.0 | 7.6 | 1.3 | 78.1 | 0.7 | 0.0 | 0.6 | 1.3 | 48.7 | 15.5 | 45.1 | 78.1 |
| 7-9 | 19.2 | 14.6 | 18.2 | 36.5 | 16.0 | 17.8 | 14.6 | 15.9 | 36.5 | 23.6 | 14.5 | 31.0 | 16.0 |
| 10-14 | 43.1 | 28.2 | 47.3 | 49.4 | 3.4 | 53.6 | 46.3 | 54.4 | 49.4 | 8.7 | 15.3 | 9.1 | 3.4 |
| 15-17 | 25.8 | 48.2 | 26.9 | 12.8 | 2.5 | 27.9 | 39.1 | 29.1 | 12.8 | 19.0 | 54.7 | 14.8 | 2.5 |

* Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн зарим хүүхэд бас гэрийн ажил хийсэн байж болох юм.

*Хүснэгт 5.4б.* ***Сүүлийн 7 хоногт сургуульд суралцсан, ажил эрхэлсэн, гэрийн ажилд оролцсон 5-17 насны хүүхдүүд, насны бүлэг, хүйсээр***

(Хувиар)

| Насны бүлэг/хүйс | Нийт хүүхэд | | | | | Сургуульд сурсан | | | | Сургуульд сураагүй | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн * | Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон | Зөвхөн сурсан | Аль алиныг нь | Бүгд | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн * | Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон | Зөвхөн сурсан | Бүгд | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн * | Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон | Аль алиныг нь хийгээгүй |
| Нийт | 100.0 | 9.7 | 74.8 | 8.2 | 7.3 | 100.0 | 4.8 | 84.2 | 11.0 | 100.0 | 24.3 | 47.0 | 28.7 |
| 5-6 | 100.0 | 6.7 | 46.1 | 0.7 | 46.5 | 100.0 | 0.0 | 84.3 | 15.7 | 100.0 | 7.0 | 44.4 | 48.6 |
| 7-9 | 100.0 | 7.1 | 72.1 | 14.8 | 6.0 | 100.0 | 3.6 | 75.5 | 20.9 | 100.0 | 15.3 | 64.2 | 20.5 |
| 10-14 | 100.0 | 7.0 | 82.9 | 9.6 | 0.5 | 100.0 | 4.3 | 85.5 | 10.2 | 100.0 | 46.5 | 44.1 | 9.4 |
| 15-17 | 100.0 | 17.9 | 76.7 | 4.6 | 0.8 | 100.0 | 6.5 | 87.7 | 5.8 | 100.0 | 60.1 | 36.1 | 3.8 |
| Эрэгтэй | 100.0 | 11.6 | 71.6 | 8.7 | 8.1 | 100.0 | 5.3 | 82.7 | 12.0 | 100.0 | 28.5 | 42.3 | 29.2 |
| 5-6 | 100.0 | 7.5 | 42.3 | 0.5 | 49.7 | 100.0 | 0.0 | 88.5 | 11.5 | 100.0 | 7.8 | 40.4 | 51.8 |
| 7-9 | 100.0 | 8.2 | 70.2 | 14.9 | 6.6 | 100.0 | 3.8 | 74.8 | 21.4 | 100.0 | 18.5 | 59.7 | 21.8 |
| 10-14 | 100.0 | 8.8 | 80.3 | 10.3 | 0.6 | 100.0 | 5.0 | 83.9 | 11.1 | 100.0 | 53.8 | 37.6 | 8.6 |
| 15-17 | 100.0 | 21.4 | 72.2 | 5.4 | 1.0 | 100.0 | 7.2 | 85.6 | 7.2 | 100.0 | 63.2 | 32.9 | 3.9 |
| Эмэгтэй | 100.0 | 7.7 | 78.1 | 7.7 | 6.5 | 100.0 | 4.2 | 85.8 | 10.0 | 100.0 | 19.2 | 52.7 | 28.1 |
| 5-6 | 100.0 | 5.8 | 50.2 | 0.9 | 43.1 | 100.0 | 0.0 | 79.8 | 20.2 | 100.0 | 6.1 | 48.8 | 45.1 |
| 7-9 | 100.0 | 5.8 | 74.1 | 14.6 | 5.5 | 100.0 | 3.4 | 76.2 | 20.4 | 100.0 | 11.8 | 69.1 | 19.1 |
| 10-14 | 100.0 | 5.0 | 85.7 | 8.8 | 0.5 | 100.0 | 3.6 | 87.2 | 9.2 | 100.0 | 33.8 | 55.3 | 10.9 |
| 15-17 | 100.0 | 14.3 | 81.3 | 3.8 | 0.6 | 100.0 | 5.8 | 89.6 | 4.6 | 100.0 | 55.4 | 41.0 | 3.6 |

* Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн зарим хүүхэд бас гэрийн ажил хийсэн байж болох юм.

*Хүснэгт 5.5.* **Сүүлийн 7 хоногт сургуульд суралцсан, ажил эрхэлсэн, гэрийн ажилд оролцсон 5-17 насны хүүхдийн тоо, өрхийн ам бүлийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр**

| Өрхийн ам бүлийн тоо/ Өрхийн тэргүүлэгчийн хүйс | Нийт хүүхэд | | | | | Сургуульд сурсан | | | | Сургуульд сураагүй | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн * | Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон | Зөвхөн сурсан | Аль алиныг нь хийгээгүй | Бүгд | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн * | Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон | Зөвхөн сурсан | Бүгд | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн * | Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон | Аль алиныг нь хийгээгүй |
| Нийт өрх: | 676911 | 65729 | 506284 | 55647 | 49251 | 505234 | 23931 | 425656 | 55647 | 171677 | 41798 | 80628 | 49251 |
| <3 | 14671 | 1221 | 12030 | 716 | 703 | 11640 | 282 | 10643 | 716 | 3030 | 939 | 1388 | 703 |
| 3-4 | 242994 | 20562 | 182850 | 17915 | 21666 | 173970 | 5959 | 150095 | 17915 | 69024 | 14602 | 32755 | 21666 |
| 5-6 | 296469 | 28834 | 225444 | 24501 | 17689 | 228339 | 11091 | 192747 | 24501 | 68130 | 17744 | 32697 | 17689 |
| 7-8 | 98319 | 12107 | 69834 | 9276 | 7102 | 73753 | 5311 | 59166 | 9276 | 24566 | 6796 | 10668 | 7102 |
| 9+ | 24460 | 3005 | 16126 | 3239 | 2091 | 17532 | 1288 | 13005 | 3239 | 6928 | 1716 | 3121 | 2091 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй | 590149 | 58903 | 437969 | 49489 | 43788 | 437871 | 21759 | 366623 | 49489 | 152278 | 37144 | 71346 | 43788 |
| <3 | 4261 | 471 | 3357 | 225 | 209 | 3317 | 98 | 2994 | 225 | 944 | 372 | 363 | 209 |
| 3-4 | 200103 | 18084 | 147101 | 15460 | 19458 | 140072 | 5234 | 119379 | 15460 | 60031 | 12850 | 27722 | 19458 |
| 5-6 | 271994 | 26036 | 207362 | 22527 | 16069 | 209609 | 10059 | 177022 | 22527 | 62386 | 15977 | 30339 | 16069 |
| 7-8 | 92198 | 11675 | 65524 | 8561 | 6438 | 68962 | 5184 | 55217 | 8561 | 23236 | 6491 | 10307 | 6438 |
| 9+ | 21592 | 2637 | 14625 | 2716 | 1614 | 15911 | 1184 | 12011 | 2716 | 5681 | 1453 | 2614 | 1614 |
| Эмэгтэй тэргүүлэгчтэй | 86763 | 6826 | 68315 | 6159 | 5463 | 67363 | 2172 | 59033 | 6159 | 19399 | 4654 | 9282 | 5463 |
| <3 | 10410 | 750 | 8674 | 491 | 495 | 8323 | 183 | 7649 | 491 | 2086 | 567 | 1025 | 495 |
| 3-4 | 42890 | 2478 | 35749 | 2455 | 2208 | 33898 | 726 | 30717 | 2455 | 8993 | 1752 | 5032 | 2208 |
| 5-6 | 24474 | 2798 | 18083 | 1974 | 1619 | 18730 | 1032 | 15725 | 1974 | 5744 | 1766 | 2358 | 1619 |
| 7-8 | 6120 | 432 | 4309 | 715 | 664 | 4791 | 127 | 3949 | 715 | 1329 | 305 | 360 | 664 |
| 9+ | 2868 | 368 | 1500 | 523 | 477 | 1621 | 105 | 993 | 523 | 1248 | 264 | 507 | 477 |

* Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн зарим хүүхэд бас гэрийн ажил хийсэн байж болох юм.

Хүснэгт 5.5а. **Сүүлийн 7 хоногт сургуульд суралцсан, ажил эрхэлсэн, гэрийн ажилд оролцсон 5-17 насны хүүхэд, өрхийн ам бүлийн тоо, өрхийн тэргүүлэгчийн хүйсээр**

(Хувиар)

| Өрхийн ам бүлийн тоо/ Өрхийн тэргүүлэгчийн хүйс | Нийт хүүхэд | | | | | Сургуульд сурсан | | | | Сургуульд сураагүй | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эдиний засгийн үйл ажиллагаа эрхэлсэн * | Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон | Зөвхөн сурсан | Аль алиныг нь хийгээгүй | Бүгд | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн * | Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон | Зөвхөн сурсан | Бүгд | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн * | Зөвхөн гэрийн ажил хийхэд оролцсон | Аль алиныг нь хийгээгүй |
| Нийт өрх: | 100.0 | 9.7 | 74.8 | 8.2 | 7.3 | 100.0 | 4.7 | 84.2 | 11.1 | 100.0 | 24.3 | 47.0 | 28.7 |
| <3 | 100.0 | 8.3 | 82.0 | 4.9 | 4.8 | 100.0 | 2.4 | 91.4 | 6.2 | 100.0 | 31.0 | 45.8 | 23.2 |
| 3-4 | 100.0 | 8.5 | 75.2 | 7.4 | 8.9 | 100.0 | 3.4 | 86.3 | 10.3 | 100.0 | 21.1 | 47.5 | 31.4 |
| 5-6 | 100.0 | 9.7 | 76.0 | 8.3 | 6.0 | 100.0 | 4.9 | 84.4 | 10.7 | 100.0 | 26.0 | 48.0 | 26.0 |
| 7-8 | 100.0 | 12.3 | 71.0 | 9.4 | 7.3 | 100.0 | 7.2 | 80.2 | 12.6 | 100.0 | 27.7 | 43.4 | 28.9 |
| 9+ | 100.0 | 12.3 | 65.9 | 13.3 | 8.5 | 100.0 | 7.3 | 74.2 | 18.5 | 100.0 | 24.8 | 45.0 | 30.2 |
| Эрэгтэй тэргүүлэгчтэй | 100.0 | 10.0 | 74.2 | 8.4 | 7.4 | 100.0 | 5.0 | 83.7 | 11.3 | 100.0 | 24.4 | 46.9 | 28.7 |
| <3 | 100.0 | 11.0 | 78.8 | 5.3 | 4.9 | 100.0 | 3.0 | 90.3 | 6.7 | 100.0 | 39.4 | 38.5 | 22.1 |
| 3-4 | 100.0 | 9.0 | 73.5 | 7.8 | 9.7 | 100.0 | 3.7 | 85.2 | 11.1 | 100.0 | 21.4 | 46.2 | 32.4 |
| 5-6 | 100.0 | 9.6 | 76.2 | 8.3 | 5.9 | 100.0 | 4.8 | 84.5 | 10.7 | 100.0 | 25.6 | 48.6 | 25.8 |
| 7-8 | 100.0 | 12.7 | 71.1 | 9.2 | 7.0 | 100.0 | 7.5 | 80.1 | 12.4 | 100.0 | 27.9 | 44.4 | 27.7 |
| 9+ | 100.0 | 12.2 | 67.7 | 12.6 | 7.5 | 100.0 | 7.4 | 75.5 | 17.1 | 100.0 | 25.6 | 46.0 | 28.4 |
| Эмэгтэй тэргүүлэгчтэй | 100.0 | 7.9 | 78.7 | 7.1 | 6.3 | 100.0 | 3.2 | 87.6 | 9.2 | 100.0 | 24.0 | 47.8 | 28.2 |
| <3 | 100.0 | 7.2 | 83.3 | 4.7 | 4.8 | 100.0 | 2.2 | 91.9 | 5.9 | 100.0 | 27.2 | 49.1 | 23.7 |
| 3-4 | 100.0 | 5.8 | 83.4 | 5.7 | 5.1 | 100.0 | 2.1 | 90.6 | 7.3 | 100.0 | 19.5 | 56.0 | 24.5 |
| 5-6 | 100.0 | 11.4 | 73.9 | 8.1 | 6.6 | 100.0 | 5.5 | 84.0 | 10.5 | 100.0 | 30.8 | 41.1 | 28.1 |
| 7-8 | 100.0 | 7.1 | 70.4 | 11.7 | 10.8 | 100.0 | 2.7 | 82.4 | 14.9 | 100.0 | 22.9 | 27.1 | 49.9 |
| 9+ | 100.0 | 12.8 | 52.3 | 18.3 | 16.6 | 100.0 | 6.5 | 61.2 | 32.3 | 100.0 | 21.1 | 40.6 | 38.3 |

* Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн зарим хүүхэд бас гэрийн ажил хийсэн байж болох юм.

### 5.5 Өрхөөс гадуур амьдарч буй хүүхдүүд

6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч буй 5-17 насны хүүхдийн талаарх тоо мэдээ, ямар шалтгаанаар өрхөөс гадуур байгааг *Хүснэгт 5.6*–д харуулав. Нийт 70,215 хүүхэд өрхөөс гадуур амьдарч байгаа нь судалгаанд хамрагдсан энэ насны 679,049 хүүхдийн 10.0 орчим хувьтай тэнцэж байгаа юм.

*Хүснэгт 5.6.* ***6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч буй 5-17 насны хүүхдийн тоо***

| Хот/Хөдөө | Бүгд | Үүнээс: | | |
|---|---|---|---|---|
| | | Сурч буй | Ажиллаж буй | Бусад |
| (1) | (2) | (3) | (4) | (5) |
| Нийт | 70215 | 66341 | 1636 | 2238 |
| Хот | 6669 | 5628 | 325 | 715 |
| Улаанбаатар | 711 | 559 | 0 | 152 |
| Аймгийн төв | 5958 | 5069 | 325 | 563 |
| *Хөдөө:* | 63546 | 60712 | 1311 | 1523 |
| Сумын төв | 9544 | 8630 | 465 | 450 |
| Хөдөө | 54002 | 52082 | 846 | 1073 |

*Хүснэгт 5.6а.* ***6 сараас дээш хугацаагаар өрхөөс гадуур амьдарч буй 5-17 насны хүүхдийн дүнд эзлэх хувь***

| Хот/Хөдөө | Нийт хүүхэд | Үүнээс: | | |
|---|---|---|---|---|
| | | Сурч буй | Ажиллаж буй | Бусад |
| (1) | (2) | (3) | (4) | (5) |
| Нийт | 100.0 | 94.5 | 2.3 | 3.2 |
| Хот | 100.0 | 84.4 | 4.9 | 10.7 |
| Улаанбаатар | 100.0 | 78.6 | 0.0 | 21.4 |
| Аймгийн төв | 100.0 | 85.1 | 5.5 | 9.4 |
| Хөдөө | 100.0 | 95.5 | 2.1 | 2.4 |
| Сумын төв | 100.0 | 96.4 | 1.6 | 2.0 |
| Хөдөө | 100.0 | 96.4 | 1.6 | 2.0 |

Өрхөөс гадуур амьдарч буй хүүхдийн 90.5 хувь нь хөдөө орон нутагт (63546 хүүхэд), 9.5 хувь нь хот, суурин газарт (6669 хүүхэд) байна. Хөдөөд өрхөөс гадуур амьдарч буй хүүхдийн тоо өндөр байгаа нь сургууль хүрэлцэхгүй, хол байгаатай холбоотой, нийт хүүхдүүдийн 95.5 хувь нь сурах шалтгаанаар өрхөөс гадуур амьдарч байна. Хот, суурин газрын хүүхдийн өрхөөс гадуур амьдарч байгаа үндсэн шалтгаан нь суралцахтай холбоотой байгаа бөгөөд энэ шалтгаан нь 84.4 хувьтай байна. Өрхөөс гадуур амьдарч буй хот, суурин газрын хүүхдийн 4.9 хувь нь ажиллаж, харин 10.7 гаруй хувь нь суралцах эсвэл ажиллах зорилгогүй, улмаар шалтгаан нь тодорхой бус байгаад анхааран гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй.

### 5.6 Сургуульд суралцаагүй шалтгаан

*Хүснэгт 5.4*-өөс үзэхэд 5-17 насны нийт хүүхдийн 25.4 хувь (676911 хүүхдийн 171,677)

нь сүүлийн 7 хоногт сургуульд суралцаагүй байна. Хүүхдүүд сургуульд суралцаагүйн шалтгааныг *Хүснэгт 5.7*-д харуулав. Сургуульд суралцаагүй хүүхдийн 55.1 хувь буюу 94,574 нь хөвгүүд, 44.9 хувь буюу 77,082 нь охид байв. Сургуульд хамрагдаагүй хүүхдийн тоо, эзлэх хувь насны бүлэгтэй урвуу хамааралтай байгаа бөгөөд 5-6 насны бүлгээс дээшхи 7-9, 10-14 насны бүлгүүдэд багасч байна (*Хүснэгт 5.7а*). Гэхдээ 10-14 насны бүлэгтэй харьцуулахад 15-17 насанд сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн эзлэх хувь эрс өсчээ. Охидын хувьд энэ үзүүлэлт илүү, 10-14 насанд 6673 байсан бол 15-17 насанд 14,608 болж эрс нэмэгджээ. 10-14 насны хөвгүүдийн 11,731 нь сургуульд хамрагдаагүй байхад 15-17 насанд энэ тоо 21,834 болж өссөн байна.

5-17 насны 171,677 хүүхэд /үүний 94,818 нь эрэгтэй, 76,860 нь эмэгтэй/ сургуульд суралцахгүй байгаагийн дотор 64.3 хувь буюу 110,432 нь сургуулийн өмнөх насны хүүхдүүд байна. Сургуулийн насны хүүхдүүдээс өрхийн орлогод хувь нэмэр оруулах, мөн гэр орныхоо ажилд туслах зорилгоор 24,008, ном сурах бичиг, сургуулийн дүрэмт хувцас зэрэг сургалтын зардлыг төлөх чадваргүй гэсэн шалтгаанаар 8,289 хүүхэд сургууль завсарджээ. Өвчтэй, тахир дутуугийн улмаас сургуульд яваагүй гэж хариулсан хүүхдүүд 8,435, сургууль хол, сурах сонирхолгүй гэж хариулсан 14,140 хүүхэд, бусад шалтгаанаар сургууль завсардсан 6,352 хүүхэд байна. Хүүхдүүдийн сургуульд хамрагдаагүйн шалтгааны бүтцийг Зураг 1-ээс харна уу.

*Зураг 1.* ***5-17 насны хүүхдүүдийн сургуульд хамрагдаагүй шалтгааны бүтэц, хувиар***



*Хүснэгт 5.7.* **5-17 насны сургуульд хамрагдаагүй хүүхдийн тоо, шалтгаан, насны бүлэг, хүйсээр**

| Насны бүлэг/ хүйс | Сургуульд хамрагдаагүй нийт хүүхэд | Сургууль, курст хамрагдаагүй шалтгаан | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Сургуулийн насанд хүрээгүй | Сургууль хол | Хичээлийн хэрэглэл, хувцас зэрэг зардлыг гаргаж чадахгүй | Сурлага муу, сурах сонирхолгүй | Өрхийн орлогод нэмэр болох | Гэрийн ажилд туслах | Өвчтэй | Тахир дутуу | Бусад |
| Нийт: | 171677 | 110432 | 2804 | 8289 | 11336 | 8502 | 15506 | 5488 | 2947 | 6373 |
| 5-6 | 78819 | 77194 | 585 | 315 | 0 | 0 | 129 | 0 | 0 | 596 |
| 7-9 | 38013 | 32968 | 363 | 805 | 645 | 237 | 844 | 838 | 438 | 874 |
| 10-14 | 18404 | 99 | 751 | 3291 | 3713 | 1525 | 3814 | 2525 | 1480 | 1206 |
| 15-17 | 36442 | 171 | 1105 | 3877 | 6978 | 6741 | 10719 | 2125 | 1029 | 3697 |
| | | | | | | | | | | 0 |
| Эрэгтэй: | 94818 | 57271 | 1685 | 4700 | 7364 | 5622 | 9861 | 2679 | 1945 | 3691 |
| 5-6 | 41384 | 40366 | 325 | 136 | 0 | 0 | 129 | 0 | 0 | 428 |
| 7-9 | 19868 | 16730 | 273 | 493 | 344 | 172 | 458 | 340 | 269 | 789 |
| 10-14 | 11731 | 57 | 427 | 1940 | 2508 | 1243 | 2554 | 1346 | 1059 | 598 |
| 15-17 | 21834 | 117 | 660 | 2131 | 4512 | 4207 | 6720 | 994 | 616 | 1876 |
| | | | | | | | | | | 0 |
| Эмэгтэй: | 76860 | 53161 | 1120 | 3588 | 3972 | 2881 | 5645 | 2809 | 1002 | 2682 |
| 5-6 | 37434 | 36827 | 261 | 179 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 168 |
| 7-9 | 18145 | 16238 | 90 | 312 | 301 | 65 | 386 | 499 | 169 | 85 |
| 10-14 | 6673 | 42 | 324 | 1351 | 1205 | 282 | 1259 | 1179 | 421 | 609 |
| 15-17 | 14608 | 53 | 445 | 1746 | 2466 | 2534 | 4000 | 1131 | 412 | 1821 |

*Хүснэгт 5.7а.* ***Сургууль, курст хамрагдаагүй 5 – 17 насны хүүхдийн дунд эзлэх хувь, шалтгаан, насны бүлэг, хүйсээр***

| Насны бүлэг/хүйс | Сургуульд хамрагдаагүй нийт хүүхэд | Сургууль, курст хамрагдаагүй шалтгаан | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Сургуулийн насанд хүрээгүй | Сургууль хол | Хичээлийн хэрэглэл, хувцас зэрэг зардлыг гаргаж чадахгүй | Сурлага муу/ сурах сонирхолгүй | Өрхийн орлогод нэмэр болох | Гэрийн ажилд туслах | Өвчтэй | Тахир дутуу | Бусад |
| Нийт: | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 5-6 | 45.9 | 69.9 | 20.9 | 3.8 | 0.0 | 0.0 | 0.8 | 0.0 | 0.0 | 9.3 |
| 7-9 | 22.1 | 29.9 | 12.9 | 9.7 | 5.7 | 2.8 | 5.4 | 15.3 | 14.9 | 13.8 |
| 10-14 | 10.7 | 0.1 | 26.8 | 39.7 | 32.8 | 17.9 | 24.6 | 46.0 | 50.2 | 18.9 |
| 15-17 | 21.2 | 0.2 | 39.4 | 46.8 | 61.6 | 79.3 | 69.1 | 38.7 | 34.9 | 58.0 |
| Эрэгтэй: | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 5-6 | 43.6 | 70.5 | 19.3 | 2.9 | 0.0 | 0.0 | 1.3 | 0.0 | 0.0 | 11.6 |
| 7-9 | 21.0 | 29.2 | 16.2 | 10.5 | 4.7 | 3.1 | 4.6 | 12.7 | 13.8 | 21.4 |
| 10-14 | 12.4 | 0.1 | 25.3 | 41.3 | 34.1 | 22.1 | 25.9 | 50.2 | 54.5 | 16.2 |
| 15-17 | 23.0 | 0.2 | 39.2 | 45.3 | 61.3 | 74.8 | 68.1 | 37.1 | 31.7 | 50.8 |
| Эмэгтэй: | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 5-6 | 48.7 | 69.3 | 23.3 | 5.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 6.3 |
| 7-9 | 23.6 | 30.5 | 8.1 | 8.7 | 7.6 | 2.3 | 6.8 | 17.8 | 16.8 | 3.2 |
| 10-14 | 8.7 | 0.1 | 28.9 | 37.7 | 30.3 | 9.8 | 22.3 | 42.0 | 42.0 | 22.7 |
| 15-17 | 19.0 | 0.1 | 39.7 | 48.7 | 62.1 | 88.0 | 70.9 | 40.3 | 41.1 | 67.8 |

*Хүснэгт 5.7б.* ***5-17 насны хүүхдийн сургууль, курст хамрагдаагүй шалтгааны бүтэц, насны бүлэг, хүйсээр***

| Насны бүлэг/ хүйс | Сургуульд хамрагдаагүй нийт хүүхэд | Сургууль, курст хамрагдаагүй шалтгаан | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Сургуулийн насанд хүрээгүй | Сургууль хол | Хичээлийн хэрэглэл, хувцас зэрэг зардлыг гаргаж чадахгүй | Сурлага муу, сурах сонирхолгүй | Өрхийн орлогод нэмэр болох | Гэрийн ажилд туслах | Өвчтэй | Тахир дутуу | Бусад |
| Нийт: | 100.0 | 64.3 | 1.6 | 4.8 | 6.6 | 5.0 | 9.0 | 3.2 | 1.7 | 3.7 |
| 5-6 | 100.0 | 97.9 | 0.7 | 0.4 | 0.0 | 0.0 | 0.2 | 0.0 | 0.0 | 0.8 |
| 7-9 | 100.0 | 86.7 | 1.0 | 2.1 | 1.7 | 0.6 | 2.2 | 2.2 | 1.2 | 2.3 |
| 10-14 | 100.0 | 0.5 | 4.1 | 17.9 | 20.2 | 8.3 | 20.7 | 13.7 | 8.0 | 6.6 |
| 15-17 | 100.0 | 0.5 | 3.0 | 10.6 | 19.1 | 18.5 | 29.4 | 5.8 | 2.8 | 10.1 |
| Эрэгтэй: | 100.0 | 60.4 | 1.8 | 5.0 | 7.8 | 5.9 | 10.4 | 2.8 | 2.1 | 3.9 |
| 5-6 | 100.0 | 97.5 | 0.8 | 0.3 | 0.0 | 0.0 | 0.3 | 0.0 | 0.0 | 1.0 |
| 7-9 | 100.0 | 84.2 | 1.4 | 2.5 | 1.7 | 0.9 | 2.3 | 1.7 | 1.4 | 4.0 |
| 10-14 | 100.0 | 0.5 | 3.6 | 16.5 | 21.4 | 10.6 | 21.8 | 11.5 | 9.0 | 5.1 |
| 15-17 | 100.0 | 0.5 | 3.0 | 9.8 | 20.7 | 19.3 | 30.8 | 4.6 | 2.8 | 8.6 |
| Эмэгтэй: | 100.0 | 69.2 | 1.5 | 4.7 | 5.2 | 3.7 | 7.3 | 3.7 | 1.3 | 3.5 |
| 5-6 | 100.0 | 98.4 | 0.7 | 0.5 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.4 |
| 7-9 | 100.0 | 89.5 | 0.5 | 1.7 | 1.7 | 0.4 | 2.1 | 2.7 | 0.9 | 0.5 |
| 10-14 | 100.0 | 0.6 | 4.9 | 20.3 | 18.1 | 4.2 | 18.9 | 17.7 | 6.3 | 9.1 |
| 15-17 | 100.0 | 0.4 | 3.0 | 12.0 | 16.9 | 17.3 | 27.4 | 7.7 | 2.8 | 12.5 |

Бүлэг 6

# АЖИЛ ЭРХЭЛЖ БУЙ ХҮҮХДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙСЭЭР

### 6.1 Удиртгал

Судалгаагаар ажил эрхэлж байгаа буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн 5-17 насны хүүхдүүдийг хүйс, байршил, насны бүлгээр (5-9, 10-14, 15-17) ангилан байнгын болон тухайн үеийн идэвхийн аргачлалаар тооцож гаргасан. Түүнчлэн Бүлэг 5-аас үзэхэд сургуульд хамрагдсан болон сургуульд хамрагдаагүй нийт хүүхдийн дийлэнх нь гэрийн ажилд оролцож байна. Иймд энэ бүлэгт мөн хүүхдүүдийн эдийн засгийн бус үйл ажиллагааг тооцож, дүнг нь гаргаж харуулсан. Бүлэг 4-т дурьдсанчлан эдийн засгийн идэвхийг:

- *Байнгын идэвхи буюу сүүлийн 12 сарын байдлаар*
- *Тухайн үеийн идэвхи буюу судалгааны өмнөх сүүлийн 7 хоногийн байдлаар гэж тодорхойлно.*

Ажил эрхэлж буй хүүхэд гэдэг нь ажил болон хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг хамруулсан өргөн хүрээний ойлголт юм. Хувиараа хөдөлмөр эрхэлж буй, эсвэл бусдад хөлстэй болон хөлсгүй, байнгын болон түр зуурын ажил хийж буй, хууль бусаар хөдөлмөр эрхэлж буй, албан болон албан бус секторт ажиллаж буй хүүхдүүдийг эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн гэж үзнэ. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн гэдэг нь ажил эрхлэлтийг тооцох олон улсын жишиг ойлголт юм[13].

### 6.2 Хүүхдийн эдийн засгийн идэвхийн байдал[14]

Эдийн засгийн идэвхийн ангиллыг ашиглан 5-17 насны ажил эрхэлж буй хүүхдийн талаарх тоо мэдээг гаргана. Үүнд:

1. Ажил эрхэлж буй буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн
   а. Зөвхөн ажил эрхэлж буй хүүхэд (сургуульд сурдаггүй, гэрийн ажилд тусалдаг, эсвэл тусалдаггүй)
   б. Ажил ч хийдэг, сургуульд ч сурдаг (гэрийн ажилд тусалдаг, эсвэл тусалдаггүй)
2. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй
   а. Зөвхөн сургуульд сурдаг
   б. Сургуульд сурдаг, гэрийн ажилд тусалдаг
3. Ажил ч хийдэггүй, сургуульд ч сурдаггүй
   а. Зөвхөн гэрийн ажилд тусалдаг
   б. Сургуульд ч сурдаггүй, гэрийн ажилд ч тусалдаггүй, ажил ч хийдэггүй (өвчтэй, тахир дутуу зэрэг хүүхдүүдийг оруулаад)

Ангиллын түвшин бүрт эдийн засгийн идэвхийн байдлыг маш нарийвчлан, давхардуулалгүйгээр гаргасан бөгөөд ингэснээр нэг хүүхэд зөвхөн нэг ангилалд өөрөөр хэлбэл ажил эрхлэлтийн байдал нь нэг байхаар тооцоолон гаргасан болно. Ангиллын энэ схемийг хэрэглэснээр “эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй” хүүхдүүдийн ангилал нь “сургуульд сурч буй” хүүхдийн ангиллаас илүү ач холбогдолтой юм. Тиймээс сургуульд сурч байхдаа ажил хийж буй хүүхдүүд нь ангиллын анхан шатны түвшинд “ажил хийж буй” ангилалд тооцогдон, харин ангиллын хоёр дахь түвшинд тусдаа ангилагдан тооцоологдсон. “Сургуульд сурч байгаа” гэдэгт судалгааны долоо хоногт ямар нэг сургуульд суралцаж байгаа хүүхдүүд гэж ойлгоно. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдүүдийн тоог тооцохдоо хоёр нөхцөл байдлыг анхааралдаа авах ёстойг тэмдэглэх нь

[13] *Эдийн засгийн идэвхитэй хүүхэд, ажил эрхлэлт, ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлт, Хавсралт ОУХБ, Женев хот, 1990.*
[14] *Хүүхдийн Хөдөлмөрийн Тоо Мэдээ, Дэлхийн Хэмжээнд, ОУХБ/ХХУОУХ-ХХС, Женев хот, 2002 оны 4-р сар.*

зүйтэй юм.

Үүнд:

а) зөвхөн ажил эрхэлж буй хүүхдүүд,

б) суралцахын зэрэгцээ ажил эрхэлж буй хүүхдүүд.

Хүүхдийн өөрийн гэртээ хийж буй ойр зуурын (ахуйн) ажлыг эдийн засгийн үйл ажиллагаанд оруулдаггүй тул ДНБ-ийг тооцдог НҮБ-ын ҮТС-ийн 1993 оны аргачлалаар тодорхойлогдсон "үйлдвэрлэлийн хүрээ"-нд хамаардаггүй. Тиймээс ажил хийж буй хүүхдүүдийн тооцоонд эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүдийг хамруулаагүй болно.

## 6.3 Ажил эрхэлж буй хүүхдүүдийн тоо, тухайн үеийн идэвхээр

5-17 насны хүүхдүүдийн тухайн үеийн эдийн засгийн идэвхийн байдлыг хүйсээр ангилан тооцсон дүнг *Хүснэгт 6.1*-д харуулав.

*Хүснэгт 6.1.* ***5-17 насны хүүхдийн сүүлийн 7 хоногийн буюу тухайн үеийн эдийн засгийн идэвхийн байдал, хүйсээр***

| Хүйс | 5-17 насны нийт хүүхэд | Ажил эрхэлж буй хүүхдүүд (эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн)* | | | Ажил хийгээгүй хүүхдүүд | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй (гэхдээ сургуульд сурдаг) | | Ажил хийгээгүй, сургуульд сураагүй | |
| | | Ажил эрхэлж буй нийт хүүхэд ** | Зөвхөн ажил эрхэлж буй | Ажил хийж, сургуульд сурч буй | Зөвхөн сургуульд сурдаг | Сургуульд сурдаг, эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг | Зөвхөн эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг | Ажил эрхлээгүй, эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхлээгүй |
| (1) | (2) | (3)=(4)+(5) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) |
| Нийт | 676911 | 65729 | 41798 | 23931 | 55647 | 425656 | 80628 | 49251 |
| Эрэгтэй | 346867 | 40406 | 27028 | 13378 | 30292 | 208379 | 40144 | 27646 |
| Эмэгтэй | 330045 | 25323 | 14770 | 10553 | 25356 | 217277 | 40485 | 21605 |

*Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй зарим хүүхэд гэрийн ажилд тусалж байж болно
** Сүүлийн 7 хоногт ажиллаагүй боловч ер нь ажил эрхлэдэг 5-17 насны 2851 (Хүснэгт 6.3-ийг харна уу) хүүхдийг хасав, багана (4) ба (5)-д оруулах боломжгүй байв.

*Хүснэгт 5.4*-д үндэслэн энэ дүнг тооцон хүүхдүүдийг ажил эрхэлж буй болон ажил эрхлээгүй гэж хоёр бүлэглэв. Тайлангийн энэ бүлэгт ажил эрхэлж буй болон ажил эрхлээгүй хүүхдүүдийн (өөрөөр хэлбэл эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд, зөвхөн сургуульд сурч буй, сургуульд ч сураагүй, ажил ч эрхлээгүй, гэрийн ажилд ч тусалдаггүй) талаар голчлон танилцуулах тул ингэж бүлэглэсэн болно. Тухайн үеийн идэвхийн байдлаар 5-17 насны 68580*(Хүснэгт 6.3-аас харна уу) хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажилтай гэж ангилагдав. *Хүснэгт 6.2*-оос харахад нийт хүүхдийн 10.1 хувь нь ажил эрхэлж, харин үлдсэн 89.1 хувийг ажил эрхлээгүй буюу эдийн засгийн идэвхигүй хүүхэд эзэлж байна. 5-9 насны бүлэгт ажил эрхэлж буй хүүхдийн эзлэх хувь 7.2, харин 15-17 насанд нэлээд өндөр, 18.5 хувьтай байна. Монгол Улсын хуулинд 15-16 наснаас эхлэн тодорхой хязгаарлалттайгаар эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн байдаг.

Хүснэгтээс харахад ажил хийж буй хөвгүүдийн тоо охидынхоос өндөр байна. 5-14 насанд ажил хийж буй хөвгүүдийн эзлэх хувь 8.7, охидынх 5.7 хувь байна. 15-17 насны бүлэгт энэ үзүүлэлт хөвгүүдийн хувьд 22.1, охидын хувьд 14.9 байна.

*Хүснэгт 6.2.* ***Ажил эрхэлж буй хүүхдийн тоо, дунд эзлэх хувь, насны бүлэг, хүйсээр***

| Хүйс, насны бүлэг | Нийт хүүхэд | Ажил эрхэлж буй хүүхдийн тоо | Дунд эзлэх хувь (%) |
|---|---|---|---|
| (1) | (2) | (3) | (4) |
| Бүгд | 679049* | 68580 | 10.1 |
| 05-09 | 212145 | 15320 | 7.2 |
| 10-14 | 294841 | 21407 | 7.3 |
| ***05-14*** | ***506986*** | ***36727*** | ***7.2*** |
| 15-17 | 172063 | 31854 | 18.5 |
| Хөвгүүд | | | |
| Бүгд (5 -17) | 347652 | 41874 | 12.0 |
| 05-09 | 109205 | 9005 | 8.2 |
| 10-14 | 151999 | 13762 | 9.1 |
| ***05-14*** | ***261204*** | ***22767*** | ***8.7*** |
| 15-17 | 86449 | 19107 | 22.1 |
| Охид | | | |
| Бүгд (5 -17) | 331397 | 26706 | 8.1 |
| 05-09 | 102940 | 6315 | 6.1 |
| 10-14 | 142843 | 7645 | 5.4 |
| ***05-14*** | ***245783*** | ***13960*** | ***5.7*** |
| 15-17 | 85614 | 12746 | 14.9 |

*- Энэ тоо хүснэгт 6.1-ийн 2-р баганад дурдсан тооноос зөрж буй учир нь 2,138 хүүхэд асуулганд хариулаагүйтэй холбоотой.

*Зураг 2.* ***Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдийн тоо, насны бүлэг, хүйсээр***



*Хүснэгт 6.3*-т тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн тоог ажил эрхлэлтийн байдал, долоо хоногт үндсэн ажил эрхлэлтэнд зарцуулсан дундаж цагаар тооцсоноос харахад тухайн үеийн байдлаар ажил хийж байгаа нийт 68580 хүүхдийн 2851 нь ажлын байртай ч гэсэн сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхлээгүй буюу ажил хийгээгүй хүүхдүүд байна.

Иймд энэ тайланд сүүлийн 7 хоногт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн буюу ажил хийж буй 65729 хүүхдийн талаарх үзүүлэлтүүдийг



дэлгэрэнгүй тооцож оруулсан. *Хүснэгт 6.3*-аас үзэхэд сүүлийн 7 хоногт ажил хийсэн 65729 хүүхдийн 706 нь цалин хөлстэй ажил, дийлэнх болох 65023 хүүхэд хувиараа хөдөлмөр эрхэлсэн эсвэл өрхийн аж ахуйн бизнест цалин хөлсгүй ажилласан байна. Нас болон хүйсийн бүтцээр харахад цалин хөлстэй ажил хийсэн хөвгүүдийн тоо (452) охидынхоос (254) өндөр байна. Ийм хандлага хувиараа хөдөлмөр эрхлэлт болон цалин хөлсгүй ажил хийж байгаа нийт хүүхдэд ч ажиглагдав (39955 хөвгүүд, 25068 охид). Цалин хөлстэй ажил эрхэлсэн хүүхдийн дийлэнх (566) нь 15-17 насныхан байна. 10-14 насны зарим хөвгүүд (140) цалин хөлстэй ажил хийсэн бол ийм ажил хийсэн охид 15-17 насныхан л байна. Цалин хөлстэй ажил хийсэн 15-17 насны хүүхдүүд дунджаар 50,7 цагийг долоо хоногт энэ ажилдаа зарцуулсан нь ОУХБ-аас тогтоосон "хүүхдийн хөдөлмөр" гэсэн ангилалд тооцох цагаас үлэмж дээгүүр байгаа юм[15]. Түүнчлэн цалин хөлстэй ажил хийж буй насанд хүрэгчдийн долоо хоногт зарцуулж буй цагаас ч өндөр байгаа боловч ийм ажил эрхэлж буй хүүхдийн тоо маш цөөн байгаа тул энэ талаар дүгнэлт хийхдээ болгоомжтой хандах хэрэгтэй. Бүх насны бүлэгт хөвгүүд охидтой харьцуулбал хувиараа хөдөлмөр эрхлэх, цалин хөлсгүй ажил эрхлэхэд долоо хоногт илүү олон цаг зарцуулж байна. Ажил эрхэлж буй охид, хөвгүүдийн эзлэх хувийг насны бүлгээр харахад ерөнхийдөө адил байна. Ажил эрхэлж буй хүүхдийн тоог хот, хөдөөгөөр *Хүснэгт 6.3а*-д харуулав. Нийт ажил эрхэлж буй хүүхдийн дийлэнх нь хөдөө орон нутагт (61686) байхад хот, суурин газарт ажил эрхэлж буй хүүхэд ердөө 6894 байна. Цалин хөлстэй ажил эрхэлж буй хүүхдийн ихэнх нь хот, суурин газарт байна. Хот, суурин газарт ажил эрхэлж буй хүүхдийн 8.4 хувийг цалин хөлстэй ажил эрхэлж буй хүүхэд эзэлж байхад хөдөө орон нутагт энэ үзүүлэлт 0.2 хувьтай байна. Түүнчлэн хүүхдийн ажил эрхлэлтийг хот, хөдөөгөөр харьцуулахад эдийн засгийн үйл ажиллагаа буюу ажил эрхэлж буй нийт хүүхдэд 5-9 насны хүүхдийн эзлэх хувь хөдөө орон нутагт 23.9 байхад хотод ердөө 8.1 хувь байна. *Хүснэгт 6.3б*, *6.3в*-д тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн хүүхдийн дунд эзлэх хувийг насны бүлэг, хүйс, ажил эрхлэлтийн байдлаар тооцож харуулав.

[15] *Бүлэг 2.6-д байгаа ойлголт, тодорхойлолтыг үзнэ үү.*

Хүснэгт 6.3. **Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, долоо хоногт ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цаг, хүйсээр**

| Насны бүлэг/Хүйс | Бүгд | Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн хүн амын тоо | | | | Долоо хоногт үндсэн ажил эрхлэлтэнд зарцуулсан дундаж цаг | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй ч ажлын байртай | Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн | Цалин хөлстэй ажил эрхэлсэн | Хувиараа хөдөлмөр эрхлэгч | Цалин хөлстэй ажил эрхэлсэн | Хувиараа хөдөлмөр эрхлэгч |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) |
| Нийт ажил эрхэлж буй хүн амын тоо | 899282 | 63712 | 835570 | 297996 | 537574 | 44.8 | 44.4 |
| Ажил эрхэлж буй хүүхэд - | 68580 | 2851 | 65729 | 706 | 65023 | | |
| үүнээс: 5-9 | 15320 | 687 | 14633 | 0 | 14633 | - | 14.8 |
| 10-14 | 21407 | 971 | 20436 | 140 | 20296 | 18.4 | 25.4 |
| 15-17 | 31854 | 1194 | 30660 | 566 | 30094 | 50.7 | 37.3 |
| Эрэгтэй - | 41874 | 1468 | 40406 | 452 | 39955 | | |
| 5-9 | 9005 | 343 | 8662 | 0 | 8662 | - | 16.0 |
| 10-14 | 13762 | 459 | 13302 | 140 | 13162 | - | 27.5 |
| 15-17 | 19107 | 665 | 18442 | 311 | 18131 | 18.4 | 40.7 |
| Эмэгтэй - | 26706 | 1384 | 25323 | 254 | 25068 | | |
| 5-9 | 6315 | 343 | 5971 | 0 | 5971 | - | 12.9 |
| 10-14 | 7645 | 511 | 7134 | 0 | 7134 | - | 21.6 |
| 15-17 | 12746 | 529 | 12217 | 254 | 11963 | 52.5 | 32.1 |

*Хүснэгт 6.3а.* ***Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн 5-17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, долоо хоногт ажил эрхлэхэд зарцуулсан дундаж цагаар, хүйсээр***

| Насны бүлэг/хүйс | Бүгд | Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн хүүхэд | | | | Долоо хоногт үндсэн ажил эрхлэлтэнд зарцуулсан дундаж цаг | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй ч ажлын байртай | Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн | Цалин хөлстэй ажил | Хувиараа хөдөлмөр эрхлэгч | Цалин хөлстэй ажил | Хувиараа хөдөлмөр эрхлэгч |
| **Хот** | **6894** | **178** | **6716** | **580** | **6136** | | |
| 5-9 | 560 | 0 | 560 | 0 | 560 | - | 16.2 |
| 10-14 | 2662 | 126 | 2537 | 140 | 2396 | 18.4 | 17.0 |
| 15-17 | 3672 | 52 | 3620 | 440 | 3180 | 50.7 | 32.3 |
| Эрэгтэй | 4558 | 178 | 4380 | 362 | 4018 | | |
| 5-9 | 328 | 0 | 328 | 0 | 328 | - | 12.5 |
| 10-14 | 2004 | 126 | 1878 | 140 | 1738 | 18.4 | 17.3 |
| 15-17 | 2226 | 52 | 2174 | 222 | 1952 | 49.5 | 33.2 |
| Эмэгтэй | 2336 | 0 | 2336 | 218 | 2118 | | |
| 5-9 | 231 | 0 | 231 | 0 | 231 | - | 21.4 |
| 10-14 | 659 | 0 | 659 | 0 | 659 | - | 16.2 |
| 15-17 | 1446 | 0 | 1446 | 218 | 1228 | 51.9 | 30.8 |
| **Хөдөө** | **61686** | **2673** | **59013** | **126** | **58887** | | |
| 5-9 | 14760 | 687 | 14073 | 0 | 14073 | - | 14.7 |
| 10-14 | 18745 | 845 | 17900 | 0 | 17900 | - | 26.6 |
| 15-17 | 28182 | 1142 | 27040 | 126 | 26914 | 50.6 | 37.9 |
| Эрэгтэй | 37316 | 1290 | 36026 | 90 | 35937 | | |
| 5-9 | 8676 | 343 | 8333 | 0 | 8333 | - | 16.2 |
| 10-14 | 11758 | 334 | 11424 | 0 | 11424 | - | 29.1 |
| 15-17 | 16882 | 613 | 16269 | 90 | 16179 | 48.5 | 41.6 |
| Эмэгтэй | 24370 | 1384 | 22986 | 36 | 22950 | | |
| 5-9 | 6083 | 343 | 5740 | 0 | 5740 | - | 12.6 |
| 10-14 | 6987 | 511 | 6475 | 0 | 6475 | - | 22.1 |
| 15-17 | 11300 | 529 | 10771 | 36 | 10735 | 56.0 | 32.3 |

*Хүснэгт 6.3б.* ***Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн 5–17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр***

| Насны бүлэг/ хүйс | Бүгд | Тухайн үед ажил эрхэлсэн | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Сүүлийн 7 хоногт ажиллаагүй ч ажлын байртай | Сүүлийн 7 хоногт ажилласан | Цалин хөлстэй ажил эрхэлсэн | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, өрхийн бизнест цалин хөлсгүй . оролцогч |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) |
| Нийт ажил эрхэлсэн хүн ам | 100.0 | 7.1 | 92.9 | 35.7 | 64.3 |
| Ажил эрхэлсэн хүүхдүүд | 100.0 | 4.2 | 95.8 | 1.1 | 98.9 |
| үүнээс: 5-9 | 100.0 | 4.5 | 95.5 | 0.0 | 100.0 |
| 10-14 | 100.0 | 4.5 | 95.5 | 0.7 | 99.3 |
| 15-17 | 100.0 | 3.7 | 96.3 | 1.8 | 98.2 |
| Эрэгтэй | 100.0 | 3.5 | 96.5 | 1.1 | 98.9 |
| 5-9 | 100.0 | 3.8 | 96.2 | 0.0 | 100.0 |
| 10-14 | 100.0 | 3.3 | 96.7 | 1.1 | 98.9 |
| 15-17 | 100.0 | 3.5 | 96.5 | 1.7 | 98.3 |
| Эмэгтэй | 100.0 | 5.2 | 94.8 | 1.0 | 99.0 |
| 5-9 | 100.0 | 5.4 | 94.6 | 0.0 | 100.0 |
| 10-14 | 100.0 | 6.7 | 93.3 | 0.0 | 100.0 |
| 15-17 | 100.0 | 4.2 | 95.8 | 2.1 | 97.9 |

*Хүснэгт 6.3в.* ***Тухайн үеийн байдлаар ажил эрхэлсэн 5–17 насны хүүхэд, насны бүлэг, ажил эрхлэлтийн байдал, хүйсээр, хувиар***

| Насны бүлэг/хүйс | Бүгд | Тухайн үед ажил эрхэлсэн | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Сүүлийн 7 хоногт ажиллаагүй ч ажлын байртай | Сүүлийн 7 хоногт ажилласан | Цалин хөлстэй ажил эрхэлсэн | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) |
| Нийт хүүхэд - | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| үүнээс: 5-9 | 22.3 | 24.1 | 22.3 | 0.0 | 22.5 |
| 10-14 | 31.2 | 34.0 | 31.1 | 19.8 | 31.2 |
| 15-17 | 46.5 | 41.9 | 46.6 | 80.2 | 46.3 |
| Эрэгтэй | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 5-9 | 21.5 | 23.4 | 21.5 | 0.0 | 21.7 |
| 10-14 | 32.9 | 31.3 | 32.9 | 31.0 | 32.9 |
| 15-17 | 45.6 | 45.3 | 45.6 | 69.0 | 45.4 |
| Эмэгтэй | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 5-9 | 23.6 | 24.8 | 23.6 | 0.0 | 23.8 |
| 10-14 | 28.6 | 36.9 | 28.2 | 0.0 | 28.5 |
| 15-17 | 47.8 | 38.3 | 48.2 | 100.0 | 47.7 |

*Хүснэгт 6.4.* ***Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүүхэд, насны бүлэг, хот, хөдөө, долоо хоногт ажилласан дундаж цаг, хүйсээр***

| Насны бүлэг/хүйс | Тухайн үед өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүүхдийн тоо | | | | 7 хоногт ажилласан дундаж цаг | |
|---|---|---|---|---|---|---|
| | Сүүлийн 7 хоногт ажиллаагүй | Сүүлийн 7 хоногт ажилласан | | | | |
| | | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Эрэгтэй | Эмэгтэй |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) |
| Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч нийт хүн | 8639 | 239628 | 100976 | 138651 | 40.2 | 34.9 |
| Нийт хүүхэд: | 2020 | 59657 | 36382 | 23276 | - | - |
| Үүнээс: 5-9 | 687 | 14514 | 8585 | 5929 | 16.1 | 13.4 |
| 10-14 | 782 | 18510 | 11808 | 6702 | 27.9 | 22.8 |
| 15-17 | 552 | 26633 | 15989 | 10645 | 39.4 | 31.6 |
| Хот | 51 | 5047 | 3278 | 1769 | - | - |
| 5-9 | 0 | 560 | 328 | 231 | 12.5 | 21.4 |
| 10-14 | 51 | 1850 | 1250 | 600 | 20.2 | 20.4 |
| 15-17 | 0 | 2638 | 1700 | 938 | 28.1 | 28.3 |
| Хөдөө | 1969 | 54610 | 33103 | 21507 | - | - |
| 5-9 | 687 | 13954 | 8256 | 5698 | 16.2 | 13.1 |
| 10-14 | 731 | 16660 | 10558 | 6102 | 28.9 | 23.1 |
| 15-17 | 552 | 23996 | 14289 | 9707 | 40.7 | 32.0 |

*Хүснэгт 6.4 а.* ***Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүүхэд, насны бүлэг, хот, хөдөө, долоо хоногт ажилласан дундаж цаг, хүйсээр, хувиар***

| Насны бүлэг/хүйс | Тухайн үед өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүн (Дүнд эзлэх хувь насны бүлгээр) | | | | Тухайн үед өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүн (Дүнд эзлэх хувь хүйсээр) | |
|---|---|---|---|---|---|---|
| | Сүүлийн 7 хоногт ажиллаагүй | Сүүлийн 7 хоногт ажилласан | | | | |
| | | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Эрэгтэй | Эмэгтэй |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) |
| Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон нийт хүн | | | | | 42.1 | 57.9 |
| Нийт хүүхэд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 61.0 | 39.0 |
| үүнээс : 5-9 | 34.0 | 24.4 | 23.6 | 25.5 | 59.1 | 40.9 |
| 10-14 | 38.7 | 31.0 | 32.5 | 28.8 | 63.8 | 36.2 |
| 15-17 | 27.3 | 44.6 | 43.9 | 45.7 | 60.0 | 40.0 |
| Хот | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 65.0 | 35.0 |
| 5-9 | 0.0 | 11.1 | 10.0 | 13.1 | 58.7 | 41.3 |
| 10-14 | 100.0 | 36.6 | 38.1 | 33.9 | 67.6 | 32.4 |
| 15-17 | 0.0 | 52.3 | 51.9 | 53.0 | 64.5 | 35.5 |
| Хөдөө | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 60.6 | 39.4 |
| 5-9 | 34.9 | 25.6 | 24.9 | 26.5 | 59.2 | 40.8 |
| 10-14 | 37.1 | 30.5 | 31.9 | 28.4 | 63.4 | 36.6 |
| 15-17 | 28.0 | 43.9 | 43.2 | 45.1 | 59.5 | 40.5 |

*Хүснэгт 6.4*-т тухайн үед өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүүхдийн тоог насны бүлэг, хүйс, хот, хөдөөгөөр болон долоо хоногт ажилласан цагаар, *Хүснэгт 6.4а*-д эдгээр хүүхдүүдийн дунд эзлэх хувийг насны бүлэг, хүйсээр тус тус тооцов. Эндээс харахад хот, суурин газартай харьцуулахад бүх насны бүлэгт хөдөө орон нутагт хүүхдүүд илүү их цаг зарцуулжээ. Зөвхөн 5-9 насны охидын хувьд л зарцуулсан цаг ойролцоо байна. Гэхдээ энэ насны бүлгээс цөөхөн хүүхэд түүвэрлэн сонгогдсон тул энэ тоо эргэлзээтэй байж болох юм. Хот, суурин газарт өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон 5-9 насны хүүхдийн эзлэх хувь (11.1 хувь) хөдөөгийнхөөс (25.6 хувь) доогуур байхад 15-17 насны бүлэгт хот, суурин газарт өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон хүүхдийн эзлэх хувь (52.3 хувь) хөдөө орон нутгаас (43.9 хувь) өндөр байна. Энэ нь хот, суурин газарт бага сургуульд хамрагдалтын түвшин өндөр болон ажлын орон тоо харьцангуй хүртээмжтэй байдагтай зарим талаар холбоотой. Түүнчлэн Хүснэгт 6.4а-гаас харахад өрхийн бизнест цалин хөлсгүй оролцсон эрэгтэй, эмэгтэй хүүхдийн эзлэх хувь хот хөдөөд ойролцоо 60.0 хувь нь хөвгүүд, 40.0 хувь нь охид байна.

5-17 насны ажил эрхэлсэн хүүхдийн тоог үндсэн ажлаараа ажилласан хугацаа, насны бүлэг, хүйсээр *Хүснэгт 6.5-д,* харин 6.5а-д энэ үзүүлэлтийг хувиар гаргаж харуулав. Зарим хүүхэд харьцангуй бага наснаас эхлэн эдийн засгийн үйл ажиллагаанд оролцсон байна. Тухайлбал, 5-9 насны 15320 хүүхдийн бараг гуравны нэг нь (31.2 хувь) 2-3 жил ажилласан байна. Түүнчлэн 15-17 насны хүүхдийн 6.9 хувь нь арваас дээш жил ажиллажээ. Хүйсээр онцын ялгаа ажиглагдсангүй.

*Хүснэгт 6.5.* ***5-17 насны хүүхдүүдийн үндсэн ажлаараа ажилласан хугацаа, насны бүлэг, хүйсээр***

| Насны бүлэг/ хүйс | Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн | Ажилласан хугацаагаар | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1 жил хүртэл | 2-3 жил | 3-4 жил | 5-9 жил | 10 + жил |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) |
| Нийт ажил эрхэлсэн хүний тоо | 899282 | 87445 | 92348 | 143208 | 196995 | 379286 |
| Ажил эрхэлсэн хүүхдийн тоо | 68580 | 23553 | 18470 | 17193 | 7161 | 2203 |
| Үүнээс: 5-9 | 15320 | 9986 | 4782 | 551 | 0 | 0 |
| 10-14 | 21407 | 7051 | 6090 | 7247 | 1019 | 0 |
| 15-17 | 31854 | 6516 | 7597 | 9395 | 6143 | 2203 |
| Эрэгтэй | 41874 | 13961 | 11170 | 10926 | 4617 | 1200 |
| 5-9 | 9005 | 5792 | 2950 | 263 | 0 | 0 |
| 10-14 | 13762 | 4508 | 3428 | 5041 | 785 | .0 |
| 15-17 | 19107 | 3661 | 4792 | 5623 | 3832 | 1200 |
| Эмэгтэй | 26706 | 9592 | 7300 | 6267 | 2544 | 1003 |
| 5-9 | 6315 | 4194 | 1832 | 289 | 0 | 0 |
| 10-14 | 7645 | 2543 | 2663 | 2206 | 234 | 0 |
| 15-17 | 12746 | 2855 | 2806 | 3772 | 2310 | 1003 |

*Хүснэгт 6.5а.* **5-17 насны хүүхдүүдийн үндсэн ажлаараа ажилласан хугацаа, насны бүлэг, хүйсээр, хувиар**

| Насны бүлэг/хүйс | Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн | Ажилласан хугацаагаар | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 1 жил хүртэл | 2-3 жил | 3-4 жил | 5-9 жил | 10 + жил |
| Нийт ажил эрхэлсэн хүний тоо | 100.0 | 9.7 | 10.3 | 15.9 | 21.9 | 42.2 |
| Ажил эрхэлсэн хүүхдийн тоо | 100.0 | 34.3 | 26.9 | 25.1 | 10.4 | 3.3 |
| Үүнээс: 5-9 | 100.0 | 65.2 | 31.2 | 3.6 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 100.0 | 32.9 | 28.4 | 33.9 | 4.8 | 0.0 |
| 15-17 | 100.0 | 20.5 | 23.8 | 29.5 | 19.3 | 6.9 |
| Эрэгтэй | 100.0 | 33.3 | 26.7 | 26.1 | 11.0 | 2.9 |
| 5-9 | 100.0 | 64.3 | 32.8 | 2.9 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 100.0 | 32.8 | 24.9 | 36.6 | 5.7 | 0.0 |
| 15-17 | 100.0 | 19.2 | 25.1 | 29.4 | 20.1 | 6.2 |
| Эмэгтэй | 100.0 | 35.9 | 27.3 | 23.5 | 9.5 | 3.8 |
| 5-9 | 100.0 | 66.4 | 29.0 | 4.6 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 100.0 | 33.3 | 34.8 | 28.9 | 3.0 | 0.0 |
| 15-17 | 100.0 | 22.4 | 22.0 | 29.6 | 18.1 | 7.9 |

## 6.4 Ажил эрхэлж буй хүүхдүүдийн боловсролын түвшин

5-17 насны хүүхэд цэцэрлэг, сургуульд явж, эрүүл саруул өсч бойжин, нийгэмдээ хэрэгтэй хүн болж хөгжих ёстой. Иймч учраас хүүхдийн хөдөлмөрийг судлахад боловсрол маш чухал үзүүлэлтийн нэг болдог. Олон орны туршлагаас харахад сургуульд суралцах бололцоо хомс, суралцаж хөгжих гэр орны таатай нөхцөл байхгүй зэрэг нь хүүхдийн хөдөлмөр бий болж, нэмэгдэх үндсэн хүчин зүйлийн нэг болдог ажээ.

МХХС-ны сул тал нь судалгаанд хамрагдсан өрхүүдийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг судлаагүй явдал юм. Бүлэг 2-т тэмдэглэсэнчлэн хүүхдийн хөдөлмөрийг судлахад ядуурлыг авч үзэх нь чухал байдаг. Иймд өрхийн сарын орлогын мэдээнд үндэслэн ажил эрхэлж буй хүүхдүүдийг (ажил эрхлэхийн хажуугаар сургуульд сурч буй эсвэл сураагүй) зөвхөн сургуульд сурч буй хүүхдүүдтэй харьцуулах оролдлогыг хийв. Үр дүнг нь *Хүснэгт 6.6*-д харуулсан бөгөөд хүүхдийн ажил эрхлэлтэнд хүйсийн ялгаа нэг их ажиглагдсангүй. Харин нийт ажил эрхэлж буй хүүхдүүд болон зөвхөн сургуульд суралцаж буй хүүхдүүдийн орлогын бүлгээр ангилсан дунд эзлэх хувиуд хөвгүүд, охидоор ялгасан ангилал бүрт хоорондоо ойролцоо байгаагаас харахад өрхийн орлого нь хүүхдийг нэг бол ажил эрхлэх, эсвэл зөвхөн сургуульд сурахад онцын нөлөөлөх хүчин зүйл болохгүй гэж хэлж болохоор байна. *Хүснэгт 6.6*-гаас харахад зөвхөн сургуульд сурч буй хүүхдүүдийн дийлэнх нь 7-9 болон 10-14 насны бүлгийнхэн байна. Харин түүнээс дээшхи насанд ийм хүүхдүүдийн тоо буурчээ. Өөрөөр хэлбэл хүүхдүүд бага, дунд ангид сургуульд дагнан суралцаж байгаад ахлах ангиудад сурах, ажиллах аль алиныг нь хослуулах хандлагатай байж болох юм.

*Хүснэгт 6.6.* ***Ажил эрхэлсэн болон зөвхөн сургуульд сурч буй хүүхдийн тоо, өрхийн сарын орлого, насны бүлгээр (хувиар)***

| Өрхийн сарын орлого Төг/ хүйс | Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, насны бүлгээр | | | | | Зөвхөн сургуульд сурч буй хүүхдүүдийн тоо, насны бүлгээр | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | 5-6 | 7-9 | 10-14 | 15-17 | Бүгд | 5-6 | 7-9 | 10-14 | 15-17 |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) | (10) | (11) |
| Ажил эрхэлсэн хүүхэд (тоо) | 68580 | 5809 | 9511 | 21407 | 31854 | 55647 | 545 | 19061 | 28140 | 7901 |
| (%) | 100.0 | 8.5 | 13.9 | 31.2 | 46.4 | 100.0 | 1.0 | 34.3 | 50.7 | 14.1 |
| 5001 хүртэл | 100.0 | 3.5 | 8.5 | 27.2 | 60.9 | 100.0 | 0.7 | 30.5 | 57.2 | 11.5 |
| 5001-10000 | 100.0 | 9.7 | 15.3 | 33.5 | 41.5 | 100.0 | 0.0 | 25.8 | 51.3 | 22.8 |
| 10001-20000 | 100.0 | 10.8 | 15.6 | 33.0 | 40.6 | 100.0 | 0.0 | 50.7 | 42.7 | 6.6 |
| 20001-30000 | 100.0 | 8.6 | 20.1 | 28.5 | 42.9 | 100.0 | 0.0 | 22.0 | 56.1 | 21.9 |
| 30001-40000 | 100.0 | 8.8 | 14.7 | 34.4 | 42.1 | 100.0 | 2.0 | 32.0 | 47.4 | 18.6 |
| 40001-50000 | 100.0 | 11.2 | 15.5 | 35.9 | 37.4 | 100.0 | 1.3 | 41.1 | 38.2 | 19.3 |
| 50001-100000 | 100.0 | 10.2 | 12.9 | 31.2 | 45.7 | 100.0 | 0.4 | 38.8 | 46.1 | 14.6 |
| 100000-аас дээш | 100.0 | 11.5 | 14.0 | 33.5 | 41.0 | 100.0 | 5.1 | 41.3 | 44.5 | 9.1 |
| Хөвгүүд (тоо) | 41874 | 3411 | 5594 | 13762 | 19107 | 30292 | 206 | 9819 | 15602 | 4665 |
| (%) | 100.0 | 8.1 | 13.4 | 32.9 | 45.6 | 100.0 | 0.7 | 32.5 | 51.6 | 15.3 |
| 5001 хүртэл | 100.0 | 3.9 | 8.2 | 30.8 | 57.1 | 100.0 | 0.6 | 29.2 | 58.3 | 11.9 |
| 5001-10000 | 100.0 | 9.0 | 17.5 | 31.3 | 42.3 | 100.0 | 0.0 | 16.2 | 73.2 | 10.6 |
| 10001-20000 | 100.0 | 11.2 | 15.8 | 40.2 | 32.8 | 100.0 | 0.0 | 52.6 | 37.3 | 10.2 |
| 20001-30000 | 100.0 | 6.7 | 22.2 | 26.8 | 44.5 | 100.0 | 0.0 | 13.5 | 63.6 | 22.9 |
| 30001-40000 | 100.0 | 11.1 | 13.2 | 26.7 | 49.0 | 100.0 | 0.0 | 29.8 | 55.3 | 15.0 |
| 40001-50000 | 100.0 | 13.0 | 11.0 | 40.3 | 35.7 | 100.0 | 2.3 | 34.1 | 38.2 | 25.4 |
| 50001-100000 | 100.0 | 8.2 | 10.5 | 35.1 | 46.3 | 100.0 | 0.0 | 39.2 | 41.8 | 18.9 |
| 100000-аас дээш | 100.0 | 7.4 | 16.4 | 37.3 | 39.0 | 100.0 | 3.2 | 47.7 | 42.4 | 6.8 |
| Охид (тоо) | 26706 | 2398 | 3917 | 7645 | 12746 | 25356 | 340 | 9242 | 12538 | 3236 |
| (%) | 100.0 | 9.0 | 14.7 | 28.6 | 47.7 | 100.0 | 1.3 | 36.4 | 49.7 | 12.6 |
| 5001 хүртэл | 100.0 | 2.8 | 8.9 | 21.3 | 67.0 | 100.0 | 0.9 | 32.2 | 55.8 | 11.1 |
| 5001-10000 | 100.0 | 10.8 | 11.8 | 37.1 | 40.3 | 100.0 | 0.0 | 36.8 | 26.3 | 36.8 |
| 10001-20000 | 100.0 | 10.2 | 15.5 | 22.0 | 52.4 | 100.0 | 0.0 | 49.1 | 47.5 | 3.4 |
| 20001-30000 | 100.0 | 11.8 | 16.8 | 31.2 | 40.3 | 100.0 | 0.0 | 31.5 | 47.8 | 20.7 |
| 30001-40000 | 100.0 | 4.5 | 17.4 | 49.0 | 29.0 | 100.0 | 4.1 | 34.4 | 39.0 | 22.4 |
| 40001-50000 | 100.0 | 8.9 | 21.1 | 30.4 | 39.6 | 100.0 | 0.0 | 50.5 | 38.2 | 11.3 |
| 50001-100000 | 100.0 | 13.2 | 16.3 | 25.6 | 45.0 | 100.0 | 0.9 | 38.4 | 51.1 | 9.7 |
| 100000-аас дээш | 100.0 | 19.7 | 9.2 | 26.1 | 45.0 | 100.0 | 7.1 | 34.7 | 46.7 | 11.5 |

Ажил эрхэлж буй хүүхдүүдийн 22.3 хувийг 5-9 насныхан, 31.2 хувийг 10-14 насныхан, 46.5 хувийг 15-17 насныхан тус тус эзэлж байгаа нь дээрх дүгнэлтийн бодитой болохыг нотолж байна (Хүснэгт 6.3в).

Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн тоо, дунд

эзлэх хувийг боловсролын түвшин, насны бүлэг, хүйсээр тооцож *Хүснэгт 6.7, Хүснэгт*



*6.7а*-д үзүүлэв. Эндээс харахад ажил эрхэлж буй хүүхдүүдийн боловсролын түвшин үе тэнгийнхнийхээсээ доогуур байна. Ажил эрхэлж буй 15-17 насны хүүхдүүдийн бараг тэн хагас нь (47.0 хувь) бага ангийн боловсролтой байна. Гэтэл энэ насны хүүхдүүд доод тал нь 4-8-р ангид сурч байх ёстой. 5-9 насны хүүхдүүдийн дөрөвний гурав (76.6 хувь) нь сургуульд сураагүй бөгөөд энэ нь зарим талаар сургуульд орох насны доод хязгаар 7 нас байгаатай холбоотой юм. Хүйсийн хувьд онцын ялгаа ажиглагдахгүй байгаа бөгөөд харин 15-17 насны ажил эрхэлж буй охидын 5.8 хувь нь, хөвгүүдийн 1.4 хувь нь 9-10-р ангид сурч байгаа аж.

*Хүснэгт 6.7.* ***Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн тоо, боловсролын түвшин, насны бүлэг, хүйсээр***

| Насны бүлэг/ хүйс | Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн | Сургуульд огт суралцаагүй | 4-р анги төгсөөгүй | Анги | | | Техник мэргэжлийн анхан шатны |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бага | 4-8 | 9-10 | |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) |
| Ажил эрхэлсэн хүүхэд | 65729 | 16065 | 11391 | 26755 | 10456 | 970 | 92 |
| Үүнээс: 5-9 | 14633 | 11211 | 3422 | 0 | 0 | 0 | 0 |
| 10-14 | 20436 | 2152 | 5134 | 12343 | 807 | 0 | 0 |
| 15-17 | 30660 | 2701 | 2835 | 14412 | 9648 | 970 | 92 |
| Эрэгтэй | 40406 | 10148 | 7154 | 16569 | 6175 | 267 | 92 |
| 5-9 | 8662 | 6782 | 1880 | 0 | 0 | 0 | 0 |
| 10-14 | 13302 | 1497 | 3341 | 7964 | 501 | 0 | 0 |
| 15-17 | 18442 | 1869 | 1933 | 8605 | 5675 | 267 | 92 |
| Эмэгтэй | 25323 | 5917 | 4237 | 10186 | 4280 | 703 | 0 |
| 5-9 | 5971 | 4430 | 1542 | 0 | 0 | 0 | 0 |
| 10-14 | 7134 | 655 | 1794 | 4379 | 307 | 0 | 0 |
| 15-17 | 12217 | 832 | 902 | 5807 | 3974 | 703 | 0 |

Хүснэгт 6.7а. **Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, боловсролын түвшин, насны бүлэг, хүйсээр (дүнд эзлэх хувиар)**

| Насны бүлэг/ хүйс | Сүүлийн 7 хоногт ажил эрхэлсэн | Сургуульд огт суралцаагүй | 4-р ангиа төгсөөгүй | Анги | | | Техник мэргэжлийн анхан шатны |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бага | 4-8 | 9-10 | |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) |
| Ажил эрхэлсэн хүүхэд | 100.0 | 24.4 | 17.4 | 40.7 | 15.9 | 1.5 | 0.1 |
| Үүнээс : 5-9 | 100.0 | 76.6 | 23.4 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 100.0 | 10.5 | 25.1 | 60.5 | 3.9 | 0.0 | 0.0 |
| 15-17 | 100.0 | 8.8 | 9.2 | 47.0 | 31.5 | 3.2 | 0.3 |
| Эрэгтэй | 100.0 | 25.1 | 17.7 | 41.0 | 15.3 | 0.7 | 0.2 |
| 5-9 | 100.0 | 78.3 | 21.7 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 100.0 | 11.3 | 25.1 | 59.9 | 3.7 | 0.0 | 0.0 |
| 15-17 | 100.0 | 10.1 | 10.5 | 46.7 | 30.8 | 1.4 | 0.5 |
| Эмэгтэй | 100.0 | 23.4 | 16.7 | 40.2 | 16.9 | 2.8 | 0.0 |
| 5-9 | 100.0 | 74.2 | 25.8 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 100.0 | 9.2 | 25.1 | 61.4 | 4.3 | 0.0 | 0.0 |
| 15-17 | 100.0 | 6.8 | 7.4 | 47.5 | 32.5 | 5.8 | 0.0 |

## 6.5 Сургууль, боловсролоос гадуурх үйл ажиллагаанд зарцуулсан цаг

Сургууль, боловсролоос гадуурх үйл ажиллагаанд (боловсрол, урлаг соёлын ажил, тоглоом зэрэг сургууль боловсролын үйл ажиллагааны нэг хэсгийг оруулаад):

1. Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн. Үүнд:

а. Зөвхөн эдийн засгийн үйл ажиллагаа

б. Эдийн засгийн болон эдийн засгийн бус үйл ажиллагаа (гэрийн ажил)

2. Зөвхөн эдийн засгийн бус үйл ажиллагаа (гэрийн ажил) зэрэг орно.

Хүснэгт 6.8-д хүүхдүүд гэрийн ажил хийхэд долоо хоногт зарцуулж буй цагийг насны бүлэг, хүйсээр харуулав. Бүх хүүхдийн бараг тэн хагас нь (47.1 хувь) гэрийн ажил хийхэд долоо хоногт 10 хүртэлх цагийг, 16.8 хувь нь 25-аас илүү цагийг тус тус зарцуулсан байна. Энэ үзүүлэлт хүйсээр ялгаатай байгаа бөгөөд гэрийн ажил хийхэд оролцож буй охидын 21.1 хувь, хөвгүүдийн зөвхөн 12.7 хувь нь долоо хоногт 25-аас илүү цагийг зарцуулсан байна. Хүснэгт 6.8-аас харахад 5-9 насны хүүхдүүд гэрийн ажилд нэлээд туслалцаж байна. Гэхдээ ийм



хүүхүүдийн бараг 70.0 хувь нь долоо хоногт 9 хүрэхгүй цагийг гэрийн ажилд туслахад зарцуулж байна. Насны бүлэг дээшлэх тусам гэрийн ажилд туслах нь нэмэгдэж байна. Үүнд: 10-14 насны хүүхдүүдийн бараг тэн хагас нь (50.2 хувь), 15-17 насны хүүхдүүдийн бараг гуравны хоёр (63.7 хувь) нь долоо хоногт 10-41 цагийг гэрийн

ажилд туслахад зарцуулж байна. Долоо хоногт 42 гаруй цагийг гэрийн ажил хийхэд зарцуулсан охидын тоо(16704) хөвгүүдийнхээс (7771) даруй хоёр дахин их байна. Гэрийн хүнд хүчир ажлыг хийхэд оролцож буй хүүхдүүдийн дийлэнх нь 10-14, 15-17 насныхан байна.

*Хүснэгт 6.8.* ***Хүүхдүүдийн гэрийн ажил хийхэд долоо хоногт зарцуулсан цаг, насны бүлэг, хүйсээр***

| Долоо хоногт зарцуулсан цаг /хүйс | Гэрийн ажил хийхэд оролцсон хүүхэд | | Насны бүлгээр | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 5-9 | 10-14 | 15- 17 | 5-9 | 10-14 | 15- 17 |
| | Тоо | % | % | | | Тоо | | |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) |
| Нийт хүүхэд | 567414 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 144782 | 262709 | 159923 |
| 5 хүртэл | 124059 | 21.9 | 44.4 | 17.6 | 8.4 | 64250 | 46328 | 13481 |
| 5 – 9 | 142726 | 25.2 | 25.4 | 28.3 | 19.8 | 36833 | 74216 | 31677 |
| 10 – 14 | 94216 | 16.6 | 12.5 | 18.0 | 18.1 | 18117 | 47185 | 28913 |
| 15 – 24 | 110682 | 19.5 | 11.6 | 20.0 | 25.8 | 16787 | 52572 | 41323 |
| 25 – 34 | 53577 | 9.4 | 3.8 | 9.2 | 14.9 | 5443 | 24229 | 23905 |
| 35 – 41 | 17680 | 3.1 | 1.3 | 3.0 | 4.9 | 1848 | 7971 | 7860 |
| 42 – 48 | 10278 | 1.8 | 0.4 | 1.9 | 2.9 | 594 | 4989 | 4694 |
| 49 – 55 | 5584 | 1.0 | 0.3 | 0.9 | 1.8 | 431 | 2292 | 2861 |
| 56+ | 8614 | 1.5 | 0.3 | 1.1 | 3.4 | 479 | 2927 | 5208 |
| Эрэгтэй | 285465 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 72643 | 133930 | 78892 |
| 5 хүртэл | 72395 | 25.4 | 44.8 | 22.3 | 12.6 | 32512 | 29914 | 9969 |
| 5 – 9 | 78901 | 27.6 | 25.8 | 30.0 | 25.2 | 18843 | 40164 | 19895 |
| 10 – 14 | 47958 | 16.8 | 12.5 | 17.6 | 19.4 | 9071 | 23618 | 15268 |
| 15 – 24 | 50133 | 17.6 | 11.7 | 17.5 | 23.1 | 8484 | 23387 | 18261 |
| 25 – 34 | 20590 | 7.2 | 3.4 | 7.2 | 10.8 | 2461 | 9611 | 8518 |
| 35 – 41 | 7718 | 2.6 | 1.0 | 2.6 | 4.4 | 733 | 3502 | 3484 |
| 42 – 48 | 3937 | 1.4 | 0.4 | 1.5 | 2.1 | 258 | 2027 | 1652 |
| 49 – 55 | 1656 | 0.6 | 0.1 | 0.6 | 1.0 | 75 | 820 | 761 |
| 56+ | 2178 | 0.8 | 0.3 | 0.7 | 1.4 | 204 | 889 | 1085 |
| Эмэгтэй | 281949 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 72139 | 128779 | 81031 |
| 5 хүртэл | 51664 | 18.3 | 44.0 | 12.7 | 4.3 | 31738 | 16414 | 3512 |
| 5 – 9 | 63826 | 22.6 | 24.9 | 26.4 | 14.5 | 17990 | 34052 | 11783 |
| 10 – 14 | 46257 | 16.4 | 12.5 | 18.3 | 16.8 | 9046 | 23567 | 13645 |
| 15 – 24 | 60549 | 21.5 | 11.6 | 22.7 | 28.5 | 8302 | 29184 | 23062 |
| 25 – 34 | 32988 | 11.8 | 4.1 | 11.4 | 19.0 | 2982 | 14618 | 15387 |
| 35 – 41 | 9961 | 3.5 | 1.5 | 3.5 | 5.4 | 1115 | 4469 | 4377 |
| 42 – 48 | 6340 | 2.2 | 0.5 | 2.3 | 3.8 | 335 | 2963 | 3042 |
| 49 – 55 | 3928 | 1.4 | 0.5 | 1.1 | 2.6 | 355 | 1473 | 2100 |
| 56+ | 6436 | 2.3 | 0.4 | 1.6 | 5.1 | 275 | 2038 | 4123 |

*Хүснэгт 6.9*-д хүүхдүүдийн долоо хоногт эдийн засгийн үйл ажиллагаанд зарцуулсан цагийг насны бүлэг, хүйсээр нарийвчлан тооцов. ОУХБ-ын зөвлөмжийн дагуу "хүүхдийн хөдөлмөр"-ийг тооцон гаргахад энэхүү хүснэгт нь ач холбогдолтой юм[16]. Дийлэнх хүүхэд (58.9 хувь) долоо хоногт 10-41 цаг ажилласан байна. Насны бүлэг дээшлэх тусам долоо хоногт ажиллахад зарцуулсан цагийн тоо нэмэгдэж байна.

[16] *Хүүхдийн хөдөлмөрийн тооцоог Бүлэг 7-д тодорхойлсон байгаа*

*Хүснэгт 6.9.* ***Хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэхэд зарцуулсан цаг, насны бүлэг, хүйсээр***

| Долоо хоногт зарцуулсан цаг /хүйс | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхэд | | Насны бүлгээр | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 5-9 | 10-14 | 15- 17 | 5-9 | 10-14 | 15- 17 |
| | Тоо | % | % | | | Тоо | | |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) |
| Бүгд: | 65729 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 14633 | 20436 | 30660 |
| 5 хүртэл | 3924 | 6.0 | 11.8 | 6.7 | 2.7 | 1723 | 1374 | 827 |
| 5 – 9 | 6827 | 10.4 | 24.0 | 9.4 | 4.5 | 3518 | 1923 | 1387 |
| 10 – 14 | 11054 | 16.8 | 32.0 | 18.4 | 8.7 | 4671 | 3746 | 2637 |
| 15 – 24 | 13083 | 19.9 | 18.2 | 23.2 | 18.5 | 2664 | 4741 | 5678 |
| 25 – 34 | 7918 | 12.0 | 5.9 | 15.1 | 12.9 | 866 | 3086 | 3966 |
| 35 – 41 | 8628 | 13.2 | 4.6 | 12.8 | 17.4 | 668 | 2626 | 5334 |
| 42 – 48 | 1664 | 2.5 | 0.6 | 2.4 | 3.5 | 93 | 492 | 1079 |
| 49 – 55 | 2751 | 4.2 | 0.6 | 2.5 | 7.0 | 87 | 511 | 2153 |
| 56+ | 9879 | 15.0 | 2.3 | 9.5 | 24.8 | 343 | 1937 | 7599 |
| Эрэгтэй | 40406 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 8662 | 13302 | 18442 |
| 5 хүртэл | 2068 | 5.1 | 8.1 | 6.8 | 2.5 | 700 | 899 | 468 |
| 5 – 9 | 3857 | 9.5 | 26.1 | 8.7 | 2.3 | 2264 | 1160 | 433 |
| 10 – 14 | 5965 | 14.8 | 28.8 | 15.8 | 7.4 | 2495 | 2108 | 1363 |
| 15 – 24 | 7134 | 17.7 | 19.4 | 20.6 | 14.8 | 1676 | 2734 | 2724 |
| 25 – 34 | 5160 | 12.8 | 6.8 | 17.7 | 12.1 | 588 | 2348 | 2224 |
| 35 – 41 | 5746 | 14.2 | 5.6 | 12.5 | 19.4 | 495 | 1669 | 3582 |
| 42 – 48 | 1274 | 3.2 | 1.1 | 2.9 | 4.3 | 93 | 383 | 797 |
| 49 – 55 | 1878 | 4.6 | 0.6 | 2.8 | 7.9 | 51 | 375 | 1452 |
| 56+ | 7324 | 18.1 | 3.5 | 12.2 | 29.3 | 299 | 1626 | 5399 |
| Эмэгтэй | 25323 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 5971 | 7134 | 12217 |
| 5 хүртэл | 1856 | 7.3 | 17.1 | 6.7 | 2.9 | 1023 | 475 | 359 |
| 5 – 9 | 2971 | 11.7 | 21.0 | 10.7 | 7.8 | 1254 | 763 | 954 |
| 10 – 14 | 5089 | 20.1 | 36.5 | 23.0 | 10.4 | 2176 | 1639 | 1274 |
| 15 – 24 | 5948 | 23.5 | 16.6 | 28.1 | 24.2 | 988 | 2007 | 2954 |
| 25 – 34 | 2757 | 10.9 | 4.6 | 10.3 | 14.4 | 278 | 738 | 1742 |
| 35 – 41 | 2883 | 11.5 | 2.9 | 13.4 | 14.3 | 173 | 957 | 1752 |
| 42 – 48 | 390 | 1.5 | 0.0 | 1.5 | 2.3 | 0 | 109 | 281 |
| 49 – 55 | 873 | 3.4 | 0.6 | 1.9 | 5.7 | 36 | 136 | 701 |
| 56+ | 2555 | 10.1 | 0.7 | 4.4 | 18.0 | 44 | 311 | 2200 |

Ялангуяа 15-17 насны хөвгүүдийн 41.5 хувь, охидын 26.0 хувь нь долоо хоногт 42-оос олон цаг ажиллажээ. *Хүснэгт 6.8, 6.9*-өөс үзэхэд ахлах насны бүлгийн охидоор гэрийн ажил хийлгүүлж, харин хөвгүүдийг нь гадуур ажил эрхлүүлэх сонирхолтой байж болох юм.

## 6.6 Нэмэгдэл ажил хайсан хүүхдүүд

Нэмэгдэл ажил хайсан хүүхдүүдийн тоог *Хүснэгт 6.10, Хүснэгт 6.11*-д танилцуулав.

Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдээс нэмэгдэл ажил хайсан хүүхдүүдийн тоо харьцангуй цөөн тул хүснэгтүүдийн тоог ашиглахдаа болгоомжтой хандах хэрэгтэй.

*Хүснэгт 6.10.* ***Сүүлийн 7 хоногт нэмэгдэл ажил хийхэд бэлэн байсан хүүхдүүд, насны бүлэг, хот, хөдөө, хүйсээр***

| Насны бүлэг/хүйс | Ажил эрхэлж буй нийт хүүхдийн тоо | Нэмэгдэл ажил хийх боломжтой хүүхэд | | | | Боломжгүй хүүхдийн тоо | Дунд эзлэх хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | % | Хот | Хөдөө | | Хот | Хөдөө |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) |
| Бүгд: | 68580 | 2443 | 3.6 | 377 | 2067 | 66137 | 100.0 | 100.0 |
| 5-9 | 15320 | 0 | 0.0 | 0 | 0 | 15320 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 21407 | 262 | 1.2 | 75 | 188 | 21145 | 19.8 | 9.1 |
| 15-17 | 31854 | 2181 | 6.8 | 302 | 1879 | 29673 | 80.2 | 90.9 |
| Эрэгтэй | 41874 | 1509 | 3.6 | 262 | 1247 | 40365 | 100.0 | 100.0 |
| 5-9 | 9005 | 0 | 0.0 | 0 | 0 | 9005 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 13762 | 237 | 1.7 | 50 | 188 | 13524 | 19.0 | 15.0 |
| 15-17 | 19107 | 1271 | 6.7 | 212 | 1060 | 17836 | 81.0 | 85.0 |
| Эмэгтэй | 26706 | 935 | 3.5 | 115 | 820 | 25772 | 100.0 | 100.0 |
| 5-9 | 6315 | 0 | 0.0 | 0 | 0 | 6315 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 7645 | 25 | 0.3 | 25 | 0 | 7620 | 21.6 | 0.0 |
| 15-17 | 12746 | 910 | 7.1 | 90 | 820 | 11837 | 78.4 | 100.0 |

*Хүснэгт 6.10*-аас харахад хэдийгээр ажил эрхэлж буй хүүхдийн эзлэх хувь хот, суурин газарт өндөр байгаа боловч ажил хайсан хүүхдийн дийлэнх нь хөдөө орон нутгийнх байна. Ажил хайсан хүүхдүүдийн ихэнх нь 15-17 насныхан, түүнчлэн ажил хайсан хөвгүүдийн тоо охидынхоос өндөр байна.

*Хүснэгт 6 11.* ***Сүүлийн 7 хоногт нэмэгдэл ажил хайсан хүүхдийн тоо, ажил хайсан хугацаагаар***

| Ажил хайсан хугацаа | Нэмэгдэл ажил хайсан хүүхэд | | | Эзлэх хувь, ажил хайсан хугацаагаар | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) |
| Нийт хүүхэд: | 2443 | 1509 | 935 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 1 сар хүртэл | 42 | 42 | 0 | 1.7 | 2.8 | 0.0 |
| 1 – 2 сар | 157 | 114 | 42 | 6.4 | 7.6 | 4.5 |
| 3 – 6 сар | 500 | 178 | 323 | 20.5 | 11.8 | 34.5 |
| 7 – 11 сар | 336 | 179 | 157 | 13.8 | 11.9 | 16.8 |
| 1 – 2 жил | 591 | 411 | 180 | 24.2 | 27.2 | 19.3 |
| 3 + дээш жил | 817 | 584 | 233 | 33.4 | 38.7 | 24.9 |

Нийт хүүхдүүдийн гуравны нэг нь 3-аас илүү жилийн хугацаагаар, тэн хагасаас илүү хувь (57.0 хувь) нь нэг жилээс илүү хугацаагаар нэмэгдэл ажил хайжээ.

## 6.7 Хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагаа

Энэ хэсэгт хүүхдүүдийн эдийн засгийн үйл ажиллагааг байнгын болон тухайн үеийн эдийн засгийн идэвхийн байдлаар тодорхойлов. МХХС-нд тооцсоноор тухайн үед ажил эрхэлж

буй 68580 хүүхэд байна. Мөн байнгын эдийн засгийн идэвхийн аргачлалаар 48936 хүүхэд ажил эрхэлж байна.

### 6.7.1 Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар

Тухайн үед эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийг насны бүлэг, хүйсээр ангилан эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбараар тооцож *Хүснэгт 6.12*-т харуулав. Дийлэнх хүүхэд нь (91.7 хувь) хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарт ажиллаж байна. Нийт эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүдийн 1.0 хувь нь боловсруулах аж үйлдвэрт, 0.8 хувь нь уул уурхай, олборлох салбарт, 0.5 хувь нь зочид буудал, зоогийн газарт ажиллаж байна (Зураг 3, Хүснэгт 6.14а).

*Зураг 3.* ***Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, хувиар***




Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар хүйсийн ялгаа нэг их байхгүй, гагцхүү хөвгүүд уул уурхай, олборлох салбарт охидоос илүү ажиллаж, харин зочид буудал, зоогийн газарт охид илүүтэй ажиллаж байгаа дүн гарчээ. Барилгын салбарт ажиллаж байгаа хүүхдүүдийн ихэнх нь хөвгүүд байна. Насны бүлгээр харахад хөдөө аж ахуйн салбарт ажиллаж буй хүүхэд бүх насанд тодорхой хувийг (5-9 насанд 23.8 хувь, 10-14 насанд 30.7 хувь, 15-17 насанд 45.5 хувь) эзэлсэн байхад бусад салбарт ажиллаж буй хүүхдийн тоо 10-14 болон 15-17 насанд илүүтэй төвлөрчээ (мөн л ажиллаж буй хүүхдийн тоо цөөн тул энэ дүгнэлт нь яг үнэн бодитой гэж үзэж болохгүй.) *Хүснэгт 6.12*-т тухайн үеийн эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийн тоог, *Хүснэгт 6.13*-т байнгын эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийн тоог тус тус танилцуулав.

*Хүснэгт 6.12.* ***Тухайн үед эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар, насны бүлэг, хүйсээр***

| Насны бүлэг/ хүйс | Тухайн үед ажил эрхэлсэн нийт хүүхэд | Эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн салбар | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ХАА, ан агнуур, ойн аж ахуй | Уул уурхай, олборлох үйлдвэр | Боловсруулах аж үйлдвэр | Барилга | Бөөний болон жижиглэн худалдаа | Зоогийн газар, зочид буудал | Тээвэр, холбоо, харилцаа | Түрээс | Төрийн захиргаа | Нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээ | Өрхийн хувийн бизнес |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) | (10) | (11) | (12) | (13) |
| Нийт | 68580 | 62880 | 552 | 701 | 217 | 3148 | 353 | 185 | 132 | 88 | 291 | 34 |
| 5-9 | 15320 | 14972 | 42 | 33 | 0 | 272 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 10-14 | 21407 | 19324 | 265 | 135 | 53 | 1259 | 150 | 0 | 132 | 38 | 50 | 0 |
| 15-17 | 31854 | 28584 | 244 | 533 | 163 | 1616 | 203 | 185 | 0 | 50 | 241 | 34 |
| Эрэгтэй | 41874 | 38409 | 380 | 344 | 217 | 1766 | 146 | 185 | 99 | 88 | 223 | 17 |
| 5-9 | 9005 | 8811 | 42 | 33 | 0 | 118 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
*Хүснэгт 7.10.* ***Хүүхэд ажлаас болж (1) өвдөж, гэмтсэн, 2) хамгийн сүүлд авсан гэмтэл, өвчлөлийн зэрэглэл, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар***

| | Ажлын байран дээр өвдөж, гэмтсэн хүүхдүүд | | | Эдийн засгийн үйл ажиллагааны салбар | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бөөний болон жижиглэн худалдаа | | | ХАА, ан агнуур, ойн аж ахуй | | |
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) | (10) |
| Өвдөж, гэмтсэн – бүгд: | 160 | 127 | 33 | 33 | 0 | 33 | 127 | 127 | 0 |
| Хөнгөн | 42 | 42 | 0 | 0 | 0 | 0 | 42 | 42 | 0 |
| Хүнд | 118 | 85 | 33 | 33 | 0 | 33 | 85 | 85 | 0 |
| Хамгийн сүүлд авсан өвчлөл, гэмтлийн зэрэглэл: | | | | | | | | | |
| Бүгд | 160 | 127 | 33 | 33 | 0 | 33 | 127 | 127 | 0 |
| Эмчид үзүүлэх шаардлагатай болсон | 75 | 42 | 33 | 33 | 0 | 33 | 42 | 42 | 0 |
| Эмнэлэгт хэвтэж, эмчлүүлэх шаардлагатай болсон | 42 | 42 | 0 | 0 | 0 | 0 | 42 | 42 | 0 |
| Түр зуур чадваргүй болсон | 42 | 42 | 0 | 0 | 0 | 0 | 42 | 42 | 0 |

*Хүснэгт 7.10а.* ***Хүүхэд ажлаас болж (1) өвдөж, гэмтсэн, (2) хамгийн сүүлд авсан гэмтэл, өвчлөлийн зэрэглэл, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар (эзлэх хувиар)***

| Гэмтэл, өвчлөлийн зэрэглэл | Ажлын байран дээр өвдөж, гэмтсэн хүүхдүүд | | | Эдийн засгийн үйл ажиллагааны салбар | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бөөний болон жижиглэн худалдаа | | | ХАА, ан агнуур, ойн аж ахуй | | |
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) | (10) |
| Өвдөж, гэмтсэн – бүгд: | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | - | 100.0 | 100.0 | 100.0 | - |
| Хөнгөн | 26.3 | 33.3 | - | - | - | 0.0 | 33.3 | 33.3 | - |
| Хүнд | 73.7 | 66.7 | 100.0 | 100.0 | - | 100.0 | 66.7 | 66.7 | - |
| Хамгийн сүүлд авсан өвчлөл, гэмтлийн зэрэглэл: | | | | | | | | | |
| Бүгд | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | - | 100.0 | 100.0 | 100.0 | - |
| Эмчид үзүүлэх шаардлагатай болсон | 47.1 | 33.3 | 100.0 | 100.0 | - | 100.0 | 33.3 | 33.3 | - |
| Эмнэлэгт хэвтэж, эмчлүүлэх шаардлагатай болсон | 26.5 | 33.3 | 0.0 | 0.0 | - | 0.0 | 33.3 | 33.3 | - |
| Түр зуур чадваргүй болсон | 26.4 | 33.3 | 0.0 | 0.0 | - | 0.0 | 33.3 | 33.3 | - |

## 7.7 Чөлөөт цаг

Хүүхэд нийгмийн өв тэгш иргэн болж өсч, хөгжихөд чөлөөт цаг ихээхэн чухал үүрэгтэй. Ийм ч учраас 5-17 насны хүүхдүүдэд өдөрт чөлөөт цагт хир зэрэг гардаг талаар мэдээлэл цуглуулж, дүнг нь *Хүснэгт 7.11*-д танилцуулав. *Хүснэгт 7.11а*-д өдөрт чөлөөт цагт зарцуулсан хугацаар хүүхдүүдийн дунд эзлэх хувиар, *Хүснэгт 7.12*-т өрхөөс гадуур байгаа эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийг

сургуульд сурдаг, сургуульд хамрагдаагүй гэж хоёр бүлэглэн ангилал тус бүр дээр чөлөөт цагийг нь тодорхойлов. *Хүснэгт 7.12а*-д хүүхдүүдийн дунд эзлэх хувийг насны бүлгээр тооцлоо. Судалгаанд хамрагдсан 5-17 насны хүүхдүүдийн ихэнх (99.6 хувь) нь өдөрт чөлөөт



цагаа өнгөрөөхөд тодорхой хугацаа зарцуулдаг байна. Тухайлбал, ийм хүүхдийн 10.0 орчим хувь нь өдөрт 1-2 цагийг, 5.0 орчим хувь нь 11-ээс дээш цагийг зарцуулжээ. Олон хүүхэд (бараг 70.0 хувь нь) өдөрт 3-6 цаг, түүн дотроо хамгийн олон хүүхэд 3–4 цагийг чөлөөт цагаа өнгөрөөхөд зарцуулсан байна. Энэ үзүүлэлт хүйсийн хувьд нэг их ялгаатай бус, харин насны бүлгүүдээр ялгаатай харагдаж байна. Насны бүлэг дээшлэх тусам өдөрт чөлөөт цагт зарцуулах хугацаа багасч байна. Тухайлбал, 5-6 болон 7-9 насны хүүхэд голчлон 5-6 цагийг чөлөөт цагт зарцуулсан байхад 10-14, 15-17 насанд 3-4 цаг болж багасч байна. 5-6 насны нийт хүүхдүүдийн дотор өдөрт 1-2 цаг зарцуулдаг хүүхэд 4.0 хувийг, 7-8 цаг зарцуулдаг хүүхэд 21.7 хувийг тус тус эзэлж байна. Гэтэл 15-17 насанд 1-2 цаг зарцуулсан хүүхдийн дунд эзлэх хувь 18.2 хувь, 7-8 цаг зарцуулсан хүүхэд 7.0 хувьтай байна. 5-6 насны маш цөөхөн хүүхэд (82302 хүүхдийн 79 нь) чөлөөт цаг гардаггүй гэсэн байхад 15-17 насанд ийм хүүхдийн эзлэх хувь 0.9 хувь (171506 хүүхдийн 1485 нь) байгаа гэсэн сонирхолтой дүн гарав. *Хүснэгт 7.12*-т өрхөөс гадуур байгаа, эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхэд өдөрт чөлөөт цагт хэр их хугацаа зарцуулсныг тооцов. Ингэж тооцохдоо өрхөөс гадуур ажил хийсэн хүүхдүүдийг (13509) 1) сургуульд сурдаггүй (7557), 2) сургуульд сурдаг (5952) гэж хоёр ангилсан. Хүснэгтээс харахад сургуульд сурч, ажилладаг хүүхдүүд хамгийн дээд тал нь 7-8 цагийг чөлөөт цагт, харин сургуульд сурдаггүй, эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүдийн 1.5 хувь нь (7557 хүүхдийн 112 нь) ийм цагийг зарцуулж байна. Ийм хүүхдүүдийн 10.0 орчим хувь (7557 хүүхдийн 761) нь өдөрт 9 болон түүнээс дээш цагийг чөлөөт цагаа өнгөрөхөд зарцуулж байна. Сурдаггүй, зөвхөн ажилладаг хүүхдийн 6.0 орчим хувьд (7557 хүүхдийн 450 нь) чөлөөт цаг гардаггүй байхад сурч, ажиллахын аль алиныг нь хийдэг хүүхдүүдийн зөвхөн 1.0 хувь нь (5952 хүүхдийн 59) ийм хариулт өгчээ. Сургуульд сурдаггүй, зөвхөн ажил хийдэг хүүхдүүдийн дунд чөлөөт цаг гардаггүй гэж хариулсан хүүхдүүдийн ихэнх нь 15-17 насны охид байсан нь сонирхол татаж байна (450 хүүхдийн 302 нь). Ажил хийсэн хүүхдүүдийг сургуульд сурдаггүй, зөвхөн ажил хийдэг болон сурахын зэрэгцээ ажил хийдэг гэж хоёр бүлэглэн өдөрт өөртөө зарцуулсан чөлөөт цагийг нь харахад бага зэргийн ялгаа ажиглагдав. Сургуульд сурдаггүй, зөвхөн ажилладаг хүүхдүүдийн ихэнх нь өдөрт 1–2 цагийг, харин сурахын зэрэгцээ ажиллаж буй хүүхдүүдийн ихэнх нь өдөрт 3-4 цагийг чөлөөт цагаа өнгөрүүлэхэд зарцуулжээ.

*Хүснэгт 7.11.* ***Хүүхэд өдөрт чөлөөт цагт зарцуулж буй дундаж цаг, хүйс, насны бүлгээр***

| Насны бүлэг / хүйс | Нийт хүүхэд | Чөлөөт цаг байхгүй хүүхэд | Чөлөөт цагтай хүүхэд | Өдөрт чөлөөт цагт зарцуулах дундаж цаг | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1-2 | 3-4 | 5-6 | 7-8 | 9-10 | 11-12 | 13+ |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) | (10) | (11) |
| Нийт: | 676911 | 2789 | 674122 | 65533 | 248515 | 217640 | 78015 | 30018 | 12134 | 22267 |
| 5-6 | 82302 | 79 | 82223 | 3289 | 14558 | 29238 | 18051 | 10390 | 2629 | 4067 |
| 7-9 | 129139 | 252 | 128887 | 7404 | 38180 | 48321 | 19579 | 7435 | 2823 | 5146 |
| 10-14 | 293964 | 973 | 292991 | 23941 | 117629 | 100978 | 28490 | 8571 | 4044 | 9338 |
| 15-17 | 171506 | 1485 | 170021 | 30899 | 78148 | 39103 | 11895 | 3622 | 2639 | 3715 |
| Эрэгтэй: | 346867 | 1502 | 345365 | 32858 | 124246 | 112904 | 41102 | 17040 | 5822 | 11392 |
| 5-6 | 43181 | 79 | 43103 | 1780 | 6967 | 15871 | 9525 | 5733 | 1157 | 2069 |
| 7-9 | 65764 | 57 | 65706 | 3636 | 18618 | 25838 | 9582 | 3990 | 1349 | 2693 |
| 10-14 | 151656 | 712 | 150944 | 11973 | 59680 | 51493 | 15890 | 5258 | 1905 | 4746 |
| 15-17 | 86266 | 654 | 85612 | 15469 | 38981 | 19702 | 6105 | 2060 | 1411 | 1884 |
| Эмэгтэй: | 330045 | 1288 | 328757 | 32675 | 124269 | 104736 | 36913 | 12977 | 6312 | 10875 |
| 5-6 | 39120 | 0 | 39120 | 1509 | 7591 | 13367 | 8526 | 4658 | 1471 | 1999 |
| 7-9 | 63376 | 195 | 63181 | 3768 | 19562 | 22482 | 9996 | 3445 | 1474 | 2454 |
| 10-14 | 142309 | 262 | 142047 | 11968 | 57949 | 49485 | 12601 | 3313 | 2138 | 4592 |
| 15-17 | 85240 | 831 | 84409 | 15430 | 39167 | 19401 | 5790 | 1562 | 1228 | 1831 |

*Хүснэгт 7.11а.* ***Хүүхэд өдөрт чөлөөт цагт зарцуулж буй дундаж цаг, хүйс, насны бүлгээр (эзлэх хувь )***

| Насны бүлэг / хүйс | Нийт хүүхэд | | Чөлөөт цаг байхгүй хүүхэд | Чөлөөт цагтай хүүхэд | Өдөрт чөлөөт цагт зарцуулах дундаж цаг. | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | Хувь | | | 1-2 | 3-4 | 5-6 | 7-8 | 9-10 | 11-12 | 13+ |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) | (10) | (11) | (12) |
| Нийт: | 676911 | 100.0 | 0.4 | 99.6 | 9.7 | 36.9 | 32.3 | 11.6 | 4.5 | 1.8 | 3.3 |
| 5-6 | 82302 | 100.0 | 0.1 | 99.9 | 4.0 | 17.7 | 35.6 | 22.0 | 12.6 | 3.2 | 4.9 |
| 7-9 | 129139 | 100.0 | 0.2 | 99.8 | 5.7 | 29.6 | 37.5 | 15.2 | 5.8 | 2.2 | 4.0 |
| 10-14 | 293964 | 100.0 | 0.3 | 99.7 | 8.2 | 40.1 | 34.5 | 9.7 | 2.9 | 1.4 | 3.2 |
| 15-17 | 171506 | 100.0 | 0.9 | 99.1 | 18.2 | 46.0 | 23.0 | 7.0 | 2.1 | 1.6 | 2.2 |
| Эрэгтэй: | 346867 | 100.0 | 0.4 | 99.6 | 9.5 | 36.0 | 32.7 | 11.9 | 4.9 | 1.7 | 3.3 |
| 5-6 | 43181 | 100.0 | 0.2 | 99.8 | 4.1 | 16.2 | 36.8 | 22.1 | 13.3 | 2.7 | 4.8 |
| 7-9 | 65764 | 100.0 | 0.1 | 99.9 | 5.5 | 28.3 | 39.3 | 14.6 | 6.1 | 2.1 | 4.1 |
| 10-14 | 151656 | 100.0 | 0.5 | 99.5 | 7.9 | 39.5 | 34.1 | 10.5 | 3.5 | 1.3 | 3.1 |
| 15-17 | 86266 | 100.0 | 0.8 | 99.2 | 18.1 | 45.5 | 23.0 | 7.1 | 2.4 | 1.6 | 2.2 |
| Эмэгтэй: | 330045 | 100.0 | 0.4 | 99.6 | 9.9 | 37.8 | 31.9 | 11.2 | 3.9 | 1.9 | 3.3 |
| 5-6 | 39120 | 100.0 | 0.0 | 100.0 | 3.9 | 19.4 | 34.2 | 21.8 | 11.9 | 3.8 | 5.1 |
| 7-9 | 63376 | 100.0 | 0.3 | 99.7 | 6.0 | 31.0 | 35.6 | 15.8 | 5.5 | 2.3 | 3.9 |
| 10-14 | 142309 | 100.0 | 0.2 | 99.8 | 8.4 | 40.8 | 34.8 | 8.9 | 2.3 | 1.5 | 3.2 |
| 15-17 | 85240 | 100.0 | 1.0 | 99.0 | 18.3 | 46.4 | 23.0 | 6.9 | 1.9 | 1.5 | 2.2 |

*Хүснэгт 7.12.* ***Өрхөөс гадуур байгаа эдийн засгийн үйл ажиллага эрхэлсэн суралцаж буй болон сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн тоо, өдөрт зарцуулдаг чөлөөт цагаар, насны бүлэг, хүйсээр***

| Насны бүлэг / хүйс | Нийт | Чөлөөт цаггүй хүүхэд | Чөлөөт цагтай хүүхэд | Өдөрт чөлөөт цагт зарцуулах дундаж цаг: | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | 1-2 | 3-4 | 5-6 | 7-8 | 9-10 | 11-12 | 13+ |
| Сургуульд сурдаггүй хүүхдүүд: | | | | | | | | | | |
| Нийт: | 7557 | 450 | 7108 | 3475 | 2180 | 580 | 112 | 592 | 127 | 42 |
| 5-6 | 17 | 0 | 17 | 0 | 0 | 17 | 0 | 0 | 0 | 0 |
| 7-9 | 275 | 0 | 275 | 0 | 117 | 158 | 0 | 0 | 0 | 0 |
| 10-14 | 1435 | 65 | 1370 | 492 | 555 | 117 | 36 | 127 | 42 | 0 |
| 15-17 | 5830 | 384 | 5446 | 2982 | 1508 | 288 | 75 | 465 | 85 | 42 |
| Эрэгтэй: | 4994 | 148 | 4847 | 2196 | 1415 | 481 | 79 | 508 | 127 | 42 |
| 5-6 | 17 | 0 | 17 | 0 | 0 | 17 | 0 | 0 | 0 | 0 |
| 7-9 | 233 | 0 | 233 | 0 | 74 | 158 | 0 | 0 | 0 | 0 |
| 10-14 | 1148 | 65 | 1082 | 399 | 461 | 17 | 36 | 127 | 42 | 0 |
| 15-17 | 3597 | 82 | 3515 | 1797 | 880 | 288 | 42 | 381 | 85 | 42 |
| Эмэгтэй: | 2563 | 302 | 2261 | 1279 | 765 | 100 | 33 | 85 | 0 | 0 |
| 7-9 | 42 | 0 | 42 | 0 | 42 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 10-14 | 288 | 0 | 288 | 93 | 95 | 100 | 0 | 0 | 0 | 0 |
| 15-17 | 2233 | 302 | 1931 | 1185 | 628 | 0 | 33 | 85 | 0 | 0 |
| Сургуульд сурдаг хүүхдүүд: | | | | | | | | | | |
| Нийт: | 5952 | 59 | 5893 | 963 | 3374 | 1179 | 377 | | | |
| 7-9 | 17 | 0 | 17 | 17 | 0 | 0 | 0 | | | |
| 10-14 | 2907 | 59 | 2848 | 435 | 1629 | 457 | 327 | | | |
| 15-17 | 3028 | 0 | 3028 | 510 | 1745 | 723 | 50 | | | |
| Эрэгтэй: | 3976 | 59 | 3918 | 582 | 2332 | 745 | 259 | | | |
| 7-9 | 17 | 0 | 17 | 17 | 0 | 0 | 0 | | | |
| 10-14 | 1974 | 59 | 1916 | 289 | 1160 | 257 | 209 | | | |
| 15-17 | 1985 | 0 | 1985 | 276 | 1171 | 487 | 50 | | | |
| Эмэгтэй: | 1976 | 0 | 1976 | 381 | 1042 | 434 | 118 | | | |
| 10-14 | 933 | 0 | 933 | 147 | 469 | 199 | 118 | | | |
| 15-17 | 1043 | 0 | 1043 | 234 | 573 | 235 | 0 | | | |

*Хүснэгт 7.12а.* ***Өрхөөс гадуур байгаа эдийн засгийн үйл ажиллага эрхэлсэн суралцаж буй болон сургуульд хамрагдаагүй хүүхдүүдийн тоо, өдөрт зарцуулдаг чөлөөт цагтаар, насны бүлэг, хүйсээр (хувиар)***

| Насны бүлэг / хүйс | Нийт хүүхэд | | Чөлөөт цагтай хүүхэд | Чөлөөт цаггүй хүүхэд | Өдөрт чөлөөт цагт зарцуулах дундаж цаг | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | хувь | | | 1-2 | 3-4 | 5-6 | 7-8 | 9-10 | 11-12 | 13+ |
| **Сургуульд сурдаггүй хүүхдүүд:** | | | | | | | | | | | |
| Бүгд: | 7557 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 5-6 | 17 | 0.2 | 0.0 | 0.2 | 0.0 | 0.0 | 3.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 7-9 | 275 | 3.6 | 0.0 | 3.9 | 0.0 | 5.4 | 27.3 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 1435 | 19.0 | 14.5 | 19.3 | 14.2 | 25.5 | 20.1 | 32.4 | 21.4 | 33.3 | 0.0 |
| 15-17 | 5830 | 77.1 | 85.5 | 76.6 | 85.8 | 69.2 | 49.6 | 67.6 | 78.6 | 66.7 | 100.0 |
| Эрэгтэй: | 4994 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| 5-6 | 17 | 0.3 | 0.0 | 0.4 | 0.0 | 0.0 | 3.6 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 7-9 | 233 | 4.7 | 0.0 | 4.8 | 0.0 | 5.3 | 32.9 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 10-14 | 1148 | 23.0 | 44.3 | 22.3 | 18.2 | 32.6 | 3.6 | 46.1 | 25.0 | 33.3 | 0.0 |
| 15-17 | 3597 | 72.0 | 55.7 | 72.5 | 81.8 | 62.2 | 59.9 | 53.9 | 75.0 | 66.7 | 100.0 |
| Эмэгтэй: | 2563 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | - | - |
| 7-9 | 42 | 1.7 | 0.0 | 1.9 | 0.0 | 5.5 | 0.0 | 0.0 | 0.0 | - | - |
| 10-14 | 288 | 11.2 | 0.0 | 12.7 | 7.3 | 12.4 | 100.0 | 0.0 | 0.0 | - | - |
| 15-17 | 2233 | 87.1 | 100.0 | 85.4 | 92.7 | 82.1 | 0.0 | 100.0 | 100.0 | - | - |
| **Сургуульд сурдаг хүүхдүүд:** | | | | | | | | | | | |
| Бүгд: | 5952 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | - | - | |
| 7-9 | 17 | 0.3 | 0.0 | 0.3 | 1.8 | 0.0 | 0.0 | 0.0 | - - | - | |
| 10-14 | 2907 | 48.8 | 100.0 | 48.3 | 45.2 | 48.3 | 38.7 | 86.7 | - - | - | |
| 15-17 | 3028 | 50.9 | 0.0 | 51.4 | 53.0 | 51.7 | 61.3 | 13.3 | - - | - | |
| Эрэгтэй: | 3976 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | - - | - | |
| 7-9 | 17 | 0.4 | 0.0 | 0.4 | 3.0 | 0.0 | 0.0 | 0.0 | - - | - | |
| 10-14 | 1974 | 49.6 | 100.0 | 48.9 | 49.6 | 49.8 | 34.6 | 80.7 | - - | - | |
| 15-17 | 1985 | 49.9 | 0.0 | 50.7 | 47.5 | 50.2 | 65.4 | 19.3 | - - | - | |
| Эмэгтэй: | 1976 | 100.0 | - | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | - - | - | |
| 10-14 | 933 | 47.2 | - | 47.2 | 38.5 | 45.0 | 45.8 | 100.0 | - - | - | |
| 15-17 | 1043 | 52.8 | - | 52.8 | 61.5 | 55.0 | 54.2 | 0.0 | - - | - | |

Бүлэг 8

# ХҮҮХДИЙН АЖИЛ ЭРХЛЭЛТ, УЛИРАЛ БОЛОН БҮС НУТГААР

## 8.1 Удиртгал

2002-2003 оны АХС+МХХС-г 2002 оны 10-р сараас 2003 оны 9-р сарыг дуусталх хугацаанд нийт 12 сарыг хамруулан 4 улирлаар явуулсан билээ. Судалгааны тоо мэдээг Улаанбаатар хот, 4 бүс нутгаар, хот, хөдөөгөөр цуглуулсан. Иймд энэ бүлэгт хүүхдийн ажил эрхлэлтийг бүс нутаг, улирлын хэлбэлзлээр тооцов.[22] Түүврийн хэмжээ харьцангуй бага тул зарим бүс нутаг, ялангуяа Улаанбаатар хот, Зүүн бүс нутагтай холбоотой тоо мэдээг ашиглахдаа болгоомжтой хандах хэрэгтэй.

## 8.2 Хүүхдийн ажил эрхлэлт, бүс нутгаар

*Хүснэгт 8.1*-д тухайн үед эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийн тоог бүс нутгаар тооцон, хүйс, насны бүлгээр харуулав. Түүнчлэн судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн тоог бүс нутгаар тооцон, хүйс, насны бүлгээр харууллаа.

### 8.2.1 Хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин, бүс нутгаар

*Хүснэгт 8.2*-т хүүхдийн ажил эрхлэлтийг бүс нутгаар тооцон, хүйс, насны бүлгээр харуулав. Баруун бүсийн нутагт энэ үзүүлэлт хамгийн өндөр буюу 18.6 хувь, түүний дараагаар Хангайн бүсэд 15.3 хувьтай байна. Хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин Улаанбаатарт хамгийн доогуур буюу 1.0 хувь хүрэхгүй байна. Харин Зүүн болон Төвийн бүсийн нутагт тус бүр 7.2-7.8 хувьтай байна. Насны бүлгээр авч үзэхэд бүс нутгууд дахь хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин нийт ажил эрхэлж буй хүүхдүүдийн хандлагыг давтаж байна. Тухайлбал, бүх насны бүлэгт ажил эрхлэлтийн түвшин Баруун бүсэд хамгийн өндөр, дараа нь Хангайн бүс орж байхад Улаанбаатар хотод энэ үзүүлэлт хамгийн доогуур байна (*Хүснэгт 8.2*).

Насны бүлэг дээшлэх тусам ажил эрхлэлтийн түвшин нэмэгдэж байгаа нь бүх бүс нутагт



ажиглагдаж байна. Гагцхүү Төв, Баруун бүсэд 5-9 насны хүүхдүүдийнхтэй харьцуулахад энэ үзүүлэлт 10-14 насны бүлэгт буурч гарчээ. Хүүхдийн ажил эрхлэлтийн түвшинг насны бүлгээр авч үзэхэд бүх бүс нутагт 15-17 насны хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин үлэмж өндөр байна. Хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин хамгийн өндөр Баруун, Хангай бүсэд энэ үзүүлэлт 15-17 насанд 30 гаруй хувьтай байна. Баруун бүсэд 5-9 насны хүүхдийн хувьд ажил эрхлэлтийн түвшин 16.4 хувь, 10-14 насанд 13.8 хувь байна. Хүйсээр харахад эрэгтэй, эмэгтэй хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин бүс нутаг, насны бүлгээр нийт хүүхдийнхтэй адилхан байна. Гэхдээ бүх насны бүлэг болон бүх бүс нутгаар харахад эрэгтэй хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин эмэгтэй хүүхдийнхээс өндөр байна. *Хүснэгт 8.2*-т ялангуяа 15-17 насны бүлэгт ажил эрхлэлтийн түвшин хүйсээр нэлээд ялгаатай байна.

[22] *Түүврийн аргатай холбоотойгоор хэлбэлзлийг аймгуудаар гаргах боломжгүй байв (үг нь бодлого боловсруулалтанд илүү их хэрэгтэй байх байв).*

*Хүснэгт 8.1.* ***Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, бүс нутаг, насны бүлэг, хүйсээр***

| Насны бүлэг/хүйс | | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн тоо, бүс нутгаар | | | | | | Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо, бүс нутгаар | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нийт | Улаанбаатар | Зүүн | Төв | Баруун | Хангай | Нийт | Улаанбаатар | Зүүн | Төв | Баруун | Хангай |
| (1) | | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) | (10) | (11) | (12) | (13) |
| Бүгд | | 68580 | 1533 | 3904 | 9858 | 27053 | 26231 | 679050 | 176535 | 50182 | 136149 | 145201 | 170983 |
| үүнээс: | 5-9 | 15320 | 69 | 440 | 2096 | 8584 | 4130 | 212145 | 47597 | 17006 | 39252 | 52450 | 55839 |
| | 10-14 | 21407 | 458 | 1149 | 2703 | 8067 | 9030 | 294841 | 82405 | 20547 | 61061 | 58623 | 72206 |
| | 15-17 | 31854 | 1006 | 2315 | 5058 | 10403 | 13072 | 172063 | 46532 | 12628 | 35837 | 34127 | 42938 |
| Эрэгтэй | | 41874 | 935 | 2505 | 6231 | 16223 | 15979 | 347653 | 90644 | 26453 | 70154 | 73886 | 86515 |
| үүнээс: | 5-9 | 9005 | 0 | 246 | 1127 | 5070 | 2562 | 109205 | 24933 | 8664 | 20795 | 26603 | 28210 |
| | 10-14 | 13762 | 308 | 753 | 1822 | 5061 | 5817 | 151999 | 42971 | 11059 | 31391 | 29579 | 36999 |
| | 15-17 | 19107 | 627 | 1507 | 3282 | 6093 | 7600 | 86449 | 22740 | 6730 | 17968 | 17704 | 21306 |
| Эмэгтэй | | 26706 | 598 | 1399 | 3626 | 10830 | 10253 | 331397 | 85891 | 23729 | 65995 | 71315 | 84468 |
| үүнээс: | 5-9 | 6315 | 69 | 195 | 969 | 3514 | 1568 | 102940 | 22665 | 8343 | 18456 | 25848 | 27629 |
| | 10-14 | 7645 | 150 | 396 | 881 | 3006 | 3213 | 142843 | 39433 | 9488 | 29670 | 29044 | 35207 |
| | 15-17 | 12746 | 379 | 809 | 1777 | 4310 | 5472 | 85614 | 23793 | 5898 | 17869 | 16423 | 21632 |

*Хүснэгт 8.2.* ***5-17 насны нийт хүүхдэд ажил эрхэлж буй хүүхдийн эзлэх хувь, бүс нутгаар***

| Насны бүлэг/ хүйс | Нийт | Улаанбаатар | Зүүн | Төв | Баруун | Хангай |
|---|---|---|---|---|---|---|
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) |
| Бүгд | 10.1 | 0.9 | 7.8 | 7.2 | 18.6 | 15.3 |
| үүнээс: 5-9 | 7.2 | 0.1 | 2.6 | 5.3 | 16.4 | 7.4 |
| 10-14 | 7.3 | 0.6 | 5.6 | 4.4 | 13.8 | 12.5 |
| 15-17 | 18.5 | 2.2 | 18.3 | 14.1 | 30.5 | 30.4 |
| Эрэгтэй | 12.0 | 1.0 | 9.5 | 8.9 | 22.0 | 18.5 |
| үүнээс: 5-9 | 8.2 | 0.0 | 2.8 | 5.4 | 19.1 | 9.1 |
| 10-14 | 9.1 | 0.7 | 6.8 | 5.8 | 17.1 | 15.7 |
| 15-17 | 22.1 | 2.8 | 22.4 | 18.3 | 34.4 | 35.7 |
| Эмэгтэй | 8.1 | 0.7 | 5.9 | 5.5 | 15.2 | 12.1 |
| үүнээс: 5-9 | 6.1 | 0.3 | 2.3 | 5.2 | 13.6 | 5.7 |
| 10-14 | 5.4 | 0.4 | 4.2 | 3.0 | 10.3 | 9.1 |
| 15-17 | 14.9 | 1.6 | 13.7 | 9.9 | 26.2 | 25.3 |

### 8.2.2 Ажил эрхэлж буй хүүхдүүдийн тоо, бүс нутгаар

*Хүснэгт 8.3*-д ажил эрхэлж буй нийт хүүхдийн дүнд эзлэх хувийг бүс нутгаар тооцож гаргав. Баруун бүсийн нутаг ажил эрхэлж буй нийт хүүхэд болон эрэгтэй, эмэгтэй хүүхдийн тоогоор хамгийн өндөр, хоёрдугаарт нь Хангайн бүс, гуравдугаарт нь Төвийн бүс орж байна. Харин Улаанбаатарт ажил эрхэлж буй хүүхдийн тоо хамгийн цөөн байна (Зураг 7).

*Зураг 7.* ***Ажил эрхэлж буй хүүхдүүдийн тоо, хүйс, бүс нутгаар***




Ажил эрхэлж буй хүүхдийг насны бүлэг, хүйсээр харахад адил дүр зураг ажиглагдаж байгаа бөгөөд харин ажил эрхэлж буй 5-9 насны хүүхдийн тоо Баруун бүсийн нутагт Хангайн бүсийнхээс даруй хоёр дахин олон байна. Бусад насны бүлэгт ийм зөрүү Хангай болон Баруун бүсийн хооронд нэг их биш байна.

*Хүснэгт 8.3.* ***Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн бүс нутгууд дахь байршил, насны бүлэг, хүйсээр*** *(хувиар)*

| Насны бүлэг/хүйс | Бүгд | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, бүс нутгаар | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Улаанбаатар | Зүүн | Төв | Баруун | Хангай |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) |
| Бүгд | 100.0 | 2.2 | 5.7 | 14.4 | 39.4 | 38.2 |
| үүнээс: 5-9 | 100.0 | 0.5 | 2.9 | 13.7 | 56.0 | 27.0 |
| 10-14 | 100.0 | 2.1 | 5.4 | 12.6 | 37.7 | 42.2 |
| 15-17 | 100.0 | 3.2 | 7.3 | 15.9 | 32.7 | 41.0 |
| Эрэгтэй | 100.0 | 2.2 | 6.0 | 14.9 | 38.7 | 38.2 |
| үүнээс: 5-9 | 100.0 | 0.0 | 2.7 | 12.5 | 56.3 | 28.4 |
| 10-14 | 100.0 | 2.2 | 5.5 | 13.2 | 36.8 | 42.3 |
| 15-17 | 100.0 | 3.3 | 7.9 | 17.2 | 31.9 | 39.8 |
| Эмэгтэй | 100.0 | 2.2 | 5.2 | 13.6 | 40.6 | 38.4 |
| үүнээс: 5-9 | 100.0 | 1.1 | 3.1 | 15.3 | 55.7 | 24.8 |
| 10-14 | 100.0 | 2.0 | 5.2 | 11.5 | 39.3 | 42.0 |
| 15-17 | 100.0 | 3.0 | 6.3 | 13.9 | 33.8 | 42.9 |

*Хүснэгт 8.3а*-аас харахад Улаанбаатар хот болон зүүн бүсийн нутагт (хүүхдийн тоо хамгийн цөөн газрууд) ажил эрхэлж буй хүүхдүүд голдуу 10-14 болон 15-17 насны бүлгийнхэн байна. Ажил эрхэлж байгаа хүүхэд хамгийн олон байгаа Баруун бүсийн нутагт энэ тооны зөрүү насны бүлгээр маш бага байгаа юм. Эндээс харахад 5-9 насны олон хүүхэд эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа тул эдгээр хүүхдийг ажиллах хүчний бүлэглэлээс гаргах бодлого барих нь хүүхдийн хөдөлмөрийг бууруулахад том алхам болох юм.

*Хүснэгт 8.3а.* ***Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн бүс нутгууд дахь байршил, насны бүлэг, хүйсээр (хувиар)***

| Насны бүлэг/ хүйс | Бүгд | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, бүс нутгаар | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Улаанбаатар | Зүүн | Төв | Баруун | Хангай |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) |
| Нийт хүүхэд - | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| үүнээс: 5-9 | 22.3 | 4.5 | 11.3 | 21.3 | 31.7 | 15.7 |
| 10-14 | 31.2 | 29.9 | 29.4 | 27.4 | 29.8 | 34.4 |
| 15-17 | 46.4 | 65.6 | 59.3 | 51.3 | 38.5 | 49.8 |
| Нийт эрэгтэй хүүхэд- | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| үүнээс: 5-9 | 21.5 | 0.0 | 9.8 | 18.1 | 31.3 | 16.0 |
| 10-14 | 32.9 | 33.0 | 30.0 | 29.2 | 31.2 | 36.4 |
| 15-17 | 45.6 | 67.0 | 60.1 | 52.7 | 37.6 | 47.6 |
| Нийт эмэгтэй хүүхэд - | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| үүнээс: 5-9 | 23.6 | 11.6 | 13.9 | 26.7 | 32.5 | 15.3 |
| 10-14 | 28.6 | 25.1 | 28.3 | 24.3 | 27.8 | 31.3 |
| 15-17 | 47.7 | 63.3 | 57.8 | 49.0 | 39.8 | 53.4 |

## 8.3 Хүүхдийн ажил эрхлэлт, улирлаар

*Хүснэгт 8.4, Хүснэгт 8.4а-* д тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн тоо болон дүнд эзлэх хувийг 4 улирлыг хамруулан насны бүлгээр тооцож харуулав. Өөрөөр хэлбэл эхний улирал 2002 оны 10-12-р сар, сүүлчийн улирал 2003 оны 7-9-р сарыг хамарсан нийт 4 улирлын хэлбэлзлээр хүүхдийн ажил эрхлэлтийг тооцсон болно. Хүүхдийн ажил эрхлэлт улирлаар нэлээд хэлбэлзэж байгаа бөгөөд эхний улиралд хамгийн цөөн хүүхэд, дараачийн улирлуудад аажим аажмаар өсөх хандлагатай байна (Зураг 8).



*Хүснэгт 8.4.* **Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, насны бүлэг, хүйс, улирлаар**

| Насны бүлэг/ хүйс | Судалгааны хугацаанд | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, улирлаар | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1- улирал | 2- улирал | 3- улирал | 4-р улирал |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) |
| Нийт хүүхэд - | 68580 | 41403 | 58097 | 85753 | 91946 |
| үүнээс: 5-9 | 15320 | 4912 | 14126 | 22232 | 20697 |
| 10-14 | 21407 | 10696 | 15422 | 28992 | 31932 |
| 15-17 | 31854 | 25795 | 28549 | 34529 | 39317 |
| Эрэгтэй | 41874 | 27086 | 35623 | 53597 | 52436 |
| үүнээс: 5-9 | 9005 | 2923 | 7971 | 13443 | 12150 |
| 10-14 | 13762 | 7571 | 9995 | 19087 | 19103 |
| 15-17 | 19107 | 16592 | 17657 | 21066 | 21183 |
| Эмэгтэй | 26706 | 14318 | 22474 | 32156 | 39509 |
| үүнээс: 5-9 | 6315 | 1989 | 6155 | 8788 | 8547 |
| 10-14 | 7645 | 3126 | 5427 | 9904 | 12829 |
| 15-17 | 12746 | 9203 | 10892 | 13464 | 18133 |

*Хүснэгт 8.4а.* **Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, насны бүлэг, хүйс, улирлаар (хувиар)**

| Насны бүлэг/ хүйс | Судалгааны хугацаанд | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, улирлаар | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1- улирал | 2- улирал | 3- улирал | 4- улирал |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) |
| Нийт хүүхэд - | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| үүнээс: 5-9 | 22.3 | 11.9 | 24.3 | 25.9 | 22.5 |
| 10-14 | 31.2 | 25.8 | 26.5 | 33.8 | 34.7 |
| 15-17 | 46.4 | 62.3 | 49.1 | 40.3 | 42.8 |
| Эрэгтэй | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| үүнээс: 5-9 | 21.5 | 10.8 | 22.4 | 25.1 | 23.2 |
| 10-14 | 32.9 | 28.0 | 28.1 | 35.6 | 36.4 |
| 15-17 | 45.6 | 61.3 | 49.6 | 39.3 | 40.4 |
| Эмэгтэй | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| үүнээс: 5-9 | 23.6 | 13.9 | 27.4 | 27.3 | 21.6 |
| 10-14 | 28.6 | 21.8 | 24.1 | 30.8 | 32.5 |
| 15-17 | 47.7 | 64.3 | 48.5 | 41.9 | 45.9 |

Эхний 2 улирал нь ил задгай газар эсхүл гадаа ажиллахад тохиромжгүй хамгийн хүйтэн цаг агаартай тул хүүхдүүд ажил эрхлэх нь бага байж болох юм. 4-р улиралд ажил эрхэлж буй хүүхдийн тоо хамгийн их байгаа нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх хамгийн боломжтой улирал болохоос гадна өвлийн улиралд бэлтгэх ажил хийдэгтэй холбоотой байж болох юм.

Зураг 8. **Ажил эрхэлсэн хүүхдүүдийн тоо, хүйс, улирлаар**




| | Судалгааны хугацаанд | 1-р улирал | 2-р улирал | 3-р улирал | 4-р улирал |
|---|---|---|---|---|---|
| Хөвгүүд | 41.9 | 27.1 | 35.6 | 53.6 | 52.4 |
| Охид | 26.7 | 14.3 | 22.5 | 32.2 | 39.5 |

Ажил эрхэлж буй нийт хүүхдийн дунд эзлэх хувь улирлаар нэг их өөрчлөгдөхгүй, хэлбэлзэхгүй байгаа бөгөөд хүйсийн ялгаа бага байна. Эхний улиралд ажил эрхэлж буй хүүхдийн тоо хамгийн бага харин бусад улирлынхтай харьцуулахад ажил эрхэлж буй 15-17 насны хүүхдүүдийн дунд эзлэх хувь нь хамгийн өндөр байна (Хүснэгт 8.4а). Ажил эрхэлдэг хүүхдийн тоо харьцангүй цөөхөн 2-р улиралд ч гэсэн 3, 4-р улиралтай харьцуулахад 15-17 насны хүүхэд нь ажил эрхэлж буй нийт хүүхдийн тэн хагаст ч хүрэхгүй байна. Эндээс харахад бусад саруудтай харьцуулахад 4-9-р сарууддад эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх болж буй хүүхдийн тоо, ялангуяа бага насны ийм хүүхдийн тоо нэмэгддэг байна. 3, 4-р улиралд ажил эрхэлж буй бүх насны хүүхдүүдийн насны бүлгийн дунд эзлэх хувь нэлээд жигд, тэнцүү байгааг *Хүснэгт 8.4б*-гээс харж болно.

## 8.4 Ажил эрхэлж буй хүүхдүүд, хот, хөдөөгөөр

### 8.4.1 Хот, хөдөөд ажил эрхэлж буй хүүхдүүд, улирлаар

*Хүснэгт 8.5*-д тухайн үед ажил эрхэлсэн хүүхдүүдийг хот, хөдөө болон улирлаар тооцож харуулав. Нийт ажил эрхэлж буй хөвгүүдийн



10.9 хувь, охидын 8.7 хувь нь хот, суурин газарт байна. Нийт хүүхдийн хувьд 4-р улиралд ажил эрхлэлтийн түвшин хамгийн өндөр байна. Хот,

суурин газарт хамгийн олон хүүхэд 3-р улиралд буюу 4-6-р саруудад ажиллаж, энэ үзүүлэлт 2-р улиралд арай бага байна. *Хүснэгт 8.5*-аас харахад 2-р улиралд ажилласан хүүхдийн тоо Улаанбаатар хотод нэлээд багасчээ. Ажил эрхэлж буй дийлэнх хүүхэд хөдөө орон нутагт байгаа тул нийт ажил эрхэлж буй хүүхдэд хотын хүүхдийн эзлэх хувь өөрчлөгдөн хэлбэлзэж байгаа нь хөдөөгийн хүүхдийн тоо, дүнд эзлэх хувьд нөлөөлөхгүй байна. Хөдөөгийн хүүхдүүдийн дүнд эзлэх хувь, тоо нийт хүүхдүүдийнхтэй адил байгаа юм. Иймд 1-р улиралд ажил эрхэлсэн хүүхэд хөдөөд хамгийн цөөхөн байснаа дараачийн улирлуудад тогтмол нэмэгдсээр 4-р улиралд хамгийн олон болсон байна.

*Хүснэгт 8.5.* ***Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, хот, хөдөө, улирал, хүйсээр***

| Хот, хөдөө/ хүйс | Судалгааны хугацаанд | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд, улирлаар | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 1-р улирал | 2- улирал | 3-р улирал | 4-р улирал |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) |
| Нийт хүүхэд | 68580 | 41404 | 58097 | 85753 | 91946 |
| Хот | 6894 | 5447 | 6804 | 9064 | 6204 |
| Нийслэл хот | 1533 | 1383 | 593 | 2666 | 1505 |
| Аймгийн төв | 5361 | 4064 | 6212 | 6398 | 4699 |
| Хөдөө | 61686 | 35957 | 51292 | 76689 | 85743 |
| Сумын төв | 5841 | 1872 | 5285 | 7301 | 8789 |
| Хөдөө | 55845 | 34085 | 46007 | 69388 | 76954 |
| Эрэгтэй | 41874 | 27086 | 35623 | 53597 | 52437 |
| Хот | 4558 | 3435 | 4753 | 6175 | 3701 |
| Хөдөө | 37316 | 23651 | 30870 | 47422 | 48736 |
| Эмэгтэй | 26706 | 14318 | 22473 | 32156 | 39509 |
| Хот | 2336 | 2012 | 2051 | 2889 | 2503 |
| Хөдөө | 24370 | 12306 | 20422 | 29267 | 37006 |

Хүйсээр задлан харвал ажил эрхэлж буй эмэгтэй хүүхдийн тоо болон дүнд эзлэх хувь дахь хэлбэлзэл нийт хүүхдүүдийн ерөнхий чиглэл хандлагатай адил байхад эрэгтэй хүүхдүүдийн хувьд 3-р улиралд хамгийн олон хүүхэд ажил эрхэлсэн байна. 4-р улиралд ажил хийсэн нийт хүүхдүүдийн тоо 3-р улирлынхаас өссөн ч гэсэн хотод ажил эрхэлж буй хөвгүүдийн тоо 4-р улиралд 3-р улирлынхаас эрс багасчээ. *Хүснэгт 8.5*-аас



харахад хөдөөд ажил эрхэлж буй охидын тоо 3, 4-р улирлын хооронд эрс өссөн байна.

### 8.4.2 Хот, хөдөөд ажил эрхэлж буй хүүхдүүд, бүс нутгаар

*Хүснэгт 8.6*-д хот, хөдөөгийн ажил эрхэлж буй хүүхдүүдийн тоог бүс нутгаар, дунд эзлэх хувийг хот, хөдөөгөөр нь *Хүснэгт 8.6а*-д танилцуулж байна.

*Хүснэгт 8.6.* ***Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн тоо, бүс нутаг, хот, хөдөө, хүйсээр***

| Хот, хөдөө/ хүйс | Бүгд | Бүс нутгаар (%) | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Улаанбаатар | Зүүн | Төв | Баруун | Хангай |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) |
| Нийт хүүхэд - | 68580 | 1533 | 3904 | 9858 | 27053 | 26231 |
| Хот | 6894 | 1533 | 518 | 1518 | 1500 | 1825 |
| Хөдөө | 61686 | 0 | 3387 | 8340 | 25554 | 24406 |
| Эрэгтэй - | 41874 | 935 | 2505 | 6231 | 16223 | 15979 |
| Хот | 4558 | 935 | 306 | 1091 | 1103 | 1122 |
| Хөдөө | 37316 | 0 | 2199 | 5140 | 15120 | 14856 |
| Эмэгтэй | 26706 | 598 | 1399 | 3626 | 10830 | 10253 |
| Хот | 2336 | 598 | 212 | 427 | 396 | 703 |
| Хөдөө | 24370 | 0 | 1187 | 3200 | 10434 | 9550 |

Ажил эрхэлж буй нийт хүүхдийн бараг 90.0 хувь нь хөдөөд байгаа бөгөөд бүс нутгаар харахад Баруун, Хангайн бүсэд ажил эрхэлж буй хүүхдүүдийн 93.0-94.5 хувь нь хөдөө орон нутагт байна. Өмнө нь энэ хоёр бүс нутагт ажил эрхэлж буй хүүхдийн тоо хамгийн өндөр байгаа талаар дурьдсан билээ. Зүүн болон Төвийн бүсийн нийт ажил эрхэлж буй хүүхдүүдийн дунд хот, суурин газрын хүүхдүүдийн эзлэх хувь нь Баруун, Хангайн бүстэй харьцуулахад өндөр байна (Хүснэгт 8.6а-г харна уу). *Хүснэгт 8.6б*-гээс харахад ажил эрхэлж буй хот, суурин газрын хүүхдүүдийн 22-оос дээш хувь нь Улаанбаатар, Төв, Баруун, Хангайн бүсэд ногдож байхад Зүүн бүсэд ердөө 7.5 хувь ногдож байна. Ажил эрхэлж буй хөдөөгийн хүүхдүүдийн нэлээд хувь нь Баруун (41.4 хувь) болон Хангайн бүсэд (39,6 хувь) байна. Үлдсэн хэсэг нь Төв (13.5 хувь) ба Зүүн (5.5 хувь) бүсүүдэд тархаж байна. Ажил эрхэлж буй хүүхдүүдийг хүйсээр харахад төстэй дүр зураг ажиглагдаж байна.

*Хүснэгт 8.6а.* ***Тухайн үед ажил эрхэлсэн хот, хөдөөгийн хүүхдүүдийн дүнд эзлэх хувь, бүс нутаг, хүйсээр***

| Хот, хөдөө/хүйс | Нийт | Бүс нутгаар (хувиар) | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Улаанбаатар | Зүүн | Төв | Баруун | Хангай |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) |
| Нийт хүүхэд - | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Хот | 10.1 | 100.0 | 13.3 | 15.4 | 5.5 | 7.0 |
| Хөдөө | 89.9 | 0.0 | 86.7 | 84.6 | 94.5 | 93.0 |
| Эрэгтэй | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Хот | 10.9 | 100.0 | 12.2 | 17.5 | 6.8 | 7.0 |
| Хөдөө | 89.1 | 0.0 | 87.8 | 82.5 | 93.2 | 93.0 |
| Эмэгтэй | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |
| Хот | 8.7 | 100.0 | 15.2 | 11.8 | 3.7 | 6.9 |
| Хөдөө | 91.3 | 0.0 | 84.8 | 88.2 | 96.3 | 93.1 |

*Хүснэгт 8.6б.* ***Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн дүнд эзлэх хувь, бүс нутаг, хот, хөдөө, хүйсээр***

| Хот, хөдөө/хүйс | Нийт | Бүс нутгаар (хувиар) | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Улаанбаатар | Зүүн | Төв | Баруун | Хангай |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) |
| Нийт хүүхэд - | 100.0 | 2.2 | 5.7 | 14.4 | 39.4 | 38.2 |
| Хот | 100.0 | 22.2 | 7.5 | 22.0 | 21.8 | 26.5 |
| Хөдөө | 100.0 | 0.0 | 5.5 | 13.5 | 41.4 | 39.6 |
| Эрэгтэй | 100.0 | 2.2 | 6.0 | 14.9 | 38.7 | 38.2 |
| Хот | 100.0 | 20.5 | 6.7 | 23.9 | 24.2 | 24.6 |
| Хөдөө | 100.0 | 0.0 | 5.9 | 13.8 | 40.5 | 39.8 |
| Эмэгтэй | 100.0 | 2.2 | 5.2 | 13.6 | 40.6 | 38.4 |
| Хот | 100.0 | 25.6 | 9.1 | 18.3 | 17.0 | 30.1 |
| Хөдөө | 100.0 | 0.0 | 4.9 | 13.1 | 42.8 | 39.2 |

Бүлэг 9

# ДҮГНЭЛТ

## 9.1 Нэгдсэн дүгнэлт

Энэ бүлэгт 2002-2003 оны МХХС-гаар гарсан ажил эрхэлсэн буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийн талаарх тоо мэдээг дүгнэн танилцуулж байна. Мэдээллийг (1) нийт ажил эрхэлж буй хүүхэд, эдгээрээс хүүхдийн хөдөлмөр эрхэлж буй хүүхэд, (2) ажил эрхэлж буй хүүхэд, насны бүлэг, хүйс, бүс нутгаар, (3) ажил эрхэлж буй хүүхэд, ажил мэргэжлийн ангилал, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил эрхлэлтийн байдлаар гэж ерөнхийд нь ангилан дүнг нэгтгэн тооцож гаргалаа. Түүнчлэн эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүдийн талаарх зарим мэдээлэл, судалгааны дүгнэлтүүд, хүүхдийн хөдөлмөрийг устгахад чиглэсэн бодлогын зөвлөмжийг тусгав.

## 9.2 Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүд

2002-2003 оны МХХС-гаар хамрагдсан 5-17 насны хүүхдүүдийн тоо болон эдгээр хүүхдүүдийн хэд нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн байгаа (өөрөөр хэлбэл ажил эрхэлж буй) талаар цуглуулсан тоо мэдээг *Хүснэгт 9.1*-д харуулав.

*Хүснэгт 9.1.* ***5-17 насны хүүхдийн тоо болон эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүдийн тухайн үеийн ажил эрхлэлтийн байдал, хот, хөдөөгөөр***

| Насны бүлэг | Нийт | | | Хот | | | Хөдөө | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй | Бүгд | Эрэгтэй | Эмэгтэй |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) | (10) |
| 5-17 насны нийт хүүхдийн тоо | 679049 | 347652 | 331397 | 360750 | 184932 | 175818 | 318299 | 162720 | 155579 |
| 5-9 | 212145 | 109205 | 102940 | 97575 | 50591 | 46984 | 114570 | 58614 | 55956 |
| 10-14 | 294841 | 151999 | 142843 | 167360 | 86365 | 80995 | 127482 | 65634 | 61848 |
| 15-17 | 172063 | 86449 | 85614 | 95816 | 47976 | 47839 | 76247 | 38472 | 37775 |
| 5-17 насны эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийн тоо | 68580 | 41874 | 26706 | 6894 | 4558 | 2336 | 61686 | 37316 | 24370 |
| 5-9 | 15320 | 9005 | 6315 | 560 | 328 | 231 | 14760 | 8676 | 6083 |
| 10-14 | 21407 | 13762 | 7645 | 2662 | 2004 | 659 | 18745 | 11758 | 6987 |
| 15-17 | 31854 | 19107 | 12746 | 3672 | 2226 | 1446 | 28182 | 16882 | 11300 |
| Хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин (%) | 10.10 | 12.04 | 8.06 | 1.91 | 2.46 | 1.33 | 19.39 | 22.93 | 15.66 |

Судалгааны дүнг тархаасан тооцоогоор байгаа нийт 679049 хүүхдийн 68580 нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин 10.1 хувьтай байна. Хот, хөдөөгийн аль алинд нь хөвгүүдийн ажил эрхлэлтийн түвшин (АЭТ) охидынхоос өндөр байна. Хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин хот, хөдөөгөөр үлэмж ялгаатай, хотод 1.9 хувь байхад хөдөөд 19.4 хувьтай байна. Хөдөөд хөвгүүдийн АЭТ 22.9 хувь байгаагаас харахад дөрвөн хөвгүүдийн нэг нь эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ажээ.

*Хүснэгт 9.2.* **Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн тоо, ажил эрхлэлтийн байдал, долоо хоногт ажилласан дундаж цагаар**

| Насны бүлэг/хүйс | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхэд | Сүүлийн 7 хоногт ажил эрхлээгүй ч ажлын байртай | Тухайн үед ажил эрхэлсэн | | | Хөдөлмөр эрхэлсэн хүүхэд (ОУХБ-ын зөвлөмжийн дагуу тооцсоноор) | Долоо хоногт үндсэн ажил мэргэжлээр ажилласан дундаж цаг | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бүгд | Цалин хөлстэй ажил | Хувиараа хөдөлмөр эрхлэгч /өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч | | Цалин хөлстэй ажил | Хувиараа хөдөлмөр эрхлэгч /өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) |
| Нийт хүүхэд - | 68580 | 2851 | 65729 | 706 | 65023 | 38857 | ... | ... |
| үүнээс: 5-9 | 15320 | 687 | 14633 | 0 | 14633 | 14633 | - | 14.8 |
| 10-14 | 21407 | 971 | 20436 | 140 | 20296 | 13393 | 18.4 | 25.4 |
| 15-17 | 31854 | 1194 | 30660 | 566 | 30094 | 10831 | 50.7 | 37.3 |
| Эрэгтэй | 41874 | 1468 | 40406 | 451 | 39955 | 25445 | ... | ... |
| 5-9 | 9005 | 343 | 8662 | 0 | 8662 | 8662 | - | 16.0 |
| 10-14 | 13762 | 459 | 13302 | 140 | 13162 | 9135 | 18.4 | 27.5 |
| 15-17 | 19107 | 665 | 18442 | 311 | 18131 | 7648 | 49.5 | 40.7 |
| Эмэгтэй | 26706 | 1384 | 25323 | 254 | 25068 | 13411 | ... | ... |
| 5-9 | 6315 | 343 | 5971 | 0 | 5971 | 5971 | - | 12.9 |
| 10-14 | 7645 | 511 | 7134 | 0 | 7134 | 4258 | - | 21.6 |
| 15-17 | 12746 | 529 | 12217 | 254 | 11963 | 3182 | 52.5 | 32.1 |

*Хүснэгт 9.2*-оос харахад ажил эрхэлж буй хүүхдийн дийлэнх нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, эсвэл өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч байгаа бөгөөд маш бага хувь нь цалин хөлстэй ажил эрхэлсэн байна. Түүнчлэн зарим хүүхэд урт цагаар ажилладаг мөн бага наснаас ажил эрхэлж эхэлжээ. Нас болон долоо хоногт ажилласан цагт үндэслэн тооцоход ажил эрхэлж буй 68580 хүүхдийн 38857 (56.7 хувь) нь хөдөлмөр эрхэлж байна. 15-17 насны хүүхэд долоо хоногт 43 болон түүнээс дээш цаг ажилласан бол хүүхдийн хөдөлмөрт тооцох жишиг үзүүлэлт байдаг билээ. Гэтэл цалин хөлстэй ажил эрхэлж буй хүүхдүүд 15-17 насанд долоо хоногт 50-иас илүү цаг ажилласан байна. Түүнчлэн 10-14 насанд долоо хоногт хөнгөн ажил хийхэд 14-өөс илүүгүй цагийг зарцуулсан бол хүүхдийн хөдөлмөрт тооцохгүй. Гэвч хувиараа хөдөлмөр эрхэлж буй эсвэл өрхийн бизнест цалин хөлсгүй оролцож буй энэ насны эрэгтэй хүүхэд долоо хоногт 27.5, эмэгтэй хүүхэд 21.6 цагийг зарцуулжээ.

*Хүснэгт 9.3.* ***Өрхөөс гадуур ажил эрхэлсэн хүүхдүүдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгаанаар***

| Насны бүлэг/хүйс | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдүүд | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Ажлын дадлага, туршлагатай болох | Өрхийн орлогод нэмэр болох | Өөрийгөө авч явах, эдийн засгийн хувьд бие даах | Сургуульд сурахад гарах зардлыг олох | Бусад |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) |
| Бүгд (тоо) | 13509 | 3017 | 7452 | 495 | 639 | 1906 |
| Бүгд (%) | 100.0 | 22.3 | 55.2 | 3.7 | 4.7 | 14.1 |
| 5-6 | 100.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 100.0 |
| 7-9 | 100.0 | 5.9 | 59.2 | 0.0 | 0.0 | 34.9 |
| 10-14 | 100.0 | 27.0 | 52.0 | 0.0 | 7.5 | 13.5 |
| 15-17 | 100.0 | 20.6 | 56.7 | 5.6 | 3.5 | 13.5 |
| Эрэгтэй: | 100.0 | 24.2 | 54.5 | 3.4 | 2.7 | 15.2 |
| Эмэгтэй: | 100.0 | 18.6 | 56.5 | 4.2 | 8.7 | 12.0 |

Хүүхдүүдийн ажил хийх болсон шалтгааныг судлахад (Хүснэгт 9.3) 55.2 хувь нь өрхийн орлогод нэмэр болох, 22.3 хувь нь ажлын дадлага, туршлагатай болох зорилгоор гэж хариулсан байна.

*Хүснэгт 9.4.* ***Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхдийн тоо, эдийн засгийн үйл ажиллагааны салбар, ажил эрхлэлтийн байдлаар***

| Насны бүлэг/ хүйс | Тухайн үед ажил эрхэлсэн нийт хүүхэд | Эдийн засгийн үйл ажиллагааны салбар | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ХАА, ан агнуур, ойн аж ахуй | Ашигт малтмал олборлох | Боловсруулах аж үйлдвэр | Барилга | Бөөний болон жижиглэн худалдаа | Зочид буудал, зоогийн газар | Бусад |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) |
| Ажил эрхэлсэн хүүхдийн тоо | 68580 | 62880 | 552 | 701 | 217 | 3148 | 353 | 729 |
| 5-9 | 15320 | 14972 | 42 | 33 | 0 | 272 | 0 | 0 |
| 10-14 | 21407 | 19324 | 265 | 135 | 53 | 1259 | 150 | 221 |
| 15-17 | 31854 | 28584 | 244 | 533 | 163 | 1616 | 203 | 511 |
| %: | | | | | | | | |
| Бүгд | 100.0 | 91.7 | 0.8 | 1.0 | 0.3 | 4.6 | 0.5 | 1.1 |
| Эрэгтэй: | 100.0 | 91.7 | 0.9 | 0.8 | 0.5 | 4.2 | 0.3 | 1.6 |
| Эмэгтэй: | 100.0 | 91.6 | 0.6 | 1.3 | 0.0 | 5.2 | 0.8 | 0.5 |
| Хүүхдийн ажил эрхлэлтийн байдал: | | | | | | | | |
| Нийт хүүхэд: | 68580 | 62880 | 552 | 701 | 217 | 3148 | 353 | 729 |
| Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч | 694 | 0 | 0 | 249 | 163 | 50 | 0 | 232 |
| Иргэний гэрээгээр ажиллагч | 460 | 124 | 36 | 157 | 0 | 0 | 93 | 50 |
| Ажил олгогч | 36 | 36 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хувиараа хөдөлмөр эрхлэгч | 5652 | 5109 | 202 | 18 | 0 | 236 | 0 | 87 |
| Өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогч | 61677 | 57550 | 313 | 277 | 53 | 2862 | 260 | 362 |
| Бусад | 61 | 61 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

Нийт ажил эрхэлсэн хүүхдийн 5.0 хүрэхгүй хувь нь сургуульд сурахад гарах зардлыг олохын тулд ажил эрхэлсэн ба ингэж хариулсан хүүхдийн эзлэх хувь хүйсээр мэдэгдэхүйц ялгаатай байна. Хөвгүүдийн 2.7 хувь нь, охидын 8.7 хувь нь сургуульд сурахад гарах зардлыг олох нь ажил хайх гол шалтгаан байсан гэж хариулжээ.

Ажил эрхэлсэн хүүхдийн дийлэнх буюу 91.7 хувь нь ХАА, ойн аж ахуйн, 4.6 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт ажил эрхэлж байна (Хүснэгт 9.4). Түүнчилэн хүүхдүүд боловсруулах аж үйлдвэр, уул уурхай олборлох аж үйлдвэр, барилга, зочид буудал, зоогийн газарт ажиллаж байна. Хүүхдүүдийг ажил эрхлэлтийн байдлаар судлахад ихэнх хүүхэд өрхийн бизнест цалин хөлсгүй оролцож, түүний дараагаар хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүд орж байна. Хэдийгээр гэрээгээр цалин хөлстэй ажил эрхэлж буй хүүхэд цөөхөн байгаа боловч ажил эрхлэлтийн байдлаар нь авч үзэхэд 3-рт орж байна. Мөн ажил мэргэжлийн ангиллаар ажил эрхэлж буй хүүхдүүдийг тооцоход дийлэнх нь (90.8 хувь) хөдөө аж ахуйн холбогдолтой ажил, 4.1 хувь нь үйлчилгээний болон худалдаа наймааны, 1.6 хувь нь үйлдвэр, худалдааны ажил эрхэлсэн байна (Хүснэгт 9.5).

## 9.3 Хүүхдийн эдийн засгийн бус үйл ажиллагаа

Ихэнх хүүхэд гэрийн ажил буюу эдийн засгийн бус үйл ажиллагаа эрхэлж байна. Судалгаанд хамрагдсан 5-17 насны нийт 679049 хүүхдийн 567414(83.6 хувь) нь гэрийн ажилд тусалдаг байна. Ийм хүүхдүүд сургуульд сурдаг, сурдаггүй, ажил эрхэлдэг (эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн) болон ажил эрхлээгүй байж болно. Олон хүүхэд гэрийн хэд хэдэн ажлыг хийдэг байна.

Хамгийн нийтлэг хийж байгаа гэрийн ажилд хоол цай хийх, аяга таваг угаах, ус авах, түлээ түлш бэлтгэх, хувцас угаах, индүүдэх, гэрийн хэрэгцээт зүйлсийг худалдан авах, дэлгүүр явах зэрэг ажлууд орж байна (Хүснэгт 9.6). Эдгээр ажлын дараагаар хүүхэд асрах, гэрийн тэжээмэл амьтан тэжээх, оёх, нэхэх ажлуудыг арай цөөн хүүхэд хийжээ.

## 9.4 Ажил эрхэлсэн хүүхдийн тоо, бүс нутгаар

Ажил эрхэлсэн хүүхдийн тоо бүс нутгаар ихээхэн хэлбэлзэж байна. Хүүхдийн ажил эрхлэлтийн улсын дундаж түвшин 10.1 хувьтай байгаа бөгөөд бүс нутгаар 0.9-18.6 хувийн хооронд (Улаанбаатар хотод 0.9 хувь, Баруун Бүсэд 18.6 хувь) хэлбэлзэж байна. Хангайн бүсэд хүүхдийн АЭТ мөн харьцангүй өндөр, 15.3 хувьтай байна. Хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин өндөр байгаа энэ хоёр бүсэд анхаарал хандуулах хэрэгтэй болжээ. Ялангуяа Баруун бүсэд 5-9 насны хүүхдийн 16.4 хувь нь ажил эрхэлж байна.

*Хүснэгт 9.5.* ***Хүүхдүүдийн тоо, ажил мэргэжлийн үндсэн ангиллаар***

| Насны бүлэг/ Хүйс | Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлсэн хүүхэд | Ажил мэргэжлийн үндсэн ангилал (тоо) | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Мэргэжилтэн | Инженер, техникийн ажилтан | Бичиг хэргийн туслах ажилтан | Үйлчилгээний ажилтан ба дэлгүүр зах зээл дээр худалдаа эрхлэгч | ХАА, загас агнуурын ажилчин | үйлдвэр, худалдааны ажилтан | Машин, тоног төхөөрөмжийн операторч, угсрагч | Энгийн ажил |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) | (10) |
| Бүгд | 68580 | 208 | 50 | 33 | 2839 | 62237 | 1105 | 239 | 1869 |
| 5-9 | 15320 | 0 | 0 | 0 | 188 | 15057 | 0 | 33 | 42 |
| 10-14 | 21407 | 38 | 50 | 33 | 1100 | 19237 | 401 | 33 | 514 |
| 15-17 | 31854 | 171 | 0 | 0 | 1551 | 27943 | 704 | 173 | 1313 |
| % | | | | | | | | | |
| Бүгд: | 100.0 | 0.3 | 0.1 | 0.0 | 4.1 | 90.8 | 1.6 | 0.3 | 2.7 |
| Эрэгтэй: | 100.0 | 0.5 | 0.1 | 0.1 | 3.6 | 90.9 | 1.7 | 0.3 | 2.8 |
| Эмэгтэй: | 100.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 4.9 | 90.6 | 1.5 | 0.4 | 2.5 |

*Хүснэгт 9.6.* ***Сүүлийн 7 хоногт гэрийн ажил (эдийн засгийн бус үйл ажиллагаа) хийхэд оролцсон хүүхдүүд, хийсэн ажлын төрлөөр***

| Насны бүлэг/хүйс | Гэрийн ажил хийсэн хүүхдийн тоо | Гэрийн ажил ** | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хоол цай хийх, аяга таваг угаах | Гэр орон цэвэрлэх | Хувцас угаах, индүүдэх | Гэрийн жижиг эд ахуйн засвар | Гэрийн хэрэгцээт зүйлсийг худалдан авах | Оёх, нэхэх | Ус авах | Түлээ түлш бэлтгэх | Настай, өвчтэй хүн асрах | Хүүхэд асрах | Гэрийн тэжээмэл амьтан тэжээх. | Олон нийтийн сайн дурын ажилд үнэ хөлсгүй оролцох |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) | (8) | (9) | (10) | (11) | (12) | (13) | (14) |
| Бүгд | 567414 | 433775 | 420379 | 259995 | 33717 | 119818 | 32650 | 300449 | 265133 | 12965 | 46127 | 36513 | 34027 |
| 5-9 | 144782 | 106846 | 97384 | 21729 | 2945 | 16341 | 1802 | 57159 | 58641 | 1878 | 17927 | 7761 | 4328 |
| 10-14 | 262709 | 200809 | 201377 | 128413 | 13471 | 59315 | 14559 | 150267 | 123350 | 5958 | 19523 | 17821 | 18096 |
| 15-17 | 159923 | 126120 | 121618 | 109853 | 17301 | 44161 | 16289 | 93023 | 83143 | 5129 | 8677 | 10931 | 11603 |
| % | | | | | | | | | | | | | |
| Бүгд: | | 76.4 | 74.1 | 45.8 | 5.9 | 21.1 | 5.8 | 53.0 | 46.7 | 2.3 | 8.1 | 6.4 | 6.0 |
| Эрэгтэй: | | 66.9 | 62.5 | 35.7 | 9.1 | 18.3 | 2.1 | 61.8 | 56.3 | 1.8 | 6.5 | 7.6 | 5.9 |
| Эмэгтэй: | | 86.1 | 85.8 | 56.1 | 2.7 | 23.9 | 9.5 | 44.0 | 37.1 | 2.8 | 9.8 | 5.3 | 6.1 |

** Хүүхэд ганц бус хэд хэдэн ажлыг хийсэн байж болно.

*Хүснэгт 9.7.* **Ажил эрхэлсэн хүүхдүүдийн тоо, бүс нутгаар**

| Насны бүлэг/хүйс | Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдийн тоо, бүс нутгаар | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Бүгд | Улаанбаатар | Зүүн | Төв | Баруун | Хангай |
| (1) | (2) | (3) | (4) | (5) | (6) | (7) |
| Нийт хүүхдийн тоо - | 68580 | 1533 | 3904 | 9858 | 27053 | 26231 |
| үүнээс: 5-9 | 15320 | 69 | 440 | 2096 | 8584 | 4130 |
| 10-14 | 21407 | 458 | 1149 | 2703 | 8067 | 9030 |
| 15-17 | 31854 | 1006 | 2315 | 5058 | 10403 | 13072 |
| Хүүхдийн ажил эрхлэлтийн түвшин (%): | | | | | | |
| Нийт - | 10.1 | 0.9 | 7.8 | 7.2 | 18.6 | 15.3 |
| үүнээс: 5-9 | 7.2 | 0.1 | 2.6 | 5.3 | 16.4 | 7.4 |
| 10-14 | 7.3 | 0.6 | 5.6 | 4.4 | 13.8 | 12.5 |
| 15-17 | 18.5 | 2.2 | 18.3 | 14.1 | 30.5 | 30.4 |

## 9.5 Дүгнэлт, бодлогын зөвлөмж

### 9.5.1 2002-2003 оны МХХС-ны дүн

2002-2003 оны МХХС-ны дүнгээс харахад 5-17 насны хүүхдийн дунд эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх явдал нилээд байгаа нь харагдлаа. Сургуульд суралцаж боловсрон, нийгэмд өв тэгш иргэн болохын тулд өөрийгөө хөгжүүлж, өсч бойжих насандаа эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй хүүхдүүдийн олонх нь олон цагаар ажиллаж байна. Тухайн үед ажил эрхэлсэн хүүхдүүдийн 1.1 хувь нь буюу 706 нь (ихэвчлэн 15-17 насных) цалин хөлстэй ажил эрхэлж, харин дийлэнх нь өрхийн бизнест цалин хөлсгүй оролцож байна. 2002-2003 оны МХХС-ны үндсэн дүнг *Хүснэгт 9.2 болон 9.4*-т танилцуулав.

### 9.5.2 2002-2003 оны МХХС-ны сул тал

